

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**



**МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ**

**ТӨСВИЙН БАРИМТ БИЧИГ**

Улаанбаатар хот  
2021 он



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn


2021.09.30 № 4-1/5502

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу хуулийн төслийн үзэл баримтлал, өргөн мэдүүлэх зөвшөөрөл болон холбогдох бусад материалын хамт хүргүүлж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-д заасны дагуу хуулийн төслийг өргөн мэдүүлж өгнө үү.

  
Б.ЖАВХЛАН

9762006184



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn


2021.09.30 № 4-1/5501


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ  
ТАНАА

### Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

  
Б.ЖАВХЛАН



9762006180



САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@tojha.gov.mn,  
Вэбсайт: www.mojha.gov.mn

2021-09-25 № 1/4173  
танай 2021-09-25 -ны № 4-1/5496 -Т

**Зөвшөөрөл олгох тухай**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай болон дагалдах бусад хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/Факс: (976-51) 26 33 33

2021.09.29 № 01/580

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**САНГИЙН САЙД  
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Танаас 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 4-1/5405 тоот албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүд, түүнд холбогдох мэдээлэлтэй танилцаж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.3-т заасны дагуу зөвшөөрөв.

ДАРГА  Х.БАТЖАРГАЛ

000881


# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## САНГИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлд:

“ХҮ.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүд

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## **МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ТОВЬЁГ**

### **1.МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

1.1. Монгол улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

1.2. Монгол улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

1.3. Монгол улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга

1.4 Монгол улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төсөл

### **2.МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

2.1. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

2.2. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

2.3. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн хавсралт

2.3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт

2.3.2. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт

2.3.3. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх “барих-шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт

2.3.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2022 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг

2.4. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

2.5. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүд

### **3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

3.1. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

3.2. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл

3.3. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хуулийн төслийн танилцуулга

#### **4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

4.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал

4.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл

4.3.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга

#### **5. ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

4.1.Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал


4.2.Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл

4.3.Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулга


4.4.Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг дагалдан гарах хуулийн төслүүд

#### **6. ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД**





**1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ  
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ  
ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**





**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага**

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийг сэргээх, иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээг шат дараалан авч хэрэгжүүлсэн төдийгүй халдварын эрсдэлийг цаг алдалгүй бууруулж, зорилтот бүлгийн хүн амыг бүрэн, нийт хүн амын 65.5 хувийг вакцинжуулаад байна.

Үүний үр дүнд 2021 оны эхний хагас жилд эдийн засаг 6.3 хувиар өсч, 2021 оны жилийн эцэст 6.5 хувь, 2022 онд 5.0 хувьд хүрч цаашид өсөлт тогтворжихоор төсөөлж байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангахад чиглүүлж, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийг төрөлжүүлж, дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд эдийн засгийг сэргээх бодлого, төсвийн шинэчлэлийг 2022 онд хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах нөхцөл үүсэж байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлах тухай нэг зүйлтэй байна.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл дэх эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тооцож, эдийн засгийг эрчимжүүлэх төсөв, санхүүгийн шинэчлэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхээс гадна эдийн засгийг тэлэх том төслүүдийг эхлүүлэх боломж бүрдэх юм.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

--- оОо ---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ... -ны өдөр

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ  
МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**"1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2022 он	2023 он	2024 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.0	5.0	6.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.7	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	15,771.7	17,168.9	18,880.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	33.7	33.0	32.2
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	18,158.8	19,040.7	20,523.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	38.8	36.6	35.0
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,410.5	881.9	1,483.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.2	1.7	2.5
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,387.1	-1,871.9	-1,643.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-5.1	-3.6	-2.8
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,116.1	5,569.3	6,124.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	10.9	10.7	10.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	31,439.4	32,727.2	34,839.6

	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	67.2	62.9	59.4
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	490.4	530.0	569.6
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.0	1.0	1.0

Гарын үсэг

## **МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг баталсан.

Дэлхий нийтийг хамарсан коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал улс орнуудын эдийн засаг, иргэдийн эрүүл мэндэд үлэмж хохирол учруулсаар байна. Гэсэн хэдий ч улс орнууд цар тахлын эсрэг вакцинжуулалт эхэлсэнтэй холбогдуулан “Шинэ хэвийн байдал”-д дасан зохицох байдлаар хөл хориог сулруулж эхэлснээр эдийн засаг эргэн сэргэж байна. Монгол Улсын Засгийн газраас халдварын эрсдэлийг бууруулах боломжит бүхий л арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлж ирсний дотор зорилтот бүлгийн хүн амыг бүрэн, нийт хүн амын 65.5 хувийг вакцинжуулаад байна.

Үүний үр дүнд 2021 оны эхний хагас жилд эдийн засаг 6.3 хувиар өсөж, 2021 оны жилийн эцэст 6.5 хувь, 2022 онд 5.0 хувьд хүрч цаашид өсөлт тогтворжихоор төсөөлж байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангахад чиглүүлж, хөдөлмөр эрхлэлт, бүтээмжийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийг төрөлжүүлж, дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг тогтворжуулах төсөв, санхүүгийн шинэчлэлийн бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Дээрх эдийн засгийн өсөлт, сэргэлтийн бодлогууд, төсвийн шинэчлэлүүдийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-д заасан эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, үндэслэл шаардлагын дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

--- оОо ---



## **ДАГАЛДАХ ХУУЛИУД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэг:

“59.7.Энэ хуулийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 10 хувийг, 59.1.5-д заасан эх үүсвэрээс бүрдсэн орлогын 70 хувийг тус тус тухайн эх үүсвэрийн 10 ба түүнээс дээш хувийг бүрдүүлэх аймагт хувь тэнцүүлж хуваарилна.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.55 дахь заалт:

“4.1.55.Ирээдүйн өв сангийн төсөв” гэж Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу бүрдүүлж, Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрт мөнгөн хуримтлал үүсгэж, хүүхдийн нэрийн дансанд байршуулах зорилгоор тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг;”

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.6, 8.8, 8.9 дэх хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “, Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэсний өмнө “Ирээдүй өв сангийн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2 дахь заалтын “30” гэснийг “50” гэж, 60 дугаар зүйлийн 60.10 дахь хэсгийн “, 60.5” гэснийг “60.6” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.3 дахь заалтын “60.2.6”, “60.7” гэснийг, 60 дугаар зүйлийн 60.9 дэх хэсгийн “, 60.7” гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.6 дахь хэсэг, 59.1.1, 59.3.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.5, 60.7, 60.8 дахь хэсэг, 60.2.2, 60.2.6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



ГАРЫН ҮСЭГ

## ТАНИЛЦУУЛГА

*Төсвийн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай*

### **Ирээдүйн өв сангийн төсөвтэй холбогдуулан:**

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ гэж заасан болно. Түүнчлэн, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “АЛСЫН ХАРАА-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход шаардагдах тогтолцоог бүрдүүлнэ гэжээ.

Энэ хүрээнд байгалийн баялгаас олох орлогын хүртээмжийг нэмэгдүүлж, улс орны ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай, мэдлэг боловсролтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Ирээдүйн өв сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг арилжааны банканд дахь хүүхдийн нэрийн дансанд байршуулахаар төлөвлөлөө.

Ингэснээр Монгол Улсын хүүхэд бүр байгалийн баялгаар баталгаажсан нэрийн дансны хуримтлалтай болж, хадгалах, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас суралцахаас гадна 18 нас хүрээд өөрийн хуримтлалаар боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Түүнчлэн, цар тахлын нөлөө бүрэн арилаагүй шилжилтийн хугацаанд хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн хүсэлтээр хүүхдийн нэрийн дансанд сар бүр төвлөрөх мөнгөн хадгаламжийг бэлнээр авах боломжийг олгоно. Тухайлбал, 2022 оны төсвийн жилд, 1 дүгээр сарын 1-ээс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл 100 хувиар, 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оныг дуустал хугацаанд 50 хувиар олгоно.

### **Орон нутгийн хөгжлийн сантай холбогдуулан:**

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, төвлөрлийг сааруулах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлж иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх арга хэрэгсэл юм. ОНХС-ийн орлогын шилжүүлэг нь Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, 60 дугаар зүйлд үндэслэн зохицуулагддаг.

Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн чуулганаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (МУЗЗНДНТУТХ)-ийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтийн нөлөөгөөр орон нутгийн төсвийн харилцаа, цаашлаад ОНХС-ийн зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлага үүсээд байна.


Иймд ОНХС-ийн зохицуулалтад дараах өөрчлөлтүүдийг оруулахаар тусгалаа. Үүнд:

1. ОНХНС нь уул уурхайн баялгийг тэгш хүртээмжтэй хуваарилах замаар бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгддэг. Иймд ОНХС-д төвлөрөх уул уурхайн чанартай эх үүсвэрийн орлогын хувь хэмжээг нэмэгдүүлж харин импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын эх үүсвэрийг хасах зохицуулалтыг хийлээ.

2. Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аймагт байгаль орчны нөхөн сэргээлт хийж иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тодорхой хэсгийг тухайн эх үүсвэрийг бүрдүүлж байгаа аймгуудад нэмэлтээр тус тус хуваарилахаар өөрчлөлт оруулж байна.

3. Шинэчлэн батлагдсан МУЗЗНДНТУТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “ОНХНС-с тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилна” гэж тусгасанд нийцүүлж Төсвийн тухай хуульд заасан үндсэн 3 итгэлцүүрээр хуваарилж, “орон нутгийн татварын идэвх санаачилга” гэсэн итгэлцүүрийг хасах зохицуулалт хийлээ.

4. Түүнчлэн МУЗЗНДНТУТХ-г дагаж Төсвийн тухай хуульд зааснаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийг аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогод тооцох болсноор аймгийн орлогын эх үүсвэр тодорхой хэмжээгээр нэмэгдсэн. Иймд аймгийн ОНХС-с сумдын ОНХС-д хийгдэх шилжүүлгийн суурь дүнг 30 хувиас 50 хувь болгон нэмэгдүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.



**2.МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



## МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

#### Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

#### Практик шаардлага

Монгол Улс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд дасан зохицож “Хөдөлмөр-Бүтээмж-Өсөлт”-д чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлж эдийн засгаа сэргээх шаардлагатай байна.

Төсвийн бодлогын хүрээнд эдийн засгийн сэргэлт, өсөлтийг эрчимжүүлэх, томоохон төсөл хөтөлбөрийн бүтээн байгуулалтыг дэмжих, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хөнгөвчлөх, төрийн өмчийн хөрөнгийн өгөөжийг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах, төрийн хяналт шалгалт, хүнд суртлыг багасгахад чиглэсэн төрийн цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх зэрэг шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх замаар төсвийн орлогыг бүрэн дайчилна.

Түүнчлэн, хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, иргэнээ дагасан, үр дүн, чанарт суурилсан төсвийн хуваарилалт-санхүүжилтийн тогтолцоонд шилжиж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлж, төр худалдан авдаг тогтолцоог нэвтрүүлэх, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх замаар нийслэлийн автозамын түгжрэлийг бууруулах зэргээр төсвийн урсгал зардлын үр ашиг, үр дүнг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

### Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт орлого, зарцуулах хэмжээ, хөрөнгө ба өрийн удирдлага, улс болон орон нутгийн төсөв хоорондын татаас, шилжүүлэг болон бусад зохицуулалттай холбогдсон харилцааг тусгасан 4 бүлэг, 21 зүйл, 4 хавсралттай байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, хуулийн зорилт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Монгол Улсын 2022 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага, Монгол Улсын төсөвт 2022 оны төсвийн жилд ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээ, төсвийн ерөнхийлөн захирагчдын Монгол Улсын төсөвт 2022 онд эргэн төлөх төлбөр, 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын зарцуулах төсөв, 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгох санхүүжилт, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын зардлын хэмжээ, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөлд олгох эргэн төлөлтийн дүн, Төсвийн тогтворжуулалтын санд 2022 оны төсвийн жилд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2022 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ, Засгийн газрын 2022 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээ, Засгийн газраас Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, "Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т нийцүүлэн хэрэгжүүлэх өрийн зохицуулалтын үйл ажиллагаа;

Гуравдугаар бүлэгт орон нутгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээ;

Дөрөвдүгээр бүлэгт төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт, Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 оны төсвийн жилд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт, мөн олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс сумын Орон нутгийн хөгжлийн санд 2022 онд олгох урамшуулал хүлээн авах аймаг, сумдын жагсаалтыг тус тус хавсралтаар батлах болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар хөдөлмөр эрхлэлт, бүтээмж нэмэгдэж, эдийн засгийн бодит өсөлтийг дунд хугацаанд 5 хувьд хүрч тогтворжуулахаас гадна төсвийн алдагдлыг үе шаттай бууруулах боломж бүрдэнэ.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд тогтвортой түвшинд хадгалж, эдийн засгийн идэвхжилийг үргэлжлүүлэн дэмжих төслүүдийг хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулж хэрэгжүүлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Гаалийн тухай, Цөмийн энергийн тухай, Төрийн албаны тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Монгол Улсын хилийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Малын индексжүүлсэн даатгалын тухай, Газрын тосны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Ургамал хамгааллын тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай, Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Онцгой албан татварын тухай, Өрийн удирдлагын тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Төсөв батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсөвт 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого, төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээ, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн гүйлгээтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1. Монгол Улсын 2022 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

### МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА БОЛОН ХӨРӨНГӨ, ӨРИЙН УДИРДЛАГА

3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллага доор дурдсан орлого төвлөрүүлнэ:

Д/ д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	185.0 185.0
2	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	120.0 120.0
3	Санхүүгийн зохицуулах хорооны дарга Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	2,709.1 2,709.1
4	Монгол Улсын Ерөнхий сайд	46,342.3



	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	45,500.0 842.3
<b>5</b>	<b>Монгол Улсын Шадар сайд</b> Мэргэжлийн хяналтын ерөнхий газар Замын-Үүд чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>20,376.0</b> 2,000.0 5,576.0 12,800.0
<b>6</b>	<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>8,157.6</b> 8,157.6
<b>7</b>	<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>419.2</b> 419.2
<b>8</b>	<b>Гадаад харилцааны сайд</b> Дипломат төлөөлөгчийн газрууд	<b>10,500.0</b> 10,500.0
<b>9</b>	<b>Сангийн сайд</b> Татварын ерөнхий газар үүнээс: Төсвийн тогтворжуулалтын санд Гаалийн ерөнхий газар Сангийн яам Гадаад тусламжийн орлогоос санхүүжих Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>9,082,565.4</b> 4,353,084.5 643,389.3 4,250,512.0 176,212.3 298,519.4 4,237.1
<b>10</b>	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b> Улсын бүртгэлийн ерөнхий газар Цагдаагийн ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>52,335.0</b> 23,800.0 5,000.0 1,344.4 22,190.6
<b>11</b>	<b>Батлан хамгаалахын сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>39,671.9</b> 39,671.9
<b>12</b>	<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>5,631.7</b> 5,631.7
<b>13</b>	<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b> Иргэний нисэхийн ерөнхий газар Зам, тээврийн хөгжлийн яам Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>175,230.0</b> 150,000.0 230.0 25,000.0
<b>14</b>	<b>Барилга, хот байгуулалтын сайд</b> Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>2,300.0</b> 2,100.0 200.0
<b>15</b>	<b>Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b> Ашигт малтмал, газрын тосны газар Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>355,755.0</b> 354,050.0 1,705.0
<b>16</b>	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>63,305.5</b> 63,305.5
<b>17</b>	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b> Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>55,528.2</b> 605.6 798.4 54,124.2

<b>18</b>	<b>Эрүүл мэндийн сайд</b> Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>4,867.2</b> 4,867.2
-----------	---	---------------------------

**4 дүгээр зүйл.** Монгол Улсын төсөвт 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого 9,406,608.4 сая төгрөг байна

**5 дугаар зүйл.** Монгол Улсын төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

<b>Д/д</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>	<b>Дүн /сая төгрөгөөр/</b>
<b>1</b>	<b>Сангийн сайд</b> Үүнээс: Орон нутгаас төлөх	<b>316,025.7</b> 102,037.5
<b>2</b>	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>20,600.7</b>
<b>3</b>	<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b>	<b>30,000.0</b>
<b>4</b>	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>51,043.8</b>

**6 дугаар зүйл.** Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан төсөв зарцуулна:

6.1. Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах зардал доор дурдсан хэмжээтэй байна:

<b>Д/д</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>	<b>Дүн /сая төгрөгөөр/</b>
<b>1</b>	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>21,928.0</b> 21,515.3 412.7
<b>2</b>	<b>Монгол Улсын Их Хурлын дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>63,755.2</b> 61,640.7 2,114.5
<b>3</b>	<b>Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга</b> Урсгал зардал	<b>2,826.8</b> 2,826.8
<b>4</b>	<b>Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч</b> Урсгал зардал	<b>9,570.4</b> 9,570.4
<b>5</b>	<b>Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>79,515.8</b> 77,515.8 2,000.0
<b>6</b>	<b>Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга</b> Урсгал зардал	<b>1,270.9</b> 1,270.9
<b>7</b>	<b>Улсын ерөнхий прокурор</b> Урсгал зардал Хөрөнгийн зардал	<b>62,818.6</b> 56,599.1 6,219.5
<b>8</b>	<b>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга</b>	<b>9,730.1</b>

	Урсгал зардал	9,730.1
<b>9</b>	<b>Монгол Улсын Ерөнхий аудитор</b>	<b>26,187.4</b>
	Урсгал зардал	24,661.3
	Хөрөнгийн зардал	1,526.1
<b>10</b>	<b>Авлигатай тэмцэх газрын дарга</b>	<b>34,024.7</b>
	Урсгал зардал	32,731.7
	Хөрөнгийн зардал	1,293.0
<b>11</b>	<b>Санхүүгийн зохицуулах хорооны дарга</b>	<b>6,607.7</b>
	Урсгал зардал	6,607.7
<b>12</b>	<b>Төрийн албаны зөвлөлийн дарга</b>	<b>2,595.5</b>
	Урсгал зардал	2,595.5
<b>13</b>	<b>Үндэсний статистикийн хорооны дарга</b>	<b>17,842.2</b>
	Урсгал зардал	15,644.0
	Хөрөнгийн зардал	2,198.2
<b>14</b>	<b>Сонгуулийн ерөнхий хорооны дарга</b>	<b>9,044.9</b>
	Урсгал зардал	9,044.9
<b>15</b>	<b>Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга</b>	<b>15,348.2</b>
	Урсгал зардал	15,348.2
<b>16</b>	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>292,418.0</b>
	Урсгал зардал	182,586.2
	Хөрөнгийн зардал	109,831.8
<b>17</b>	<b>Монгол Улсын Шадар сайд</b>	<b>201,694.6</b>
	Урсгал зардал	173,869.5
	Хөрөнгийн зардал	27,825.1
<b>18</b>	<b>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга</b>	<b>123,866.7</b>
	Урсгал зардал	72,991.9
	Хөрөнгийн зардал	50,874.7
<b>19</b>	<b>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд</b>	<b>159,236.1</b>
	Урсгал зардал	129,339.6
	Хөрөнгийн зардал	29,896.5
<b>20</b>	<b>Гадаад харилцааны сайд</b>	<b>121,773.8</b>
	Урсгал зардал	113,373.8
	Хөрөнгийн зардал	8,400.0
<b>21</b>	<b>Сангийн сайд</b>	<b>4,027,486.3</b>
	Урсгал зардал	1,921,974.9
	үүнээс: Зээлийн хүүгийн төлбөрт	959,309.9
	Хөрөнгийн зардал	422,992.0
	Гадаад зээл, тусламжаас санхүүжих зардал	1,682,519.4
<b>22</b>	<b>Хууль зүй, дотоод хэргийн сайд</b>	<b>706,925.3</b>
	Урсгал зардал	640,729.2
	Хөрөнгийн зардал	66,196.1
<b>23</b>	<b>Зам, тээврийн хөгжлийн сайд</b>	<b>464,090.6</b>
	Урсгал зардал	14,321.5
	Хөрөнгийн зардал	449,769.1
<b>24</b>	<b>Батлан хамгаалахын сайд</b>	<b>295,701.2</b>

	Урсгал зардал	281,648.0
	Хөрөнгийн зардал	14,053.2
<b>25</b>	<b>Боловсрол, шинжлэх ухааны сайд</b>	<b>2,315,811.6</b>
	Урсгал зардал	1,825,948.8
	Хөрөнгийн зардал	489,862.8
<b>26</b>	<b>Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд</b>	<b>48,193.7</b>
	Урсгал зардал	12,734.9
	Хөрөнгийн зардал	35,458.8
<b>27</b>	<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд</b>	<b>235,405.9</b>
	Урсгал зардал	164,080.2
	Хөрөнгийн зардал	71,325.7
<b>28</b>	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>1,180,877.7</b>
	Урсгал зардал	1,123,249.2
	Хөрөнгийн зардал	57,628.5
<b>29</b>	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>1,029,648.8</b>
	Урсгал зардал	904,365.0
	Хөрөнгийн зардал	125,283.8
<b>30</b>	<b>Эрчим хүчний сайд</b>	<b>193,036.4</b>
	Урсгал зардал	74,010.6
	Хөрөнгийн зардал	119,025.8
<b>31</b>	<b>Барилга, хот байгуулалтын сайд</b>	<b>368,258.2</b>
	Урсгал зардал	21,908.1
	Хөрөнгийн зардал	346,350.1
<b>32</b>	<b>Соёлын сайд</b>	<b>263,350.2</b>
	Урсгал зардал	114,964.8
	Хөрөнгийн зардал	148,385.4
<b>33</b>	<b>Хөгжлийн сайд</b>	<b>4,392.4</b>
	Урсгал зардал	4,392.4
<b>34</b>	<b>Цахим хөгжил, харилцаа холбооны сайд</b>	<b>1,862.6</b>
	Урсгал зардал	1,862.6

6.2. Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр доор дурдсан хэмжээтэй санхүүжилт олгоно:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Сангийн сайд	9,280.4
2	Барилга, хот байгуулалтын сайд	5,000.0
3	Боловсрол, шинжлэх ухааны сайд	40,531.4
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	32,758.2
5	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	20,000.0

**7 дугаар зүйл.** Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 12,086,996.3 сая төгрөг байна

**8 дугаар зүйл.** Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг 2,137,000.0 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.

**9 дүгээр зүйл.** "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд 303,600.0 сая төгрөгийн эргэн төлөлт хийнэ.

**10 дугаар зүйл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн тогтворжуулалтын санд 2022 оны төсвийн жилд 643,389.3 сая төгрөгийн хэмжээтэй хөрөнгө хуримтлуулна.

**11 дүгээр зүйл.** Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2022 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 3,099,602.1 сая төгрөг байна.

**12 дугаар зүйл.** Засгийн газрын нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээ 2022 оны төсвийн жилд 5,849,421.3 сая төгрөг байна.

**13 дугаар зүйл.** Засгийн газар "Төсвийн тогтвортой байдлын тухай хууль", "Өрийн удирдлагын тухай хууль" болон "Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг"-т нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ, ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН БОЛОН УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛЭГ

**14 дүгээр зүйл.** 2022 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно:

Д/д	Аймаг	Олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай	20,075.2
2	Баян-Өлгий	14,586.4
3	Баянхонгор	21,548.8
4	Булган	8,572.5
5	Говь-Алтай	19,091.3
6	Дундговь	14,610.3
7	Завхан	17,976.5
8	Өвөрхангай	21,761.2
9	Сүхбаатар	9,101.5

10	Төв	14,046.0
11	Увс	18,795.1
12	Ховд	11,360.9
13	Хөвсгөл	27,137.4
14	Хэнтий	15,787.7
15	Говьсүмбэр	2,277.4
<b>Нийт дүн</b>		<b>236,728.1</b>

**15 дугаар зүйл.** 2022 оны төсвийн жилд орон нутгийн төсвөөс улсын төсөвт доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Аймаг	Төвлөрүүлэх орлогын хэмжээ /сая төгрөгөөр/
1	Дорноговь	3,571.0
2	Дорнод	4,583.6
3	Өмнөговь	258,775.1
4	Сэлэнгэ	2,140.1
5	Дархан-Уул	883.7
6	Улаанбаатар	160,021.4
7	Орхон	84,023.9
<b>Нийт дүн</b>		<b>513,998.7</b>

**16 дугаар зүйл.** 2022 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлага доор дурдсан хэмжээтэй байна:

Д/д	Аймаг	Шилжүүлгийн хэмжээ /сая төгрөгөөр/
1	Архангай үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	8,467.2 780.2
2	Баян-Өлгий үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	13,307.8 404.9
3	Баянхонгор үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	11,196.2 532.9
4	Булган үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	5,866.9 535.2
5	Говь-Алтай үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	9,766.5 411.3
6	Дорноговь үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	10,954.8 300.0
7	Дорнод үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	19,080.9 515.7
8	Дундговь үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	6,541.8 208.8
9	Завхан	8,660.5

	үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	414.2
10	Өвөрхангай үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	10,720.4 521.1
11	Өмнөговь үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	24,510.0 343.1
12	Сүхбаатар үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	7,384.0 481.1
13	Сэлэнгэ үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	8,850.0 560.1
14	Төв үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	8,801.3 592.9
15	Увс үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	10,310.3 435.4
16	Ховд үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	11,603.5 496.6
17	Хөвсгөл үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	13,757.1 921.5
18	Хэнтий үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	8,334.9 579.6
19	Дархан-Уул үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	6,772.1 1,053.5
20	Улаанбаатар үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	31,118.6 176.5
21	Орхон үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	15,894.3 288.8
22	Говьсүмбэр үүнээс: Урсгал зарлага санхүүжүүлэх	1,502.4 67.1
<b>Нийт дүн</b>		<b>253,401.4</b>

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### БУСАД ЗҮЙЛ

**17 дугаар зүйл.** "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"-ийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

**18 дугаар зүйл.** "Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

**19 дүгээр зүйл.** Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт"-ыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

**20 дугаар зүйл.** "Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2022 онд сумын Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулал"-ийг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

**21 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт			2022 оны зорилтот түвшин		
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА</b>					
1	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа</b>				
	1.1	1.1.1	Хариуцлагатай төр, хүртээмжтэй эдийн засгийг бэхжүүлж, үндэсний өв соёлыг хамгаалахад чиглэсэн бодлого, санаачилгыг дэмжиж ажиллах	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	
		1.1.2	Үндэсний эв нэгдэл, аюулгүй байдлыг бэхжүүлж, хөгжилд хөтлөх гадаад бодлого хэрэгжүүлэх	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	
		1.1.3	Нийгмийн хөгжил, ногоон хөгжил, хот, хөдөөгийн хөгжлийн бодлогыг дэмжиж ажиллах	тухай бүрд дэмжиж ажиллах	
	1.2	<b>Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа</b>			
		1.2.1	Дотоод, гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /ширхгээр/		443690
1.2.2		Хэвлэмэл бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх /хувь/		3	
1.2.3		Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх /хувь/		5	
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА</b>					
2	<b>Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих</b>				
	2.1	2.1.1	Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	150-аас доошгүй ажлын өдөр хуралдаж хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	
		2.1.2	Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгах, холбогдох тайлан, мэдээллийг хэлэлцэх, сонсох	12-оос доошгүй удаа хяналт шалгалт хийх, 6-аас доошгүй удаа тайлан хэлэлцэх, 12-оос доошгүй удаа мэдээлэл сонсох	
		2.1.3	Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах	Хуульд заасны дагуу хангагдсан байх	
<b>МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА</b>					
3	<b>Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих</b>				
	3.1	3.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн барагдуулалт	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	
		3.1.2	Бага суудлын хуралдаанаар гомдол шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	
		3.1.3	Дунд, их суудлын хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	
<b>УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ</b>					
4	4.1	<b>Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа</b>			
		4.1.1	Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах эрүүгийн хэргийн тоо	800	
		4.1.2	Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах иргэний хэргийн тоо	1800	
		4.1.3	Хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах захиргааны хэргийн тоо	650	
<b>ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b>					
5	5.1	<b>Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах</b>			
		5.1.1	Хуулийн хугацаанд шийдвэрлэх хэргийн хувь	91	
<b>ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭНИЙ КОМИССЫН ДАРГА</b>					
6	<b>Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих</b>				
	6.1	6.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл	1	
		6.1.2	Хяналт шалгалт хийх, судалгаа явуулах, дүн шинжилгээний тайлан боловсруулах, санал гаргах	Хяналт шалгалт 50, судалгаа 8, дүн шинжилгээ, санал гаргах 200	
		6.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдол шийдвэрлэх	Гомдол шалгаж шийдвэрлэх-900, хууль зүйн зөвлөгөө- 250 цагийн зөвлөгөөг 200 хүнд	
		6.1.4	Хүний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүсэлт тавих, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх	Төлөөлөн нэхэмжлэл 4, шаардлага 40, зөвлөмж 45	
		6.1.5	Хүний эрхийн боловсрол, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	400 цагийн сургалт, 10 000 хүн	
<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>					
7	7.1	<b>Прокурорын хяналт</b>			
		7.1.1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих /хувь/	100	
		7.1.2	Ял эдлүүлэх ажиллагаанд буюу хорих анги, цагдан хорих байрнуудын үйл ажиллагаанд хяналт тавих тоо	7100	
		7.1.3	Улсын хэмжээнд шийдвэрлэсэн зөрчлийн тоо	1500000	
<b>ҮНДСЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА</b>					
8	8.1	<b>Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах</b>			
		8.1.1	Бодлогын зөвлөгөө	90	
		8.1.2	Эрдэм шинжилгээ, судалгаа	150	
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР</b>					
9	9.1	<b>Төрийн аудитын үйлчилгээ</b>			
		9.1.1	Санхүүгийн тайлангийн аудит	6537	
		9.1.2	Гүйцэтгэлийн аудит	118	
		9.1.3	Нийцлийн аудит	56	
<b>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА</b>					
<b>Авлигатай тэмцэх</b>					

10	10.1	10.1.1	Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар хянагдсан хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо /тоогоор/	3700	
		10.1.2	Авлигын эсрэг сургалтад хамрагдах хүний тоо	12000	
		10.1.3	Авлигын эсрэг хуульд заасан үндэслэлийн дагуу хийх судалгаа	3	
		10.1.4	Иргэд, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	98	
		10.1.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх багц ажил арга хэмжээ /тоогоор/	11	
		10.1.6	Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгаа /тоогоор/	8	
<b>САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА</b>					
11	11.1	<b>Санхүүгийн зах зээлийн зохицуулалт</b>			
		11.1.1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /шинээр боловсруулах журмын төсөл/	17	
		11.1.2	Шинээр буюу шинэчлэн батлагдсан хууль тогтоомжуудад нийцүүлэн санхүүгийн салбарт мөрдөх дүрэм, журамд өөрчлөлт оруулах /тоогоор/	34	
		11.1.3	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх /хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагын тоо/	259	
		11.1.4	Мэдээлэх үүрэгтэй этгээдийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох, тохиромжтой этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг нягтлан шалгах, санхүүгийн хориг жагсаалтад хамаарал бүхий этгээдтэй хамааралтай эсэхийг таньж мэдэх, байгууллага тус бүрийн эрсдэлийг үнэлэх, харьцуулах, хяналт шалгалтын нэгдсэн статистик, төлөвийг харах боломжтой хувийн хэргийн мэдээлэл, эрсдэлийн үнэлгээ, шийтгэлийн түүх зэргийг нэг дороос харах боломжтой нэгдсэн цогц программ хангамжийг хөгжүүлэх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	
		11.1.5	Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	28	
		11.1.6	Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, мэргэшлийн эрх олгох сургалт /тоогоор/	34	
<b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА</b>					
12	12.1	<b>"Чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийн үндэсний тогтолцоог бүрдүүлэх" зорилтын хүрээнд</b>			
		12.1.1	Төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтын уялдааг хангах, албан тушаалын давхардлыг арилгах, шинэчлэн батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбогдуулан батлах зөвшөөрөл олгосон албан тушаалын тодорхойлолтод нэмэлт, өөрчлөлт оруулах.	байгууллага-120 албан тушаалын тодорхойлолт-3000	
XIX.1.56	Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хөвсгөл, Мөрөн сум, 5, 6, 12 дугаар баг/	2022	2023	500.0	250.0
XIX.1.57	Сумын шинэ болон хуучин эрүүл мэндийн төвийг холбох хүзүүвч /Архангай, Эрдэнэмандал сум/	2022	2022	200.0	200.0
XIX.1.58	Сумын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламж /Улсын хэмжээнд/	2022	2024	24,120.0	3,000.0
XIX.1.59	Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/	2022	2023	4,692.0	1,000.0
XIX.1.60	Эрт илрүүлэг, оношилгооны төв /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2024	2,800.0	710.0
XIX.1.61	Эрүүл мэндийн төвийн барилга /Булган, Орхон сум/	2022	2023	2,328.6	800.0
XIX.1.62	Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Цогт сум, Баянтоорой тосгон/	2022	2024	2,480.0	150.0
XIX.1.63	Эрүүл мэндийн төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	2023	1,800.0	800.0
XIX.1.64	Эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 20 дугаар хороо, Гачуурт тосгон/	2022	2023	2,829.6	2,000.0
XIX.1.65	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Дорноговь, Даланжаргалан сум/	2022	2022	1,650.0	1,650.0
XIX.1.66	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Завхан, Яруу сум/	2022	2023	1,900.0	900.0
XIX.1.67	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өвөрхангай, Төгрөг сум, 1 дүгээр баг/	2022	2023	1,500.0	600.0
XIX.1.68	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Хөвсгөл, Арбулаг сум/	2022	2024	1,418.0	200.0
XIX.1.69	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Увс, Давст сум/	2022	2023	1,152.2	500.0
XIX.1.70	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 15 ор /Сэлэнгэ, Цагааннуур сум/	2022	2022	513.0	513.0
XIX.1.71	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо/	2022	2023	16,000.0	9,000.0
XIX.1.72	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Батноров сум/	2022	2023	1,400.0	700.0
XIX.1.73	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Галшар сум/	2022	2023	2,000.0	1,000.0
XIX.1.74	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Хэнтий, Дадал сум/	2022	2023	1,400.0	700.0
XIX.1.75	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 15 ор /Өвөрхангай, Бат-Өлзий сум, 5 дугаар баг/	2022	2023	1,500.0	600.0

XIX.1.76	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн "Нөхөн үржихүйн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2023	7,900.0	2,150.0
XIX.1.77	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн "Хүүхдийн зөвлөх поликлиник"-ийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2024	17,300.0	3,900.0
<b>XIX.2</b>	<b>II. Их засвар</b>			<b>16,244.1</b>	<b>6,560.4</b>
	<i>Шилжих</i>			<i>306.4</i>	<i>210.4</i>
XIX.2.1	Аймгийн нэгдсэн эмнэлгийн цахилгаан шат /Увс, Улаангом сум/	2020	2022	228.6	180.7
XIX.2.2	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2020	2022	77.8	29.7
	<i>Шинэ</i>			<i>15,937.7</i>	<i>6,350.0</i>
XIX.2.3	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цахилгаан шатны шинэчлэл /Дорнод, Хэрлэн сум/	2022	2022	100.0	100.0
XIX.2.4	Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2022	2023	2,735.0	2,250.0
XIX.2.5	Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/	2022	2022	1,000.0	1,000.0
XIX.2.6	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төвийн барилгын их засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2024	12,102.7	3,000.0
<b>XIX.3</b>	<b>III. Тоног төхөөрөмж</b>			<b>22,514.6</b>	<b>17,820.4</b>
	<i>Шилжих</i>			<i>3,974.6</i>	<i>1,900.4</i>
XIX.3.1	Геронтологийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/	2020	2022	500.0	150.0
XIX.3.2	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум, 4, 5, 6, 7, 8, 9, Өргөө баг/	2020	2022	398.6	48.6
XIX.3.3	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нярайн шар үздэг багаж, монитор, ЭХО, физик эмчилгээний тоног төхөөрөмж, зүрхний цахилгаан бичлэгийн тоног төхөөрөмж, суурин компьютер /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2021	2022	1,189.0	1,000.0
XIX.3.4	Сумдын эрүүл мэндийн төвийн лаборатори, тоног төхөөрөмж /Хөвсгөл/	2021	2022	787.0	587.0
XIX.3.5	Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/	2020	2022	800.0	14.8
XIX.3.6	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээнд мобайл технологийг нэвтрүүлэх /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Бүрэнтогтох, Тариалан, Түнэл, Цагаан-Үүр, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Шинэ-Идэр, Эрдэнэбулган сум/	2021	2022	300.0	100.0
	<i>Шинэ</i>			<i>18,540.0</i>	<i>15,920.0</i>
XIX.3.7	Алслагдсан сумдын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашин /Өмнөговь, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Ноён, Цогтцэций сум/	2022	2022	1,000.0	1,000.0
XIX.3.8	Дүүргийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2023	1,970.0	900.0
XIX.3.9	Нэгдсэн эмнэлгийн дурангийн тоног төхөөрөмж /Увс, Улаангом сум/	2022	2022	400.0	400.0
XIX.3.10	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/	2022	2022	600.0	600.0
XIX.3.11	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 6, 8, 13, 14, 15, 16, 18, 25, 26 дугаар хороо/	2022	2022	500.0	500.0
XIX.3.12	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-20 дугаар хороо/	2022	2022	500.0	500.0
XIX.3.13	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2022	740.0	740.0
XIX.3.14	Эрт илрүүлэг, оношилгооны тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2022	2022	1,950.0	1,950.0
XIX.3.15	Эрүүл мэндийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Төв/	2022	2023	1,700.0	700.0
XIX.3.16	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2022	2022	3,000.0	3,000.0
XIX.3.17	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий/	2022	2022	115.0	115.0
XIX.3.18	Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Увс, Өмнөговь сум/	2022	2022	150.0	150.0
XIX.3.19	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Баянхонгор/	2022	2023	450.0	300.0
XIX.3.20	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Булган/	2022	2022	500.0	500.0
XIX.3.21	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Дундговь/	2022	2023	900.0	500.0
XIX.3.22	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Завхан/	2022	2022	1,015.0	1,015.0
XIX.3.23	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Хөвсгөл/	2022	2022	400.0	400.0
XIX.3.24	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашин /Өвөрхангай/	2022	2022	500.0	500.0
XIX.3.25	Эрүүл мэндийн түргэн тусламжийн тоноглол бүхий автомашин /Сүхбаатар, Баруун-Урт, Мөнххаан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Онгон сум/	2022	2022	750.0	750.0
XIX.3.26	Эрүүл мэндийн явуулын үзлэгийн автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2022	2022	1,400.0	1,400.0
<b>XX</b>	<b>АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА</b>			<b>1,293.0</b>	<b>1,293.0</b>
<b>XX.1</b>	<b>I. Барилга байгууламж</b>			<b>250.0</b>	<b>250.0</b>

	<i>Шинэ</i>			250.0	250.0
XX.1.1	Авлигатай тэмцэх газрын автогараж, харуулын байрын барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2022	2022	250.0	250.0
<b>XX.3</b>	<b>III. Тоног төхөөрөмж</b>			<b>1,043.0</b>	<b>1,043.0</b>
	<i>Шинэ</i>			1,043.0	1,043.0
XX.3.1	Авлигатай тэмцэх газрын тоног төхөөрөмж, программ хангамж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2022	2022	1,043.0	1,043.0
<b>XXI</b>	<b>ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ</b>			<b>2,000.0</b>	<b>2,000.0</b>
<b>XXI.2</b>	<b>II. Их засвар</b>			<b>1,000.0</b>	<b>1,000.0</b>
	<i>Шинэ</i>			1,000.0	1,000.0
XXI.2.1	Шүүхийн барилгуудын их засвар /Улсын хэмжээнд/	2022	2022	1,000.0	1,000.0
<b>XXI.3</b>	<b>III. Тоног төхөөрөмж</b>			<b>1,000.0</b>	<b>1,000.0</b>
	<i>Шинэ</i>			1,000.0	1,000.0
XXI.3.1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2022	2022	1,000.0	1,000.0
<b>XXII</b>	<b>УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР</b>			<b>14,453.5</b>	<b>6,219.5</b>
<b>XXII.1</b>	<b>I. Барилга байгууламж</b>			<b>12,571.0</b>	<b>4,337.0</b>
	<i>Шилжих</i>			12,571.0	4,337.0
XXII.1.1	Прокурорын газрын барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2021	2023	2,270.0	1,345.7
XXII.1.2	Прокурорын газрын барилга /Увс, Улаангом сум/	2021	2023	2,300.0	937.0
XXII.1.3	Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын конторын барилга /Улсын хэмжээнд/	2021	2022	8,001.0	2,054.3
<b>XXII.2</b>	<b>II. Их засвар</b>			<b>882.5</b>	<b>882.5</b>
	<i>Шинэ</i>			882.5	882.5
XXII.2.1	Улсын ерөнхий Прокурорын газрын харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2022	2022	882.5	882.5
<b>XXII.3</b>	<b>III. Тоног төхөөрөмж</b>			<b>1,000.0</b>	<b>1,000.0</b>
	<i>Шинэ</i>			1,000.0	1,000.0
XXII.3.1	Улсын ерөнхий Прокурорын газрын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2022	2022	1,000.0	1,000.0
<b>XXIII</b>	<b>ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА</b>			<b>2,198.2</b>	<b>2,198.2</b>
<b>XXIII.3</b>	<b>III. Тоног төхөөрөмж</b>			<b>2,198.2</b>	<b>2,198.2</b>
	<i>Шинэ</i>			2,198.2	2,198.2
XXIII.3.1	Үндэсний статистикийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2022	2022	2,198.2	2,198.2
<b>XXIV</b>	<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР</b>			<b>1,526.1</b>	<b>1,526.1</b>
<b>XXIV.3</b>	<b>III. Тоног төхөөрөмж</b>			<b>1,526.1</b>	<b>1,526.1</b>
	<i>Шинэ</i>			1,526.1	1,526.1
XXIV.3.1	Үндэсний аудитын газрын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2022	2022	1,526.1	1,526.1
	<b>НИЙТ</b>			<b>5,943,593.7</b>	<b>2,137,000.0</b>

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2022 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” КОНЦЕССЫН ТӨРЛӨӨР  
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
<b>I</b>	<b>САНГИЙН САЙД</b>			<b>849,837.3</b>	<b>303,600.0</b>
<b>I.1</b>	<b>Төрийн худалдан авах ажиллагааны газар</b>			<b>849,837.3</b>	<b>303,600.0</b>
	<b>Концессын төслийн эргэн төлөлт</b>			<b>849,837.3</b>	<b>303,600.0</b>
<b>I.1.1</b>	<b>I.Барилга байгууламж</b>			<b>849,837.3</b>	<b>303,600.0</b>
	<i>Шилжих</i>			<i>747,509.1</i>	<i>253,868.4</i>
I.1.1.1	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл	2020	2022	237,797.2	62,797.2
I.1.1.2	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл	2020	2023	264,089.2	94,478.1
I.1.1.3	Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл	2021	2022	218,982.7	87,593.1
I.1.1.4	Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам	2019	2023	26,640.0	9,000.0
	<i>Шинэ</i>			<i>102,328.2</i>	<i>49,731.6</i>
I.1.1.5	Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл/ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц/	2022	2023	85,525.6	25,000.0
I.1.1.6	Өмнөговь аймгийн төвийг нийслэлтэй холбосон авто замын “Шар тээг”-ийн уулзвараас Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто зам төсөл	2022	2023	102,328.2	22,969.6
I.1.1.7	Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төсөл	2022	2022	1,762.0	1,762.0

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай  
хуулийн 4 дүгээр хавсралт

Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2022 онд сумдын орон нутгийн  
хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг

/мянган төгрөг/

Д/д	Аймаг, сум	Урамшуулал
1	<b>Архангай</b>	<b>608,213.4</b>
	1 Батцэнгэл сум	24,042.3
	2 Булган сум	23,456.8
	3 Жаргалант сум	30,535.8
	4 Өгийнуур сум	30,049.4
	5 Өндөр-Улаан сум	51,973.0
	6 Тариат сум	35,772.8
	7 Төвшрүүлэх сум	17,464.2
	8 Хайрхан сум	37,364.2
	9 Хангай сум	44,486.8
	10 Хашаат сум	24,904.0
	11 Хотонт сум	20,275.5
	12 Цахир сум	43,361.9
	13 Цэнхэр сум	35,009.3
	14 Цэцэрлэг сум	40,941.3
	15 Чулуут сум	25,382.7
	16 Эрдэнэбулган сум	83,458.4
17 Эрдэнэмандал сум	39,734.9	
2	<b>Баян-Өлгий</b>	<b>79,809.1</b>
	1 Алтай сум	43,848.7
	2 Сагсай сум	35960.4335
3	<b>Баянхонгор</b>	<b>704,249.4</b>
	1 Баацагаан сум	24,508.3
	2 Баянбулаг сум	25,243.4
	3 Баянговь сум	23,543.2
	4 Баянлиг сум	59,445.6
	5 Баян-Овоо сум	17,618.6
	6 Баян-Өндөр сум	46,600.5
	7 Баянхонгор сум	109,189.4
	8 Баянцагаан сум	46,095.5
	9 Богд сум	21,933.9
	10 Бөмбөгөр сум	26,490.5
	11 Бууцагаан сум	42,619.7
12 Галуут сум	33,015.2	

	13	Гурванбулаг сум	38,339.2
	14	Жаргалант сум	31,445.9
	15	Жинст сум	23,806.7
	16	Заг сум	22,860.1
	17	Өлзийт сум	22,830.7
	18	Хүрээмарал сум	19,100.6
	19	Шинэжинст сум	43,255.3
	20	Эрдэнэцогт сум	26,307.1
		<b>Булган</b>	<b>225,504.0</b>
4	1	Баяннуур сум	9,616.8
	2	Бугат сум	11,047.4
	3	Гурванбулаг сум	20,001.7
	4	Дашинчилэн сум	15,754.3
	5	Могод сум	14,755.9
	6	Орхон сум	15,070.0
	7	Рашаант сум	17,157.0
	8	Сайхан сум	15,500.5
	9	Сэлэнгэ сум	21,470.1
	10	Тэшиг сум	32,344.8
	11	Хангал сум	18,672.9
		12	Хутаг-Өндөр сум
		<b>Говь-Алтай</b>	<b>211,162.6</b>
5	1	Баян-Уул сум	22,093.1
	2	Жаргалан сум	11,881.4
	3	Тайшир сум	14,879.4
	4	Төгрөг сум	26,185.5
	5	Хөхморьт сум	26,532.8
	6	Цогт сум	37,555.4
	7	Чандмань сум	18,446.1
	8	Шарга сум	15,961.4
		9	Эрдэнэ сум
		<b>Дорноговь</b>	<b>289,763.1</b>
6	1	Айраг сум	23,415.1
	2	Дэлгэрэх сум	12,938.6
	3	Замын-Үүд	118,537.2
	4	Иххэт сум	14,587.8
	5	Мандах сум	20,780.9
	6	Өргөн сум	15,297.1
	7	Сайншанд сум	68,158.7
		8	Хөвсгөл сум
		<b>Дорнод</b>	<b>302,546.2</b>
7	1	Баянтүмэн сум	16,199.7
	2	Баян-Уул сум	49,631.5
	3	Булган сум	15,412.0
	4	Гурванзагал сум	17,445.6
	5	Сэргэлэн сум	13,177.6
	6	Хэрлэн сум	108,235.3
	7	Цагаан-Овоо сум	27,409.2
		8	Чойбалсан сум



	9 Чулуунхороот сум	28,422.0
8	<b>Дундговь</b>	<b>237,402.1</b>
	1 Адаацаг сум	15,837.5
	2 Баянжаргалан сум	9,382.2
	3 Говь-Угтаал сум	9,394.7
	4 Гурвансайхан сум	20,798.2
	5 Дэрэн сум	12,918.2
	6 Луус сум	8,805.9
	7 Өлзийт сум	24,734.5
	8 Өндөршил сум	13,216.0
	9 Сайнцагаан сум	56,763.0
	10 Сайхан-Овоо сум	18,279.1
	11 Цагаандэлгэр сум	14,132.7
	12 Эрдэнэдалай сум	33,140.1
9	<b>Завхан</b>	<b>127,961.3</b>
	1 Асгат сум	6,223.5
	2 Баянхайрхан сум	14,322.2
	3 Дөрвөлжин сум	22,228.5
	4 Идэр сум	13,646.8
	5 Нөмрөг сум	12,722.7
	6 Отгон сум	19,373.7
	7 Цагаанхайрхан сум	7,630.4
	8 Цагаанчулуут сум	8,108.2
	9 Цэцэн-Уул сум	12,589.5
10 Шилүүстэй сум	11,115.8	
10	<b>Өвөрхангай</b>	<b>902,999.4</b>
	1 Арвайхээр сум	117,227.5
	2 Бат-Өлзий сум	73,119.9
	3 Баянгол сум	35,047.4
	4 Баян-Өндөр сум	47,195.3
	5 Баруунбаян-Улаан сум	47,871.8
	6 Богд сум	111,925.1
	7 Бүрд сум	19,158.9
	8 Гучин-Ус сум	40,447.8
	9 Есөнзүйл сум	27,077.1
	10 Зүүнбаян-Улаан сум	35,580.8
	11 Нарийнтээл сум	35,900.3
	12 Өлзийт сум	15,506.8
	13 Сант сум	31,583.8
	14 Тарагт сум	33,962.6
	15 Төгрөг сум	37,926.6
	16 Уянга сум	35,880.4
	17 Хайрхандулаан сум	43,090.2
	18 Хархорин сум	71,418.3
19 Хужирт сум	43,078.7	
11	<b>Өмнөговь</b>	<b>282,397.5</b>
	1 Баяндалай сум	25,947.8
	2 Булган сум	14,501.0

	3	Гурвантэс сум	60,433.5
	4	Манлай сум	25,827.7
	5	Сэврэй сум	29,771.3
	6	Ханбогд сум	71,415.2
	7	Хүрмэн сум	17,803.0
	8	Цогтцэций сум	36,697.9
12	<b>Сүхбаатар</b>		<b>200,961.4</b>
	1	Асгат сум	17,117.8
	2	Баяндэлгэр сум	32,627.2
	3	Мөнххаан сум	56,576.9
	4	Уулбаян сум	33,086.3
	5	Эрдэнэцагаан сум	61,553.1
13	<b>Сэлэнгэ</b>		<b>389,995.4</b>
	1	Алтанбулаг сум	19,942.1
	2	Баруунбүрэн сум	21,599.4
	3	Ерөө сум	44,380.2
	4	Жавхлант сум	10,720.7
	5	Мандал сум	198,027.1
	6	Орхонтуул сум	25,070.8
	7	Хушаат сум	11,733.2
	8	Хүдэр сум	27,996.2
	9	Цагааннуур сум	30,525.8
14	<b>Төв</b>		<b>426,086.8</b>
	1	Алтанбулаг сум	16,469.6
	2	Аргалант сум	6,892.9
	3	Архуст сум	6,133.2
	4	Баян сум	16,351.3
	5	Баяндэлгэр сум	7,688.0
	6	Баянжаргалан сум	10,923.5
	7	Баянхангай сум	6,500.1
	8	Баянцагаан сум	19,079.5
	9	Баянцогт сум	13,356.9
	10	Баянчандмань сум	15,482.4
	11	Бүрэн сум	28,114.2
	12	Дэлгэрхаан сум	13,135.3
	13	Жаргалант сум	26,057.4
	14	Заамар сум	27,794.5
	15	Зуунмод сум	34,771.7
	16	Мөнгөнморьт сум	29,699.0
	17	Өндөрширээт сум	20,255.2
	18	Сүмбэр сум	7,470.8
	19	Сэргэлэн сум	10,064.6
	20	Угтаалцайдам сум	12,616.0
	21	Цээл сум	20,901.4
	22	Эрдэнэ сум	27,828.8
23	Эрдэнэсант сум	48,500.4	
15	<b>Увс</b>		<b>115,193.6</b>
	1	Өндөрхангай сум	36,772.0
	2	Түргэн сум	11,801.6

	3	Ховд сум	21,290.7
	4	Хяргас сум	22,203.6
	5	Цагаанхайрхан сум	23,125.8
		<b>Ховд</b>	<b>298,953.7</b>
16	1	Булган сум	104,194.5
	2	Буянт сум	18,184.4
	3	Дуут сум	11,935.5
	4	Дөргөн сум	21,099.6
	5	Зэрэг сум	23,443.3
	6	Үенч сум	46,280.2
	7	Жаргалант сум	73,816.2
		<b>Хөвсгөл</b>	<b>542,538.5</b>
17	1	Алаг-Эрдэнэ сум	35,744.7
	2	Баянзүрх сум	30,468.1
	3	Бүрэнтогтох сум	20,789.4
	4	Галт сум	33,580.6
	5	Жаргалант сум	31,745.5
	6	Их-Уул сум	24,224.7
	7	Рашаант сум	21,244.5
	8	Тариалан сум	57,294.2
	9	Төмөрбулаг сум	31,139.0
	10	Түнэл сум	23,237.7
	11	Улаан-Уул сум	50,157.3
	12	Цагаан-Уул сум	43,807.3
	13	Цагаан-Үүр сум	30,943.2
	14	Цэцэрлэг сум	39,970.4
	15	Чандмань-Өндөр сум	22,456.9
	16	Шинэ-Идэр сум	18,399.2
	17	Эрдэнэбулган сум	27,335.7
		<b>Хэнтий</b>	<b>434,149.3</b>
18	1	Батноров сум	32,360.9
	2	Батширээт сум	34,709.7
	3	Баян-Адарга сум	15,398.1
	4	Баянмөнх сум	11,485.6
	5	Баян-Овоо сум	19,299.8
	6	Биндэр сум	26,859.8
	7	Бор-Өндөр сум	53,067.8
	8	Галшар сум	22,400.2
	9	Дадал сум	39,959.8
	10	Дархан сум	23,067.2
	11	Жаргалтхаан сум	13,950.1
	12	Мөрөн сум	12,532.6
	13	Норовлин сум	24,120.3
	14	Өмнөдэлгэр сум	37,259.1
	15	Хэрлэн сум	52,207.4
	16	Цэнхэрмандал сум	15,471.1
		<b>Дархан-Уул</b>	<b>302,602.8</b>
19	1	Дархан сум	151,743.1

	2 Орхон сум	39,182.9
	3 Хонгор сум	111,676.7
<b>20</b>	<b>Орхон</b>	<b>232,306.7</b>
	1 Баян-Өндөр сум	232,306.7
	<b>Говьсүмбэр</b>	<b>85,094.6</b>
<b>21</b>	1 Баянтал сум	15,113.7
	2 Сүмбэр сум	40,347.8
	3 Шивээговь сум	29,633.0
<b>НИЙТ</b>		<b>6,999,891</b>

МОНГОЛ УЛСЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ

2021 он

## АГУУЛГА

1.	МАКРО ЭДИЙН ЗАСАГ	2
	1.1. Дэлхийн эдийн засаг, гадаад орчин	3
	1.2. Монгол улсын эдийн засаг	3
2.	2022 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГО, ЗОРИЛТ	10
3.	НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	22
	3.1. Нэгдсэн төсвийн 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл	22
	3.2. Нэгдсэн төсвийн 2022 оны үзүүлэлтүүд	22
	3.3. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	22
	3.4. Төсвийн тусгай шаардлагад нийцсэн төсвийн төлөвлөлт	23
4.	ТӨСВИЙН ОРЛОГО	24
	4.1. Монгол Улсын 2021 оны 8 дугаар сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл	24
	4.2. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого	24
	4.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого	24
	4.4. Уул уурхайн салбарын орлого	25
	4.5. Эдийн засаг дахь татварын ачаалал болон татварын орчин	25
	4.6. Татварын орлого	26
	4.7. Татварын бус орлого	30
	4.8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	30
5.	УРСГАЛ ЗАРЛАГА	32
	5.1. 2022 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм	32
	5.2. Эрүүл мэнд	33
	5.3. Боловсрол	34
	5.4. Нийгмийн хамгаалал	37
	5.5. Байгаль орчин	38
	5.6. Хөдөө аж ахуй	38
	5.7. Соёл, нийтийн биеийн тамир	39
	5.8. Бусад	39
6.	ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	47
7.	ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	51
8.	ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ	53
	8.1. Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл	53
	8.2. Төслүүдийг санхүүжүүлэхэд баримтлах зарчим	54
	8.3. Гадаад зээл, тусламжаар 2022 онд санхүүжүүлэх салбар, чиглэл, томоохон төслүүдээр хийгдэх ажлууд	54
9.	ИРЭЭДҮЙН ӨВ САН	59
10.	ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	60
	10.1. Засгийн газрын өр	60
	10.2. Дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, хүрэх үр дүн	63
11.	АРВАН ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ	67
12.	МАКРО ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ	69
	12.1. Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл	69
	12.2. Төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл	69

# 1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ



## 1.1. Дэлхийн эдийн засаг, гадаад орчин


### 1.1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Дэлхийн эдийн засаг 2022 онд 4.9 хувиар өсөх төлөвтэй байна.

ОУВС-гийн төсөөллөөр дэлхийн эдийн засаг 2022 онд 4.9 хувиар өсөх төлөвтэй байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг вакцинжуулалтын явц дэлхийн эдийн засгийн сэргэлтийн хурдыг тодорхойлох гол хүчин зүйл болж байгааг олон улсын байгууллагууд онцолж байна.

Вакцинжуулах үйл явц улс орнуудын хувьд жигд бус байгаа нь вирусын мутацид орсон шинэ хувилбарууд бий болох, улмаар хөл хорионы дэглэмийг сунжруулах, эдийн засгийн өрнөлийг хэвийн горимд эргэн орох хугацааг уртасгах зэрэг эрсдэлийг бий болгож болзошгүй байна.

График № 1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувь




Эх үүсвэр: ОУВС, “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлан 2021.07 сар

Цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийн нөлөөгөөр дэлхийн барааны худалдааны өсөлт энэ онд 8.0 хувьд хүрэх бол 2022 онд 4.0 хувь болох төлөвтэй байгааг Дэлхийн худалдааны байгууллага танилцуулсан<sup>1</sup>.

Дэлхийн томоохон эдийн засаг бүхий АНУ болон БНХАУ-ын эдийн засаг сайжрахаар хүлээгдэж байгаа нь дэлхийн эдийн засгийн төлөвт эергээр нөлөөлж байна. 2021-2022 онд дэлхийн эдийн засаг олон жилийн дунджаас өндөр өсөхөөр байна.

График № 2. Улсуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувь



Эх үүсвэр: ОУВС, “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлан 2021.07 сар

АНУ-ын эдийн засаг 2022 онд 4.9 хувиар өсөхөөр төсөөлөгдөж байна. Вакцинжуулалтын хурд болон АНУ-ын Засгийн газраас ирэх жилүүдэд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дэд бүтэц, нийгмийн хамгааллын багц хөтөлбөрүүдийн<sup>2</sup> хэрэгжилт тус улсын эдийн засгийн сэргэлтэд гол дэмжлэг болох бөгөөд 2022 оны эдийн засгийн өсөлтийг 1.1 нэгж хувиар нэмэгдүүлнэ гэж ОУВС дүгнэж байна. Эдийн засгийн төлөв сайжирсантай холбоотойгоор Холбооны Нөөцийн Банк 9 дүгээр сарын хурлаараа цаашид бондын худалдан авалтын хэмжээг танах төлөвлөгөөтэй байгаагаа мэдэгдээд байна.

БНХАУ-ын эдийн засаг 2022 онд 5.7 хувиар өсөхөөр төсөөлөгдөж байна. Энэ оны 2 дугаар улиралд тус улсын эдийн засаг өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар, өмнөх улирлаас 1.3 хувиар тус тус өсөөд байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж буй гадаад болон дотоод эрэлтийн сэргэлт ирэх онд саармагжиж,

<sup>1</sup> [https://www.wto.org/english/news\\_e/pres21\\_e/pr876\\_e.html](https://www.wto.org/english/news_e/pres21_e/pr876_e.html)

<sup>2</sup> ОУВС-гийн тооцооллоор эдгээр багц арга хэмжээнүүд (American Families Plan болон American Jobs Plan) нийт 4.3 их наяд ам.доллар буюу ДНБ-ий 18 хувьтай тэнцэж байна.

эдийн засгийн өсөлт тогтворжихоор таамаглагдаж байна.



Евро бүсийн эдийн засаг 2022 онд 4.3 хувиар өсөхөөр таамаглагдаж байна. Цар тахлын сөрөг нөлөөг бууруулах бодлогын хүрээнд Евро бүсийн орнуудын Засгийн газрууд төсвийн зардлыг нэмэгдүүлж, Европын Төв Банкнаас хасах хүүгийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ 1.85 их наяд еврогийн үнэт цаасны худалдан авалтын хөтөлбөрийн хэрэгжих хугацааг 2022 оны 3 дугаар сар хүртэл сунгаад байна. Европын холбооноос 2026 он хүртэл 800 орчим тэрбум еврогийн бондыг зах зээлд гаргахаар шийдвэрлэсэн нь Евро бүсийн эдийн засагт дэмжлэг болохоор байна.



Япон улсын эдийн засаг 2022 онд 3.0 хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Тус улсын засгийн газраас цар тахлын сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн нийт 234 орчим их наяд иений багц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Япон улсын эдийн засаг энэ оны 2 дугаар улиралд 1.9 хувиар өссөн хэдий ч коронавируст халдвар (КОВИД-19)-ын тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа нь энэ оны 2 дугаар хагаст сэргэхээр хүлээгдэж байсан эдийн засгийн идэвхжил саарах эрсдэлийг бий болгож болзошгүй байна.



ОХУ-ын эдийн засаг 2022 онд 3.1 хувиар өсөхөөр таамаглагдаж байна. Тус улсын төв банкнаас энэ онд бодлогын хүүг 5 удаа нэмэгдүүлж 6.75 хувьд хүргээд байна. Энэ онд дэлхийн эдийн засгийн сэргэлттэй холбоотой газрын тосны үнийн өсөлт ОХУ-ын эдийн засгийг дэмжихээр байгаа бол ирэх онд цар тахлын нөлөө саармагжиж, аж үйлдвэрийн үнийн тогтворжилт эдийн засгийг өсөлтөд голлон нөлөөлөхөөр байна.

### Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

**Зэс.** Зэсийн үнэ 2021 оны эхний 8 сард дунджаар 9177 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 48 хувиар өссөн байна. Энэ нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалт эхэлснээр дэлхийн эдийн засгийн үйл ажиллагаа идэвхэжсэнтэй холбоотой. Үнийн төсөөлөл боловсруулдаг шинжээчид зэсийн дундаж үнийг 2022 онд 8915.6 ам.доллар орчимд байхаар төсөөлж байна.

График № 3. Зэсийн үнийн төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмберг

**Алт.** Алтны үнэ 2021 оны эхний 8 сарын байдлаар дунджаар 1803 ам.доллар болж, өмнөх оны дунджаас 2 хувиар өсжээ. 2020 онд 27 хувиар өсөөд байсан алтны үнийн өсөлтийн хурд эрс саарсан нь нийт зах зээлийн тодорхой бус байдал буурч, эдийн засаг сэргэх төлөв ажиглагдаж байгаатай холбоотой юм. Шинжээчид дэлхийн зах зээл дээрх алтны дундаж үнийг 2022 онд 1821 ам.доллар орчимд төсөөлж байна.

График № 4. Алтны үнийн төсөөлөл, ам.доллар/трой унц




Эх үүсвэр: Блүүмберг

**Төмрийн хүдэр.** Төмрийн хүдрийн үнэ 2021 оны эхний 8 сарын байдлаар 184 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 68 хувиар өссөн байна. Сүүлийн саруудад үнэ эрчимтэй өсөж байгаа нь БНХАУ-ын гангийн эрэлт өндөр байгаатай холбоотой. БНХАУ нь коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дараах эдийн засгийн өсөлтийг сэргээхийн тулд дэд бүтцэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх бодлого баримталж байна.

Төмрийн хүдрийн үнийн өсөлтийг дагаад нийлүүлэлт мөн эрчимтэй нэмэгдэх төлөвтэй байна. Шинжээчид төмрийн хүдрийн дундаж үнийг 2022 онд буурна гэж төсөөлж байна.



График № 5. Төмрийн хүдрийн үнийн төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмберг

**Нүүрс.** Австралийн сайн чанарын коксжих нүүрсний үнэ 2021 оны эхний 8 сарын байдлаар 152 ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 21 хувиар өссөн байна. Шинжээчид БНХАУ-ын эдийн засаг сэргэж байгаатай холбоотойгоор дунд хугацаанд нүүрсний үнийг 130-140 орчим ам.долларт тогтворжино гэж таамаглаж байна.

График № 6. Нүүрсний үнийн төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмберг

**Газрын тос.** Brent (Brent) газрын тосны дундаж үнэ 2021 оны эхний 8 сарын байдлаар 67 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 55 хувиар өссөн байна. Судлаачдын таамгаар газрын тосны үнийг 2022 онд 65 ам.доллар орчимд төсөөлж байна.

График № 7. Газрын тосны үнийн төсөөлөл, ам.доллар/баррель



Эх үүсвэр: Блүүмберг

## 1.2. Монгол улсын эдийн засаг

### 1.2.1. 2020 оны гүйцэтгэл

#### Эдийн засгийн өсөлт



Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 2020 онд 37.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1 хувиар буурсан бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 26.7 их наяд төгрөг болж, Монгол Улсын эдийн засаг өмнөх оноос 4.6 хувиар агшлаа.

**ХАА-н салбарын өсөлт 2020 оны 4 дүгээр улиралд саарсан ч тус салбар оны эцэст 5.8 хувиар өслөө.** Зуншлага оройтсон, зудын эрсдэл өндөр болсон, өвс тэжээлийн эрэлт хэрэгцээ ихэссэн, малын чанарт анхаарах хандлагатай болсон зэрэг шалтгаануудаас үүдэн хүнсэнд нийлүүлсэн малын хэмжээ ихээхэн нэмэгдсэн байна. ХАА-н салбар 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 5.8 хувиар өсөж, нийт эдийн засагт 0.8 нэгж хувийн өсөлт бий болголоо.

**Эдийн засгийн идэвхжил 2020 оны эхний хагаст огцом суларсан ч сүүлийн хагаст уналт нь саарсан байна.** Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын эсрэг хөл хорионы улмаас бодит ДНБ 2020 оны эхний хагаст 9.0 хувиар агшсан бол сүүлийн хагаст сэргэж, жилийн дүнгээр эдийн засаг 4.6 хувийн бууралттай гарлаа. 2020 оны 3 дугаар улиралд экспортыг нэмэгдүүлэх болон иргэд, ААН-үүдийн орлогыг хамгаалахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлсэн, бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааны зарим хязгаарлалтыг сулруулсан нь сүүлийн хагас жилд эдийн засгийн уналт саарахад голлон нөлөөллөө.


**Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тус салбарын экспорт 2020 оны сүүлийн хагаст сэргэсэн байна.** Уул уурхайн салбарын экспорт 2020 оны эхний хагас жилд 2.6 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хувиар буураад байсан. Экспортыг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр 2020 оны 8 дугаар сараас хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тус салбарын экспорт оны сүүлийн хагас жилд 4.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 35 хувиар өссөн байна.

	2017	2018	2019	2020
<b>Эдийн засгийн өсөлт</b>	<b>5.6</b>	<b>7.7</b>	<b>5.6</b>	<b>-4.6</b>
Хөдөө аж ахуй	-0.3	6.5	5.2	5.8
Үйлдвэрлэл	1.4	8.5	3.1	-4.4
Уул уурхай	-3.9	5.4	-1.6	-9.9
Боловсруулах	16.4	19.5	3.8	3.4
Цахилгаан	4.8	8.6	7.7	2.6
Барилга	-1.3	1.8	20.3	-3.2
Үйлчилгээ	7.1	5.1	6.4	-6.5
Худалдаа	8.2	0.1	10.9	-12.5
Тээвэр	1.0	14.6	4.4	-18.2
Мэдээлэл, холбоо	-4.5	12.1	12.1	5.2
Бусад	8.8	4.8	4.6	-2.6
Цэвэр татвар	23.3	20.4	9.6	-9.4

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

**Эдийн засгийн нийт эрэлт.** Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий өсөлтийн хувьд нийт эрэлт 2020 онд 4.4 хувиар буурсан байна. Үүнд эцсийн хэрэглээ 3.6 нэгж хувийн, цэвэр экспорт 8.2 нэгж хувийн эерэг хувь нэмэр оруулсан бол хөрөнгийн нийт хуримтлал 16.2 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлж, эдийн засгийн уналтын гол шалтгаан болсон байна.

График № 8. ДНБ-ий өсөлтийн бүтэц, хувь, улирлаар



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

КОВИД-19 цар тахалтай холбоотой иргэдийн хөл хөдөлгөөн хязгаарлагдсан ч эцсийн хэрэглээ өсөж, зах зээлийн нийт эрэлтэд эерэг нөлөө үзүүлсэн байна. Нийт эцсийн хэрэглээ 2020 онд 4.5 хувиар өсөж, ДНБ-ий 3.6 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд өрхийн хэрэглээг дэмжиж, эдийн засгийн агшилтыг хязгаарлахад эерэг хувь нэмэр оруулжээ. Нийт эцсийн хэрэглээний өсөлтийн 1.7 нэгж хувийг өрхийн хэрэглээний өсөлт бүрдүүлсэн бол 2.8 нэгж хувийг төрийн байгууллагын хэрэглээ бүрдүүлжээ.


ДНБ-ий өсөлтөд гадаад худалдааны оруулж буй хувь нэмэр 8.2 хувь болж оны эцэст өсөхөд

экспортын өсөлт болон импортын бууралт голлон нөлөөлжээ.

## Гадаад худалдаа

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 онд 12.9 тэрбум ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 2,282.4 сая ам.долларын ашигтай гарлаа.

График № 9. Гадаад худалдааны гүйцэтгэл, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Экспортоор 7.6 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргаснаар 2019 оноос 0.6 хувиар буурсан байна. КОВИД-19 цар тахлын тархалттай холбоотойгоор дотоодын үйлдвэрлэл саарч, хилийн боомтуудын үйл ажиллагаа удааширснаар экспортын хэмжээ саарсан. Тухайлбал, уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний экспорт 30.9 хувиар, газрын тосны экспорт 58.8 хувиар, жоншны экспорт 23.5 хувиар, цайрын баяжмалын экспорт 11.3 хувиар тус тус буурсан. Мөн уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 37.5 хувиар буурчээ. Харин алтны экспорт 30.5 тоннд хүрсэн нь экспортод голлох нөлөө үзүүллээ.



Импортоор 2020 онд 5.3 тэрбум ам.долларын бараа, түүхий эд авсан нь өмнөх оны мөн үеэс 13.6 хувиар буурчээ. Эдийн засгийн агшилт, уул уурхайн үйлдвэрлэлийн бууралт, дотоодын хөл хорионы дэглэмтэй холбоотойгоор автобензин, дизель түлш, автомашин, машин, механизм болон тэдгээрийн эд ангийн импорт буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Мөн авто бензин, дизелийн түлшний дэлхийн зах зээлийн үнэ буурсан нь нөлөөлжээ.

## Төлбөрийн тэнцэл




Төлбөрийн тэнцэл 2020 онд 787 сая ам.долларын ашигтай гарсан байна. Үүнд урсгал ба хөрөнгийн данс 572 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1,504 сая ам.долларын ашигтай гарлаа.

2020 онд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотойгоор Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын хэмжээ нэмэгдсэн

байна. Харин хувийн хэвшлийн зарим аж ахуйн нэгж олон улсын зах зээлд гаргасан бондын төлбөрөө цаг хугацаанд нь эргүүлэн төлсөн нь гадаад зээлийн төлөлт нь ашиглалтаасаа давсан үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна.

График № 10. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар




Эх үүсвэр: Монголбанк

## Мөнгөний нийлүүлэлт



Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2020 онд өмнөх оноос 16.3 хувиар өсөж 24.2 их наяд төгрөгт хүрлээ. Үүнд гадаад валютын хадгаламж 33.2 хувь, төгрөгийн хадгаламж 20.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн.

График № 11. Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг



Эх үүсвэр: Монголбанк

Эдийн засаг агшиж, 2020 онд зээл олголт буурсан нь мөнгөний нийлүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлэв. Харин гадаад цэвэр активын өсөлт мөнгөний нийлүүлэлтэд эергээр нөлөөлсөн байна.

## Инфляц



Инфляцын түвшин цар тахлын нөлөөгөөр 2020 онд нам дор түвшинд хадгалагдан 2.3 хувьд хүрч, өмнөх оноос 3 нэгж хувиар бага гарлаа.

Эдийн засгийн идэвхжил, зах зээлийн нийт эрэлтийн төлөв байдлыг харуулдаг суурь инфляц мөн нам доогуур түвшинд хүрэв.


График № 12. Жилийн инфляц ба суурь инфляц, хувь



Эх үүсвэр: УСХ, Монголбанк

Инфляцын бууралтад шатахууны жижиглэнгийн үнэ буурсан, Засгийн газраас өрх, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлэх зорилгоор “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний үнийг бууруулсан нь голлон нөлөөллөө.

График № 13. Инфляцын бүтэц, хувь



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо


## 1.2.2. 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

### Эдийн засгийн өсөлт

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2021 оны эхний хагас жилд 19.7 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 12.5 их наяд төгрөгт хүрч, эдийн засаг өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өслөө.

Салбараар авч үзвэл 2021 оны эхний хагаст уул уурхайн салбар 24.3 хувиар, үйлчилгээний салбар 3.0 хувиар өссөн бол хөдөө аж ахуйн салбар 4.6 хувиар буурсан байна.

График № 14. Эдийн засгийн өсөлт, хувь




Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Дэлхийн зах зээл дээрх уул, уурхайн эрдэс бүтээгдэхүүний үнэ өсөж, эрэлт нэмэгдсэн хэдий ч КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр хилийн боомтууд дээр хүндрэл үүсэж түүхий эдийн экспортын өсөлтийг огцом бууруулсан нь эдийн засгийн өсөлтийн хурдцыг саарууллаа. Уул уурхайн салбар 2020 оны эхний хагас жилд эдийн засгийн өсөлтийг 4.6 нэгж хувиар бууруулж байсан бол энэ оны эхний хагаст 2.7 нэгж хувийн өсөлтийг бий болгосон байна. Чулуун нүүрсний үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 30 хувиар нэмэгдэж 19.6 сая тонн, газрын тосны үйлдвэрлэл 2.5 дахин нэмэгдэж 3.5 сая баррельд хүрсэн байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогын хүрээнд боловсруулах салбар, тээвэр, агуулахын салбар болон бөөний ба жижиглэнгийн худалдааны салбаруудын үйл ажиллагаа өсөлттэй байна. 2021 оны эхний хагас жилд боловсруулах салбар 12.7 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.8 нэгж, бөөний ба жижиглэн худалдааны салбар 7.8 хувиар өсөж, нийт эдийн засагт 0.8 нэгж хувь өсөлт бий болгосон бол тээвэр ба агуулахын үйлчилгээний салбар 2.5 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтөд 0.1 нэгж хувь өсөлт бий болгожээ.

График № 15. Эдийн засгийн өсөлт, салбараар, хувь




Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Бойжуулсан төл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.7 хувиар буурсан, зүй бус хорогдол 82.4 хувиар өссөн нь хөдөө аж ахуйн салбар уналттай гарахад голлон нөлөөллөө. Хөдөө аж ахуйн нэмэгдэл өртөг 2021 оны эхний хагас жилийн байдлаар 2.8 их наяд төгрөг болж, 2.5 хувиар өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит нэмэгдэл өртөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.6 хувиар буурсан нь ДНБ-ийг 0.8 нэгжээр буурууллаа.

Барилгын салбар дахь хөрөнгө оруулалт буурсан, барилгын үндсэн түүхий эдийн үнэ нэмэгдсэн нь барилгын салбарын бууралтад голлон нөлөөллөө. 2021 оны эхний хагас жилд барилгын салбарын нэмэгдэл өртөг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.7 хувиар буурсан нь эдийн засгийн өсөлтөд 1.1 нэгжээр сөрөг нөлөө үзүүлсэн байна.

График № 16. Барилгын салбарын өсөлт, хувь



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Бүтээгдэхүүний цэвэр татвар энэ оны эхний хагас жилд 23.5 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 3 нэгжийг бий болгосон байна.

Засгийн газраас 10 их наяд төгрөгийн цогц хөтөлбөр хэрэгжүүлж эхэлснээр 2021 оны хоёрдугаар улиралд өрхийн хэрэглээний уналт саарсан байна. Мөн зээл олголт нэмэгдэж, үндсэн хөрөнгийн хуримтлал нэмэгдэж, капитал өсөж байгаа болон ажлын байр хадгалагдаж, ажил эрхлэлт нэмэгдэж байгаа нь цаашид үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг нэмэгдүүлж, өсөлтийг дэмжихээр байна.

### Гадаад худалдаа




Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2021 оны эхний 8 сарын байдлаар 10.1 тэрбум ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны тэнцэл 1.1 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспортоор 5.6 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь өмнөх оны мөн үеэс 25.6 хувиар өссөн. Цар тахлын тархалттай

холбоотойгоор боомтын үйл ажиллагаанд саатал үүссэн ч зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр өндөр байгаатай холбоотойгоор экспорт нийт дүнгээрээ өссөн байна.

Импортоор авсан бараа, түүхий эдийн дүн 2021 оны эхний 8 сард 4.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 29.6 хувиар өссөн.

График № 17. Гадаад худалдаа, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Шинжээчдийн таамгаар 2021 оны сүүлийн хагаст нүүрс, газрын тос, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, алт зэрэг уул уурхайн салбарын голлох бүтээгдэхүүнүүдийн үнэ тогтвортой байхаар хүлээгдэж байна.

Эдийн засгийн идэвхжил 2020 онтой харьцуулахад аажмаар сэргэж байгаатай холбоотойгоор өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт нэмэгдэх төлөвтэй байна. 2021 оны хоёрдугаар улиралд өмнөх улирлаас хэрэглээний бүтээгдэхүүний импорт 24.7 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 22.2 хувиар тус тус өссөн байна. Иймд импортын хэмжээ 2021 онд 6.6 орчим тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна.


### Төлбөрийн тэнцэл



Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 300 сая ам. долларын алдагдалтай гарлаа. Урсгал ба хөрөнгийн данс 1,147 сая ам.долларын алдагдалтай гарсан бол санхүүгийн данс 918 сая ам.долларын ашигтай гарсан байна. Импортын дүн нэмэгдсэнтэй холбоотойгоор барааны дансны ашиг өмнөх оны мөн үеэс 286 сая ам. доллароор буурсан бол үйлчилгээний дансны алдагдал 172 сая ам. доллароор буурсан дүнтэй байна. Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс 375 сая ам. доллароор нэмэгдсэн нь багцын

хөрөнгө оруулалтын гарах урсгал 449 сая ам. доллароор буурсантай холбоотой байна. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 1,131 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өслөө.

График № 18. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар



Эх үүсвэр: Монголбанк

2021 оны сүүлийн хагаст томоохон дүнтэй бонд болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой валютын гадагшлах урсгал байхгүй зэрэг нь гадаад валютын нөөцөд ирэх дарамтыг бууруулж байна.

### Инфляц



Цар тахлаас шалтгаалан улс орнуудын инфляц 2020 онд зорилтот түвшнээс нам доогуур байсан хэдий ч 2021 оны 4 дүгээр сараас эхлэн өмнөх саруудтай харьцуулахад өсөх хандлага ажиглагдаж байна.

Манай улсын хувьд ч дээрх нийтлэг хандлага ажиглагдаж 2021 оны 1-3 дугаар сард 2.5 хувь орчимд тогтвортой байсан инфляцын түвшин 4 дүгээр сараас эхлэн нэмэгдэж 8 дугаар сарын байдлаар 8.9 хувьд хүрлээ.

**Нийлүүлэлтийн шалтгаантайгаар инфляцын дарамт өсөв.** Инфляц ийнхүү өсөхөд БНХАУ-ын хилээр нэвтрэх ачаа тээврийн хязгаарлалттай холбоотойгоор импортын бараа бүтээгдэхүүний өртөг өссөн нь нөлөөлөв.

Нөгөө талаас дэлхийн зах зээлд нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийг даган дотоодын шатахууны үнэ өссөний зэрэгцээ хүнсний бүлгийн барааны үнийн өсөлт голлон тайлбарлаж байна. Ийнхүү нийлүүлэлтийн гаралтай, түр зуурын шинжтэй хүчин зүйлс инфляцын түвшинд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

## Мөнгөний нийлүүлэлт



Мөнгөний нийлүүлэлт 2021 онд тасралтгүй өсөж 8 дугаар сарын байдлаар 27.1 их наяд төгрөгт хүрээд байна.

Засгийн газраас өрхийн орлогыг хамгаалахад чиглэсэн нийгмийн халамжийн бодлогыг үргэлжлүүлсний зэрэгцээ Төв банктай хамтран цар тахлын эсрэг “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байгаа нь зээл олголтыг нэмэгдүүлэн мөнгөний нийлүүлэлтийг дэмжиж байна. Тухайлбал, арилжааны банкуудын зээлийн үлдэгдэл эхний хагас жилийн байдлаар жилийн 5 хувийн өсөлттэй гарсан ба 10 их наядын цогц төлөвлөгөө хэрэгжүүлж, зээл олгоогүй бол зээлийн хэмжээ 11.5 хувиар буурахаар байв.

Цаашид эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дэмжих төлөвтэй байна.

### 1.2.3. Макро эдийн засгийн 2022-2024 оны төсөөлөл

#### Эдийн засгийн өсөлт

*Монгол Улсын 2022-2024 оны эдийн засгийн дундаж өсөлт 5.0 орчим хувь байхаар хүлээгдэж байна.*

Шинжээчид олон улсын зах зээл дээрх алт, зэс болон төмрийн хүдэр зэрэг металлуудын үнийн төсөөллийг нэмэгдүүлж байгаа нь дэлхийн эдийн засгийн төлөв сайжирч байгааг харуулж байна.

Гадаад орчин ийнхүү сэргэж байгаа нь манай улсын эдийн засагт таатай нөлөө үзүүлэхээр байна. Иймд Монгол Улсын 2022-2024 оны эдийн засгийн дундаж өсөлтийг урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 5.0 орчим хувь байхаар байна.

Потенциал өсөлтийг дэмжихийн тулд ажил эрхлэлтийг дэмжих, үйлдвэрлэл явуулахад шаардлагатай түүхий эд материалын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авах нь зүйтэй бөгөөд Засгийн газраас хэрэгжүүлж буй 10 их наяд төгрөгийн цогц төлөвлөгөөг макро эдийн засгийн тэнцвэрт байдалтай уялдуулж, бизнес эрхлэгчдийн идэвхийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн хэрэгжүүлнэ.

Мөн экспортыг нэмэгдүүлэх хүрээнд цар тахлын хяналтыг сайжруулж, нүүрсийг чингэлэгт тэвэрээр экспортлох ажлыг эхлүүлэн ажиллаж байна.

*Хүснэгт № 2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувь*

	2021	2022	2023
Эдийн засгийн өсөлт	4.1	5.0	5.0
Уул уурхайн	8.4	0.9	5.6
Уул уурхайн бус	3.4	5.7	4.9

*Эх үүсвэр: Тооцоолол*

Дунд хугацаанд газрын тос боловсруулах үйлдвэр, Богдхан төмөр зам, Оюутолгойн далд уурхай зэрэг томоохон төслүүдийн барилга, угсралтын ажлыг эрчимжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжинэ.

#### Гадаад худалдаа

Дэлхий нийтэд коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцинжуулалт амжилттай хэрэгжсэнээр улс орнуудын эдийн засагт сэргэлт бий болохоор төсөөлж байна. Манай улсын хувьд Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор эдийн засгийн идэвхжил сэргэж, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, үйлчилгээ, худалдааны салбарын үйлдвэрлэл сэргэж, үүнийг дагасан автобензин, дизель түлш, үйлдвэрлэлийн орц, барилгын материал, машин, механизм, тэдгээрийн эд ангийн импорт өсөхөөр таамаглаж байна. Гагцхүү халдварын нөхцөл байдлаас шалтгаалан хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадвар муу байгаа нь гадаад худалдааны эргэлтэд сөрөг нөлөө үзүүлэх өндөр эрсдэлтэй хэвээр байна.

#### Төлбөрийн тэнцэл

Засгийн газраас 600 сая ам.долларын “Номад” бонд болон “CENTURY” төслийн хүрээнд 1 тэрбум ам.долларын бондуудыг амжилттай гаргалаа. Ингэснээр дунд хугацаанд төлөгдөхөөр хүлээгдэж байсан гадаад үнэт цаасны үндсэн төлбөр, өрийн үйлчилгээний ачааллыг жигдэлж, төлбөрийн тэнцлийн дарамтыг буурууллаа. Цаашид гадаад үнэт цаасыг төсөв болон эдийн засагт дарамт учруулахгүйгээр шийдвэрлэх замаар төлбөрийн тэнцэл, валютын ханшийн эрсдэлийг бууруулна.

#### Инфляц

Эдийн засгийн сэргэлт, Засгийн газраас коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг

хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь эдийн засгийн сэргэлтийг дэмжиж байна. Инфляцын шалтгаан болж буй зарим бараа, бүтээгдэхүүний суурь үеийн нөлөө болон түр зуурын шинжтэй нийлүүлэлтийн хүчин зүйлийн нөлөө 2022 онд арилгаж чадвал инфляц зорилгод түвшин орчимд тогтворжихоор байна.

#### **1.2.4. Макро эдийн засгийн төсөөлөл боловсруулахад ашигласан аргачлал, тооцооны товч танилцуулга**

Макро эдийн засгийн төсөөллийг боловсруулахдаа эдийн засгийн үндсэн салбарууд болох бодит, төсөв, мөнгө, гадаад секторуудын тооцоо, төсөөллийг Олон Улсын Валютын Сангаас боловсруулсан Санхүүгийн програмчлал /Financial Programming/ макро эдийн засгийн загвар болон бусад макро эконометрик загваруудыг суурь болгон ашиглав.

## 2. 2022 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГО, ЗОРИЛТ




Халдварт цар тахал 2020 он гарсаар эрчимтэй дэгдэж улс орнуудын нийгэм, эдийн засагт урьдчилан тооцоолох боломжгүй эрсдэл учруулсны дотор манай улсын эдийн засгийн өсөлт -4.6 хувь, төсвийн алдагдал ДНБ-ий -12.0 хувьд хүрээд байсан боловч Засгийн газар цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжүүдийг дэмжих нийт 2.6 их наяд төгрөгийн багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Засгийн газар 2021 оны 2 дугаар сараас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, 4 дүгээр сараас хүн амын зорилгод хэсгийг эрчимтэй вакцинжуулснаар хол хориог үе шаттай сулруулж аж ахуйн нэгж, бизнесийн үйл ажиллагааг нээснээр эдийн засгийн өсөлтийг 2021 оны эхний хагас жилд 6.3 хувьд хүргэж чадсан. 10 их наядын цогц төлөвлөгөөний үр дүнд банкны секторын зээл 10.5 хувиар агших

байсныг 6.5 хувийн өсөлттэй хадгалж, банкны нийт зээлийн хэмжээ 18.1 их наяд төгрөгт хүрч, зээл олголт цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд хүрсэн байна. Түүнчлэн, 2021 оны 9 дүгээр сарын 27-ний байдлаар нийт 58 мянган зээлдэгчид 3.7 их наяд төгрөгийн зээлийг банкуудын эх үүсвэрээр олгож, 10.2 мянган иргэнийг орон сууцжуулж, 266.8 мянган ажлын байрыг хадгалаад байна.

Улмаар 2022 онд вакцинжуулалтын үр нөлөөгөөр бизнесийн үйл ажиллагааг бүрэн нээж эдийн засгийг сэргээх, гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг нэмэгдүүлэх, томоохон төслүүдийг эхлүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын төслүүдийг түлхүү хэрэгжүүлж эдийн засгийг тэлэх, “ХӨДӨЛМӨР, БҮТЭЭМЖ, ӨСӨЛТ”-ийг дэмжих төсвийн бодлого хэрэгжүүлснээр Монгол Улсын эдийн засгийг 5.0 хувийн өсөлттэй байна гэж тооцож байна.

### МӨЧЛӨГ СӨРСӨН ТӨСВИЙН БОДЛОГО





“Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилт 2030, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд чиглэсэн **ХӨДӨЛМӨР, БҮТЭЭМЖ, ӨСӨЛТ**-ийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд дараах багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:



1. Хөгжлийн төслүүдийг эхлүүлэх, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар **ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ** шинэчлэл хийнэ.



2. Төрийн өмчит хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулж төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор **ЗАСАГЛАЛ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ, НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН** шинэчлэлийг ирэх онд хэрэгжүүлнэ



3. Төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр **БҮХ ШАТНЫ БАЙГУУЛЛАГУУДЫГ ХЭМНЭЛТИЙН ГОРИМД** ажиллана.



4. Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж **СТАНДАРТ-ЧАНАР-ӨРСӨЛДӨӨН**-д суурилсан үйлчилгээг төр худалдан авах, нийгмийн суурь үйлчилгээний байгууллагуудыг төсвийн хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх зэргээр **ЦОМХОН, ЧАДВАРЛАГ ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА**-ыг бүрдүүлнэ



5. Эрүүл мэндийн салбарт энэ онд хэрэгжүүлж эхэлсэн шинэчлэлийг эрчимжүүлж **ИРГЭДЭЭ ЖИЛ БҮР УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ** хамруулна



6. Байгалийн баялгийн хүртээмжийг нэмэгдүүлж, ирээдүй хойч үедээ өвлүүлж, санхүүгийн баталгаатай, **“ХУРИМТЛАЛТАЙ ХҮҮХЭД”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



7. Хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн **ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ** шилжих шинэчлэл хийнэ.



8. Хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийн дагуу үнэлгээ хийгдсэн **ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙГ** нэн тэргүүнд хэрэгжүүлж, урсгал болон ашиглалтын зардал өндөртэй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй.



9. Улаанбаатар хотын авто замын **ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХАД** шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэнэ.

## ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:



Ирэх 2022 онд эдийн засгийн сэргэлтийг дэмжих, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, худалдааг хөнгөвчлөх, төрийн өмчийн хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөжийг дээшлүүлэх, засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төрийн хяналт шалгалтыг оновчтой, түргэн шуурхай болгох зэрэг бодлого хэрэгжүүлнэ.



**Нэг. Худалдааг хөнгөвчлөн эргэлтийг нэмэгдүүлэх, бараа бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх цаг, зардлыг бууруулж эдийн засаг, бизнесийг дэмжинэ.**

Хилийн мэргэжлийн хяналтын албаны чиг үүргийг гаалийн байгууллагад нэгтгэж гадаад худалдаа эрхлэгчдээс шаардах баримт бичиг, биет үзлэг, шалгалтын тоог бууруулна. Гаалийн шинэчлэлийн хүрээнд гаалийн үйлчилгээ, хяналт шалгалтыг цахимжуулж, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмж ашиглан хүний оролцоог бууруулж, иргэд, аж ахуйн нэгжийн гадаад худалдаанд зарцуулах цаг, зардлыг хэмнэнэ.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа гаалийн шинэчлэлийн хүрээнд 2022 онд Замын-Үүд, Боршоо боомтын шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж хилийн нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ. Замын-Үүд хилийн боомтын зорчигч тээврийн хэсэгт 30, ачаа тээврийн хэсэгт 28 барилга байгууламж, зам талбайг шинээр ашиглалтад оруулснаар өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын автомашины тоо 7 дахин нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгжүүдэд түргэн шуурхай үйлчлэх боломжийг бүрдүүлнэ.

Орчин үеийн өндөр хүчин чадал бүхий рентген, дээж авагч тоног төхөөрөмж, гаалийн төрөлжсөн лабораториудыг ашиглаж экспортын эрдэс бүтээгдэхүүний хэмжээ, агуулга, чанарыг үнэн зөв, шуурхай тодорхойлж татварыг бүрэн хураана.

**Хоёр. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулж төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор засаглал,**


**бүтцийн өөрчлөлт, ногдол ашгийн бодлогын шинэчлэлийг тус тус хэрэгжүүлнэ.**

Төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэлийн хүрээнд төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагыг нээлттэй сонгон шалгаруулан бие даасан байдлыг ханган мэргэжлийн, хараат бус болгоно. Мөн үйл ажиллагаа, санхүү, ашигт ажиллагааны үр дүнгээр үнэлж дүгнэх, хариуцлага тооцож байх, эдгээртэй холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох арга хэмжээ авна. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнг нээлттэй хувьцаат компанийн жишгээр тайлагнуулж, олон нийтэд нээлттэй болгоно.

Ингэснээр төрийн өмчийн хуулийн этгээд бизнесийн шийдвэрээ бие даан, хараат бусаар гаргаж үйл ажиллагаа явуулах, хариуцлагатай ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Төрийн өмчит хуулийн этгээдийн бүтцийн өөрчлөлтийн шинэчлэлийг компанийн санхүүгийн эрсдэлийн үзүүлэлтүүд, тухайн салбарын зах зээлийн өрсөлдөөн, хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой эсэх зэргийг харгалзан хэрэгжүүлнэ. Санхүүгийн эрсдэлийг олон улсын үнэлгээний байгууллага, ЭЗХАХБ, ОУВС-д өргөн хэрэглэгддэг Э.Альтман, Г.Спрингэйтийн санхүүгийн дарамтыг тооцох S-Score-ийг ашиглан төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн мэдээлэлд үндэслэн тооцно.

График № 19. Төрийн өмчийн хуулийн этгээдийн S-Score тооцоолол



Төрийн оролцоо, үнэ тарифын зохицуулалт зайлшгүй шаардлагатай, нийтийн ашиг

сонирхлын үүднээс төрийн зарим чиг үүргийг тодорхой хугацааны турш хэрэгжүүлэх тусгай зориулалт бүхий дулаан, цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, төмөр замын суурь бүтэц эзэмших зэрэг стратегийн ач холбогдолтой үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг төр цаашид 100 хувь эзэмшилдээ байлган засаглалыг бэхжүүлж ажиллана.

Тухайн бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоо тодорхой хэмжээнд шаардлагатай, санхүүгийн эрсдэл бага төрийн өмчийн хуулийн этгээдийг нэмэлт хувьцаа гарган үнэт цаасны анхдагч зах зээлд олон нийтэд санал болгож, хөрөнгө оруулалт нэмж татах замаар нээлттэй хувьцаат компани болгоно. Ийнхүү хувийн хэвшлийн оролцоо, хяналтыг бий болгосноор компанийн үйл ажиллагаа сайжирч, үнэлгээ өсөж төрийн өмчийн хөрөнгийн өгөөж нэмэгдэнэ.

Чөлөөт зах зээлийн зарчмаар хувийн хэвшил бие даан өрсөлдөх боломжтой бизнест төр хуулийн этгээд байгуулан оролцох нь шударга бус өрсөлдөөний орчин үүсгэж хувийн хэвшилд сөргөөр нөлөөлж байна.

Иймд үйл ажиллагаанд нь цаашид төр оролцох шаардлагагүй, алдагдалтай ажилладаг, санхүүгийн эрсдэл өндөр төрийн өмчит хуулийн этгээдийг нэгтгэх, худалдах, татан буулгах замаар эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулна.

ЭЗХАХБ-ын “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим”, Монголын компанийн засаглалын жишиг баримт бичигт төрийн өмчит хуулийн этгээд нь капиталын бүтцийн зохистой харьцаа, ногдол ашиг, хөрөнгийн өгөөжийн урт хугацааны бодлогыг тодорхойлж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөдөг.

Өнгөрсөн хугацаанд төрийн өмчит хуулийн этгээдийн ногдол ашгийн бодлогыг тодорхой журамлаж зохицуулаагүй байна. Улмаар тухайн хуулийн этгээдийн ашгийн хэмжээнээс хамаарч харилцан адилгүй зарчмаар ногдол ашиг хуваарилж ирсэн. Энэ нь санхүүгийн сахилга бат, ашигт ажиллагаа, хөрөнгийн өгөөж хангалтгүй байх, түүхий эдийн үнийн өсөлтөөс хамаарсан их хэмжээний нэмэлт орлогоор үр ашиггүй, үндсэн үйл ажиллагаанаас гадуур нийгмийн хариуцлагын гэх төсөл, арга хэмжээг

санхүүжүүлж байгаа нь хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Иймд ногдол ашгийн бодлогын шинэчлэлийн хүрээнд олон улсын гэрээ болон тусгайлсан хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, ашигтай ажиллах боломжгүй, үнэ тарифыг төрөөс зохицуулдаг төрийн өмчит хуулийн этгээдээс бусад этгээд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу нэгдсэн зарчмаар ногдол ашиг хуваарилна.

Ингэхдээ төрийн өмчит хуулийн этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг хуваарилж төрд эзэмшлийн хувьцаанд хамаарах дүнгээр төсөвт ногдол ашиг төвлөрүүлнэ. Олон улсын жишигт нийцсэн ногдол ашгийн бодлого хэрэгжүүлснээр төрийн өмчит хуулийн этгээд зардлаа хэмнэх, санхүүгийн үр ашгаа нэмэгдүүлэх, оновчтой хөрөнгө оруулалт хийх хөшүүрэг болж санхүүгийн сахилга бат сайжирна.



**Гурав. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулан хялбаршуулж, хүний оролцоог бууруулах, бүртгэлийг сайжруулж татварын суурийг өргөжүүлэх, татвараас зайлсхийхийн эсрэг олон улсын дүрмийг хэрэгжүүлж татварын орлогыг хамгаалах ажлыг үргэлжлүүлнэ.**

Ирэх онд татварын албаны мэдээллийн технологийн дэд бүтцийг боловсронгуй болгох, татварын бүртгэл, мэдээллийн санг өргөтгөх, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, татвар ногдуулалт, төлөлтийг цахимжуулж хялбаршуулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг ашиглан татвар төлөгчид татварын тооцоолол хийх, татварын болзошгүй өр төлбөрөөс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлийн талаар мэдэгдэх зэрэг дэмжлэг үзүүлнэ.

Иргэд татварын үйлчилгээг гар утсаа ашиглан нэг цонхоор авах, албан татвар, төлбөр, хураамжаа түргэн шуурхай, хялбараар төлөх боломжийг олгохоор “e-barimt”-ийн системийг үргэлжлүүлэн хөгжүүлнэ.

ЭЗХАХБ-ын Татварын суурийг бууруулах, ашиг шилжүүлэхийн эсрэг үйл ажиллагаа болон Татварын ил тод байдал, мэдээлэл солилцооны олон улсын форумын гишүүн орны хувьд татвараас зайлсхийхийн эсрэг болон мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагаатай холбогдох олон улсын стандартыг татварын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн мөрдөнө. Энэ хүрээнд үндэстэн дамнасан корпорацын татвараас зайлсхийх явдлын эсрэг бусад улс оронтой хамтран ажиллаж, мэдээлэл харилцан солилцон үнэ шилжилтийн хяналт шалгалт, тайлангийн тоог нэмэгдүүлэх замаар татварын суурийг хамгаална.

## ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

**Төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр БҮХ ШАТНЫ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУД ХЭМНЭЛТИЙН ГОРИМД ажиллана.**



### **Орон тоог хязгаарлах чиглэлээр:**

Төрийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын ажлын ачааллыг нягтруулах, чиг үүргийг оновчтой хуваарилах зорилгоор дараах зохицуулалт хийнэ. Үүнд:

- сайд нар нэгээс илүүгүй зөвлөх, туслахтай байх;
- дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга дундаа нэг туслахтай байх;
- Засгийн газрын агентлаг нэгээс илүүгүй дэд даргатай байх, дарга нь зөвлөхгүй байх;
- тэтгэвэрт гарсан хоёр албан хаагч тутамд нэг нөхөн томилгоо хийх.



### **Төрийн үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр:**

Төсөв хэмнэж, иргэдэд хүргэх үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай хүргэх зорилгоор бүх шатны төрийн байгууллагын сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулах, албан хаагчийг мэргэшүүлэх арга хэмжээг цахимаар зохион байгуулж холбогдох зардлыг бууруулна. Мөн захиргааны албан хаагчид долоо хоногийн ажлын нэг өдөр нь гэрээсээ цахимаар ажиллахыг зөвшөөрөх,

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд цахим гарын үсэг нэвтрүүлж банк, даатгал, нотариат, тусгай зөвшөөрөл, хөрөнгө болон эрх өмчлөх, эзэмших, ашиглах шилжүүлэх, сунгах зэрэг үйлчилгээнд ашиглах зэрэг нь иргэдийн цаг завьг хэмнэх, авто замын түгжрэлийг багасгахад эерэг нөлөөтэй байх болно.

**Бараа үйлчилгээний зардлыг бууруулах чиглэлээр:** Бүх шатны төсвийн байгууллагын

дараах зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлж дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:



### **Санхүүжилтийг 100 хувь хязгаарлах зардал:**

- төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахуун;
- гадаад албан томилолт;
- зочин төлөөлөгч хүлээн авах;
- тавилга, эд хогшил худалдан авах;
- ном хэвлэл худалдан авах, хэвлүүлэх;
- сурталчилгаа хийх;
- бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх;
- биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах;
- байгууллагын болон салбарын тэмдэглэлт өдөр, ой тэмдэглэх, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах;
- салбартай холбоотой киноны уран бүтээл хийх.
- тусгай чиг үүрэг гүйцэтгэхээс бусад байгууллага шинээр автомашин худалдан авах;
- албан конторын барилга шинээр барих

### **Санхүүжилтийг 50 хувь хязгаарлах зардал:**

- бичиг хэргийн зардал;
- Ковид-19 халдварт цар тахалтай тэмцэх чиг үүрэгтэйгээс бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолт.

**Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж СТАНДАРТ-ЧАНАР-ӨРСӨЛДӨӨН-д суурилсан үйлчилгээг төр худалдан авах, нийгмийн суурь үйлчилгээний байгууллагуудыг төсвийн хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх зэргээр ЦОМХОН, ЧАДВАРЛАГ ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБА-ыг бүрдүүлнэ**

**Төр зарим үйлчилгээг өөрөө гүйцэтгэх бус харин хувийн хэвшлээс худалдан авдаг болно.**



Өнөөдөр төрийн гэдэг тодотголтой 198.0 мянган албан хаагчдын цалингийн зардалд жилд дунджаар 2.8 их наяд төгрөг, нийгмийн баталгааг хангах тэтгэмж, урамшуулалд 240.3 тэрбум төгрөг тус тус зарцуулж байна

Нийт төрийн алба хаагчдыг гүйцэтгэж байгаа чиг үүрэг болон шинж чанараар нь ангилж үзвэл: 1) төрийн өдөр тутмын үйлчилгээг иргэнд нүүр тулан үзүүлж байдаг улсын бүртгэл, татвар, гааль, халамж, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналт зэрэг байгууллагын албан хаагчид; 2) төрийн үйлчилгээ иргэнд шууд үзүүлдэггүй боловч төрийн бодлогыг тодорхойлох яам, агентлаг, хороод болон засаг захиргааны нэгжид ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид; 3) улс орны аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий батлан хамгаалах, хил хамгаалах болон хууль сахиулах чиг үүрэгтэй цагдаа, шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг байгууллагад ажиллаж байгаа төрийн тусгай албан хаагчид; 4) нийгмийн суурь үйлчилгээ болох боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, биеийн тамирын байгууллагын багш, эмч, сувилагч зэрэг төрийн үйлчилгээний албан хаагчид; 5) төрийн өмчийн байгууллагуудын өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг болох цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, харуул хамгаалалт, халаалт, хоол үйлдвэрлэлийн чиг үүргийг гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний албан хаагчид байна.



Төрийн захиргааны болон тусгай албан хаагчид нийт төрийн албан хаагчдын 25 хувийг эзэлж байгаа бол 25.4 хувийг боловсролын салбарын багш ажиллагчид, 12.8 хувийг эрүүл мэндийн салбарын эмч ажиллагчид, 3.1 хувийг соёл урлаг, шинжлэх ухааны салбарын ажилтнууд харин 26 хувийг төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах чиг үүрэг бүхий үйлчилгээний ажилтнууд эзэлж байна.

Ирэх 2022 оноос төр зөвхөн бодлого тодорхойлох болон зохицуулах үндсэн чиг үүргээ цомхон бүтцээр, зардал багатай, хариуцлагатай гүйцэтгэдэг байх тогтолцоонд шилжих чиглэл баримталж байна.

Харин төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах цэвэрлэгээ, засвар, харуул хамгаалалт, хоол үйлдвэрлэл, автомашины үйлчилгээг төр заавал өөрөө бус харин хувийн хэвшилээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой бөгөөд ажил үйлчилгээний тарифыг өрсөлдөхүйц хэмжээнд үндэслэлтэй тогтоож шаардлагатай санхүүжилтийг хүрэх үр дүн, чанарт үндэслэсэн хувийн хэвшилд шилжүүлэх чиглэл баримталж шаардлагатай зохицуулалтыг төсөвт тусгана. Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээнд тусгай чиг үүрэг гүйцэтгэдгээс бусад төсвийн бүх шатны байгууллагыг хамруулна.

**Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг салбарын төсвийг иргэнд чиглүүлж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг хүрэх үр дүн, чанарт нь үндэслэн санхүүжүүлнэ.**



Боловсрол, эрүүл мэнд, нийтийн биеийн тамир, соёлын салбарт төрийн үйлчилгээний ангилалд хамаарах 81.8 мянган албан хаагч ажиллаж нийт төсвийн талаас илүү хувийг зарцуулж байна

Төрийн үйлчилгээг оновчтой шийдэл бүхий санхүүжилтийн тогтолцоогоор шийдвэрлэх нь өнөөдрийн тулгамдсан асуудал болж байна. Өнөөдрийг хүртэл явж ирсэн нийтлэг төсвийн хуваарилалт нь төрийн албан хаагчдыг цалинтай, орлоготой байлгах талаас нь эсхүл төрийн албан контор, эмнэлэг, сургуулийг тавтай тохитой байртай байлгах талаас нь харж ирснээс бус төрийн үйлчилгээ иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байхаар өртөг зардал нь тооцогдож уу, тэдгээр үйлчилгээг хүргэх механизм нь оновчтой байж чадаж байна уу гэдэг талаас нь сайтар анхаарах шаардлагатай байна.

Төрийн үйлчилгээ бүрийг чанартай, хүртээмжтэй хүргэхэд тулгарч байгаа асуудлуудыг тодорхойлж улмаар түүнийг нь санхүүжилтийн механизмаар нь дамжуулж шийдвэрлэх зарлагын хуваарилалтын шинэчлэл хийхийг зорьж байна

Төсвийн нэг төгрөг бүрийн үр ашиг, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг 2021 онд эхлүүлсэн бол 2022 оноос боловсрол, соёл урлаг, нийтийн биеийн тамирын байгууллагыг санхүүгийн хувьд хагас бие даалгаж, үр дүн, чанар, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлнэ.

### **Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинэчлэлийг эхлүүлнэ.**



Боловсролын салбарын төсөв нь ДНБ-н 4.4 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын 13 орчим хувийг эзэлж байгаа нь хүний хөгжлийн индекс ойролцоо улсуудтай нэг түвшинд, дэлхийн хувьд дундаж түвшинд байна. Сүүлийн 8 жилд боловсролын салбарын зарлага дунджаар /нэрлэсэн үнээр/ 14.3 хувь (инфляцыг тооцсон дунджаар 7.1 хувь) өсжээ<sup>3</sup>.

Монгол Улсын хүн амын хэтийн тооцооллоор 2030 онд сургуулийн насны хүн амын тоо 35.2 хувь, үүнээс бага ангийн хүүхдийн тоо 10.9 хувь, дунд анги 43.7 хувь, ахлах ангийн насны хүүхдийн тоо 64.8 хувь нэмэгдэх төсөөлөлтэй байгаа нь цаашид сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг тасралтгүй нэмэгдүүлэх хэрэгцээг харуулж байна.



Нэг суралцагчид ногдох зардал хэт ялгаатай байна. Улаанбаатар, Дархан-Уул, Орхон зэрэг хүн амын төвлөрөл ихтэй газруудад нэг хүүхдийг сургах нэг жилийн дундаж зардал 1.0 сая төгрөг орчим байгаа бол бүлэг дүүргэлт доогуур байдаг Булган, Говь-Алтай, Дундговь зэрэг аймагт дунджаар 1.9 сая төгрөг буюу Улаанбаатар хотоос хоёр дахин өндөр байна. Мөн сургуулийн хэв шинжээс хамаарч нэг суралцагчид зарцуулах зардал ихээхэн хэлбэлзэлтэй байна. Нэг хүүхдийг сургахад зарцуулж байгаа дундаж урсгал зардал ихээхэн

хэлбэлзэж байгаа нь сургалтын хөтөлбөрийн онцлог, байршил, хэв шинж болон сургуулийн хүртээмжээс хамааран багш-сурагчийн тооны харьцаа, нэг бүлэгт хуваарилагдах хүүхдийн тоо болон барилга байгууламжийн хүчин чадлын ашиглалт, сургалтын орчин, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүрэлцээтэй байдал зэрэг хүчин зүйл ихээхэн нөлөөлж байна.

Бүлэг дүүргэлтийн хэт ялгаатай байдлаас болж зарим газарт дунд, ахлах ангид багшлах нарийн мэргэжлийн багшийн дутагдалтай байдаг бол зарим газарт багшид хэт их ачааллыг үүсгэж байна. Жишээ нь нийслэлийн зарим ачаалалтай сургуульд нэг ангид 50-60 хүүхэд суралцаж байгаа бөгөөд багш нь илүү ачаалалтай ажилласан боловч хэвийн ачаалалтай багштай адилхан цалин авч байна.

Сургуулиудын 40-60 хувь нь байгалийн ухааны хичээлийн лабораторийн туршилт хийж чадахгүй байна. Хөрөнгө оруулалт, нөөцийн хуваарилалтын тогтвортой бодлого, зохион байгуулалт муугаас шалтгаалж ижил хүчин чадал бүхий сургуулиудын сургалтын орчин ялгаатай, тэгш бус байна.

Сүүлийн 30 жилд боловсролд хуваарилсан төсвийн санхүүжилт нь зөвхөн хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарснаас чанар, үр дүнтэй уялдуулсан бодлого, хөшүүрэг харьцангуй бага хэрэгжүүлсэн нь боловсролын чанарын үзүүлэлт өсөлтгүй, зарим үзүүлэлт уналттай байна.

Боловсролын санхүүжилтийн тогтолцоо үр ашигтай байж чадаж байгаа эсэх, мэргэжлийн багшлах хүний нөөц хүрэлцээтэй байна уу? сургалтын орчин, нөхцөл тавигдаж байгаа шаардлага стандарт хангаж чадаж байна уу? гүйцэтгэлийн чанар, үр дүн ямар байна вэ? гэсэн асуултыг санхүүжилтийн нөхцөл байдалтай уялдуулан авч үздэг байх, цаашид олон улсын судалгаанд хамрагдаж өөрийн орны ерөнхий боловсролын тогтолцоог дэлхийд аль хавьцаа явааг баримжаалж мэдэх зайлшгүй шаардлагатай байна.

Боловсролын чанар, үр дүн болон хүртээмжийг тодорхойлохын тулд санхүүжилтэд нөлөөлөх хүчин зүйлсийг зөвхөн хүүхдийн тоо, барилга байгууламжийн ашиглалтаас гадна сургалтын орчин болон нийгэм эдийн засгийн олон хүчин

<sup>3</sup> НҮБХХ – Боловсролын салбарын төсвийн зарлагын хандлагын шинжилгээ. А.Заяадэлгэр

зүйлсийн нөлөөллийг тооцож, хүүхэд хаана сурч байгаагаас үл хамааран суралцах тэгш боломжоор хангагдах, улмаар чанар, үр дүнгийн гүйцэтгэлийг урамшуулж, чадварлаг багшийг дэмжсэн, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжтой байхаар төсөв, санхүүгийн шинэчлэлийг нэвтрүүлэх шаардлагатай байгаа тул боловсролын шинэчлэлийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### **Орон нутгийн соёл, нийтийн биеийн тамирын байгууллагуудын санхүүжилтийг үйлчлүүлэгчээ дагасан зарчмаар олгодог болно.**



Иргэдэд үзүүлэх соёлын болон нийтийн биеийн тамирын үйлчилгээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тохирсон байдлаар боловсруулж, байгууллагын үйл

ажиллагааг үйлчилгээ тус бүрээр нь үнэлсний үндсэн дээр санхүүжилтийн хэмжээг уян хатан байдлаар хуваарилах тогтолцоонд шилжинэ.

### **Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоог шинэчилнэ.**



Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2017 оны түвшнээс огцом нэмэгдсэн боловч хуваарилалт, зарцуулалтын үр ашиггүй байдлаас болж тодорхой үр дүн гарахгүй байна.

Хүүхэд хамгааллын төсвийн одоогийн хуваарилалтын сул тал нь хэрэгцээ шаардлагад үндэслэгдээгүй, үйлчилгээний нэр төрөл тодорхой бус байгаатай холбоотой юм. Тиймээс үйлчилгээний нэр төрөл, өртгийг нарийвчлан тогтоож үйлчилгээний чанар, хүртээмж, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах чиглэлээр холбогдох яамд хамтран ажиллаж ирэх 2022 оноос санхүүжилтийг оновчтой байдлаар дахин хуваарилахаар төлөвлөж байна.

## **Эрүүл мэндийн салбарт энэ онд хэрэгжүүлж эхэлсэн шинэчлэлийг эрчимжүүлж ИРГЭДЭЭ ЖИЛ БҮР УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ хамруулна**

### **Эрүүл мэндийн салбарт эхлүүлсэн санхүүжилтийн шинэчлэлийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ**



Эрүүл мэндийн салбарт 2021 оноос эхлүүлсэн чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан “иргэнээ дагасан” санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлж эхлээд байна. Ирэх 2022 онд шинэчлэлийг хэрэгжүүлэх чиглэлд анхаарч ажиллах ба энэ хүрээнд эрүүл мэндийн байгууллагуудын засаглалыг сайжруулах, анхан шатлалын тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, стратегийн худалдан авалтыг оновчтой болгох, үйлчилгээний чанарт тавих иргэдийн хяналт оролцоог нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх зорилт тавьж байна.

Анхан шатны болон яаралтай/түргэн тусламж үйлчилгээний зардлын тариф, түүнчлэн гэрээр болон өдрийн эмчилгээгээр эмчлэх боломжтой эмийн эмчилгээний тарифыг шинэчлэх зэргээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тохиолдлыг бууруулж зардлын үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөн удирдах зөвлөлийн

үйл ажиллагааг жигдрүүлж бүтэц, зохион байгуулалтыг эрүүл мэндийн салбарын бодлого, санхүүжилтийн бодлоготой уялдуулан оновчтой зохион байгуулах, даатгалын байгууллагаас хэрэгжүүлэх стратегийн худалдан авалтын оновчлол, сонгон шалгаруулалт ба гэрээлэлт, төлбөрийн болон чанарын хяналтыг сайжруулах зэргээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эмч, ажилчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх боломжийг бий болгоно.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хийх гол арга хэмжээний нэг бол 2022 оноос эхлэн иргэн бүрийг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах явдал юм. Өвчнийг эрт үед нь оношилж илрүүлснээр хүндэрсэн хойно нь биш, даамжрахаас нь өмнө эмчилж иргэн болон төрөөс их хэмжээний зардал гаргахаас хамгаалах болно.



**Ирэх 2022 оноос эхлэн иргэн бүрийг жилд нэг удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах арга хэмжээг эхлүүлнэ.** Манай улсын хүн амын тэргүүлэх таван өвчлөлд амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах эрхтний эмгэг, бэлгийн



замын халдварт өвчин, зүрх судас, гэмтэл, хордлого болон гаднын бусад шалтгаан багтаж байна. Нас баралтын хувьд, зүрх судас, гэмтэл, хордлого, амьсгалын тогтолцоо, хавдар, хоол боловсруулах эрхтний өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 18-аас дээш насны иргэдэд 12 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэх 43-75 мянган төгрөгийн багцыг 2018 оноос эхлэн санхүүжүүлэхээр



### **Байгалийн баялгийн хүртээмжийг нэмэгдүүлж, ирээдүй хойч үедээ өвлүүлж, санхүүгийн баталгаатай ХУРИМТЛАЛТАЙ ХҮҮХЭД хөтөлбөр хэрэгжүүлнэ**

Манай улсын хувьд төрөөс хүүхдэд мөнгөн тэтгэмж олгож хэвшсэн бөгөөд тэтгэмжийн хэмжээ, давтамж зэргийг 2006, 2007, 2009, 2012 онуудад тухай бүр өөрчилсөн бол Коронавируст цар тахлын үед хүүхэд багачуудыг хүнс, тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, телехичээл, цахим сургалтад хамрагдах боломжоор хангах зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхэд бүрд сар бүр 100.0 мянган төгрөгийг олгож байна.

Хэдийгээр цар тахлын үед дээрх арга хэмжээ нь цагаа олсон, хүртээмж, үр дүн өндөртэй байгаа боловч урт, дунд хугацаанд бэлэн мөнгө тараах халамжийн бодлогоос үе шаттайгаар татгалзаж, хүүхдийн хуримтлалын тогтолцоонд шилжих зорилт тавьж байна.



Ирээдүйн өв сангийн тухай хуульд нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ гэж, “Алсын хараа-2050” болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход шаардагдах тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасан болно.

Энэ хүрээнд байгалийн баялгаас орох орлогын хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол улсын ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай,

шийдвэрлэсэн. Гэвч 2020 оны статистикаар 18-аас дээш насны хүн амын 7.9 хувь нь тус багцын шинжилгээнд хамрагджээ. Тиймээс хамрах хүрээг өргөтгөх зорилгоор насны багцыг шинэчилж, хүн амыг жилд нэг удаа үзлэгт хамруулах ажлыг 2022 оноос эхлүүлэхээр төлөвлөв. Өвчнийг эрт үед нь оношилж илрүүлснээр хүндэрсэн хойно нь биш, даамжрахаас нь өмнө эмчилж иргэн болон төрөөс их хэмжээний зардал гаргахаас хамгаалах болно.

мэдлэг боловсролтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тус сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг арилжааны банканд дахь хүүхдийн нэрийн дансанд хуримтлуулахаар төлөвлөлөө. Ингэснээр Монгол Улсын хүүхэд бүр Ирээдүйн өв сангаар баталгаажсан, Хадгаламжийн даатгалын сангаар даатгуулсан, хамгийн эрсдэл багатай системийн нөлөө бүхий банкуудад нэрийн дансны хуримтлалтай болж, хадгалах, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас суралцахаас гадна 18 нас хүрээд нэрийн дансны хуримтлалаар өөрийн боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Ковид-19 цар тахлын нөлөө бүрэн арилаагүй шилжилтийн хугацаанд бага дунд орлоготой өрхүүд орлогын эрсдэлд орж болзошгүй тул хуримтлалд бүрэн шилжих бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хадгаламж нээлгэсэн хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч хэрвээ хүсвэл хүүхдийн нэрийн дансанд сар бүр төвлөрөх мөнгөн хадгаламжийн тодорхой хувийг бэлнээр авах боломж олгож байна. Тодруулбал, 2022 оны төсвийн жилд, 1 дүгээр сарын 1-ээс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд сар бүрийн хуримтлалыг 100,000 төгрөг хүртэл сонголтоор, харин 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 50,000 төгрөгөөс доошгүй хэсгийг хуримтлуулж үлдсэн 50,000 төгрөгийг бэлнээр буюу хүүхэд бүрд нийт 100,000 төгрөг гэсэн зарчмыг хадгална.

## Хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ шилжих шинэчлэл хийнэ.

### Нийгмийн халамжийн зарим хөтөлбөрийг нөхцөлтэй болгож халамжид хамрагдах шалгуурыг нарийвчилна.



Манай улсын нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулж нийт хүн амын 80 хувь нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг оролцуулаад ямарваа нэг тусламж, дэмжлэг хүртэж байгаа бөгөөд үүнд улсын төсвийн 30 хувийг зарцуулж байна. Халамжийн системээр олгож байгаа дэмжлэгийн 60 хувь нь хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогод хамааралтай байна. Түүнчлэн халамжийн 28 хувийг хүн амын амьжиргааны түвшин өндөртэй 40 хувь нь хүртэж байна. Иймд нийгмийн халамжийн үйлчилгээ, хүн амын өсөлтийг дэмжсэн хөтөлбөрийг зааглах, зорилтот бүлэгт чиглүүлэх, хамрагдах шалгуурыг нарийвчлах болон халамжийн зарим хөтөлбөрт хамрагдах хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжид заасан арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах нөхцөл тавьдаг болно.

Мөн эмзэг бүлгийн өрх иргэнд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар үр дүнг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ. Тухайлбал, сонгосон өрхийн

амьжиргааг дээшлүүлж тодорхой хугацааны дотор ядуурлаас гаргах зорилтод төлөвлөгөөг халамжийн байгууллага хэрэгжүүлж үүнд хөдөлмөр эрхлэлт, өрхийн аж ахуй, үйлдвэрлэл, орлогын менежмент, зан үйлийн өөрчлөлт зэрэг олон асуудлыг цогц байдлаар авч үздэг болно.

Мөн ядууралд хүргэсэн тодорхой болон давагдашгүй хүчин зүйлсийн улмаас үүссэн цочролын сөрөг нөлөөг бууруулах, нийгэмд бие даан амьдрах чадваргүй иргэдийг нийгэмшүүлэх, хөдөлмөрт бэлтгэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх зэрэг нэн шаардлагатай үйлчилгээнүүдийг нэвтрүүлэхийг зорьж байна. Халамжаас хөдөлмөрт шилжих бодлогыг эрчимжүүлэхийн тулд мэргэжлийн боловсрол сургалтын санхүүжилтийн тогтолцоог хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах шаардлагатай байна.

Үүний тулд мэргэжлийн сургалтын байгууллагын орцод суурилсан санхүүжилтийг өөрчилж хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг хүрэх үр дүнд харгалзан санхүүжүүлэх хэлбэрт шилжүүлэхээр төлөвлөж байна

## ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

### **Хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийн дагуу үнэлгээ хийгдсэн ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙГ нэн тэргүүнд хэрэгжүүлж, урсгал болон ашиглалтын зардал өндөртэй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй**

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийг бий болгоход түлхүү чиглэсээр ирсэн, энэ хүрээндээ 2022 онд эдийн засгийн хөгжлийг дэмжих томоохон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, мөн өмнөх онуудад эхэлсэн төслүүдийг бүрэн дуусгаж ашиглалтад оруулах чиглэлийг баримталаа.

Ирэх 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг энэ оны 4-р сарын 1-ээс цахим систем, аргачлалын дагуу боловсруулж, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, бэлтгэл ажил бүрэн хангагдсан төслүүдийг төсвийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн, үрэлгэн хөрөнгө оруулалтаас хөгжлийн хөрөнгө оруулалт руу шилжилт хийж, энэ хүрээнд 2021 оны түвшингөөс зам тээврийн салбарын шинэ хөрөнгө оруулалтыг 7.1 дахин, барилга байгуулалтын салбарын шинэ хөрөнгө оруулалтыг 3.7 дахин, эрчим хүчний салбарын шинэ хөрөнгө оруулалтыг 6.4 дахин их төлөвлөлөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь 2022 онд хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт байх бөгөөд дараах төслүүдийг онцолж байна. Тухайлбал,

1. Залуу гэр бүлийг орон сууцжуулах зорилтын хүрээнд: "Залуус-1" орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн шугам сүлжээ төсөлд 29.9 тэрбум төгрөг;

2. Төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд: "Аймгуудын шинэ суурьшлын бүсэд

баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц төсөлд 100.0 тэрбум төгрөг", "Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд бүтэц төсөлд 12.0 тэрбум төгрөг", "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл 45.9 тэрбум төгрөг",

3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлэх зорилтын хүрээнд: Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам, Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км авто зам, Өндөрхаан хотоос Ульхан боомт хүртэлх 254 км авто зам зэрэг төслүүдэд нийт 455.6 тэрбум төгрөг

4. Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: Хөвсгөл аймагт баригдах "Найрамдал-2" цогцолбор төсөлд 30.0 тэрбум төгрөг, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн өргөтгөлд 37.0 тэрбум төгрөг, Нийслэлийн 2 дугаар төрөх эмнэлгийн барилгад 18.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төслүүдийг тус тус онцолж хэлмээр байна.

Ирэх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 2.4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээс зам тээвэр, эрчим хүч, барилга, бүтээн байгуулалтын салбарт 1.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 2022 оны ДНБ-ийг 820 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх төсөөлөл гарч байна.

### 3. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



#### 3.1. Нэгдсэн төсвийн 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэл

Нэгдсэн төсвийн 2021 оны 8 дугаар сарын төсвийн гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 100.9 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 87.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын өмнөх үе болон 2020 оны мөн үеийн түвшнээс тус тус өссөн.

*Хүснэгт № 3. Нэгдсэн төсвийн 2021 оны 8 дугаар сарын байдлаарх гүйцэтгэл, тэрбум төгрөг*

	Төлөв.	Гүйц.	Зөрүү.
Нийт орлого	<b>9,487.1</b>	<b>9,793.0</b>	<b>306.0</b>
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	8,448.6	8,522.0	73.4
Нийт зарлага	<b>10,943.5</b>	<b>9,563.8</b>	<b>(1,396.2)</b>
Урсгал зарлага	9,402.3	8,230.7	(1,171.6)
Хөрөнгийн зарлага	1,848.6	1,217.2	(631.4)
Эргэж төлөгдөх цэвэр зээл	(307.3)	116.0	423.3
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	<b>(2,495.0)</b>	<b>(1,041.8)</b>	<b>1,453.2</b>

#### 3.2. Нэгдсэн төсвийн 2022 оны үзүүлэлтүүд

Төсвийн төсөлд Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 15.8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 33.7 хувь, нийт зарлагын хэмжээг 18.2 их наяд

төгрөг буюу 38.8 хувь, төсвийн алдагдлыг 1.3 их наяд төгрөгөөр огцом бууруулж, -2.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий -5.1 хувь байхаар төлөвлөлөө.

*Хүснэгт № 4. Нэгдсэн төсвийн үзүүлэлт, тэрбум төгрөг*

	2019 Гүйц.	2020 Гүйц.	2021 Бат.	2022 Төс.
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>12,040.3</b>	<b>10,444.2</b>	<b>13,731.7</b>	<b>16,415.1</b>
Тогтворжуулалтын сан	94.6	66.2	612.8	643.4
Ирээдүйн өв сан	1,040.2	914.1	1,062.4	-
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО</b>	<b>10,905.5</b>	<b>9,463.8</b>	<b>12,056.4</b>	<b>15,771.7</b>
Татварын орлого	9,813.2	8,511.6	10,625.9	13,941.3
Татварын бус орлого	1,092.3	952.2	1,430.5	1,830.4
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>11,661.7</b>	<b>13,904.3</b>	<b>15,748.3</b>	<b>18,158.8</b>
Урсгал зардал	8,228.6	10,828.9	12,983.7	13,307.3
Хөрөнгийн зардал	3,016.7	3,034.2	3,363.5	5,116.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	416.4	41.1	-598.9	-264.6
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ</b>	<b>-756.2</b>	<b>-4,440.4</b>	<b>-3,691.8</b>	<b>-2,387.1</b>
ДНБ-д эзлэх хувь	-2.0%	-12.0%	-8.8%	-5.1%

Эх үүсвэр: Сангийн яам

#### 3.3. Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь -2,387.1 тэрбум төгрөг байгаагаас гадаад зээлийн ашиглалтын 1,384.0 тэрбум төгрөг нь эх үүсвэртэй алдагдал юм. Түүнчлэн, Засгийн газрын тусгай сангийн

тухай хуулийн дагуу Тогтворжуулалтын санд хуримтлагдах 643.4 тэрбум төгрөг, төсвийн дэмжлэг 293.0 тэрбум төгрөг болон Засгийн газрын дотоод үнэт цаас гаргах замаар тус тус төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр тусгасан.


### 3.4. Төсвийн тусгай шаардлагад нийцсэн төсвийн төлөвлөлт

Төсвийн тусгай шаардлагад Монгол Улсын 2022 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Улсын Их Хурлаас 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу 2022 онд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг ДНБ-ий 5.1 хувиас, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл ДНБ-ий 70 хувиас ихгүй байх төсвийн тусгай шаардлагад Монгол Улсын 2022 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

**✓ Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх:** Ирэх 2022 онд нүүрс болон зэсийн баяжмалаас төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3 хувиас давахаар байгаа тул хуульд заасны дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон. Нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,306.0 ам.доллар, нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 73.4 ам.доллараар тооцлоо.


График № 20. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /2018-2022 он/, их наяд төгрөгөөр



Эх үүсвэр: Сангийн яам

**✓ Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2022 онд тухайн жилийн ДНБ-ий 5.1 хувиас илүүгүй байх:** Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,387.1 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэхээр төлөвлөлөө.

График № 21. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /2021-2014 он/, ДНБ-д эзлэх хувь



**✓ Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь ДНБ-ий 70.0 хувиас хэтрэхгүй байх:**

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 67.2 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

График № 22. Засгийн газрын өр /2021-2024 он/



Эх үүсвэр: Сангийн яам

**✓ Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь, тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунжийн аль ихээс хэтрэхгүй байх:** Тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 5.2 хувьтай, 2010-2021 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 17.9 хувьтай тус тус тэнцэж байна. 2022 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 15.3 хувь буюу тусгай шаардлагыг хангаж байна.

## 4. ТӨСВИЙН ОРЛОГО



### 4.1. Монгол Улсын 2021 оны 8 дугаар сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл



Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2021 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 9,793.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 3.2 хувь буюу 306.0 тэрбум төгрөгөөр давжээ. Ийнхүү орлогын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс өсөхөд Засгийн газраас хэрэгжүүлж буй “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр ажлын байрыг хадгалж, иргэдийн орлого нэмэгдэж, хэрэглээ өссөн нь татварын суурийг өсгөхөд голлох нөлөөг үзүүлсэн байна. Тухайлбал, энэ оны эхний 8 сарын байдлаар нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс даруй 31.7 хувиар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний үнийн өсөлттэй холбоотойгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого болон уул уурхайн салбараас хамаарсан бусад орлого нэмэгдсэн нь орлогын өсөлтөд нөлөөлжээ.


### 4.2. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого



Ирэх онд Засгийн газар гадаад худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал, бүтцийн өөрчлөлт, ногдол ашгийн бодлогыг хэрэгжүүлж, татвар, гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлснээр нэгдсэн төсвийн нийт орлогыг энэ оны батлагдсан дүнгээс 2.7 их наяд төгрөг буюу 19.5 хувиар нэмэгдүүлэн 16.4 их наяд төгрөг байхаар тооцлоо. Үүнээс 643.4 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлнэ.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу тооцсон тэнцвэржүүлсэн нийт орлого 2022 онд 15.8 их наяд төгрөгт хүрэхээр байна. Үүний 88.4 хувь буюу 13.9 их наяд төгрөгийг татварын орлого, 11.6 хувь буюу 1.8 их наяд төгрөгийг татварын бус орлого бүрдүүлнэ.

График № 23. Нийт орлого ба тусламжийн дүн, их наяд төгрөг



Хүснэгт № 5. 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого

ҮЗҮҮЛЭЛТ	тэрбум ₮
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>16,415.1</b>
Тогтворжуулалтын сан	643.4
<b>Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн</b>	<b>15,771.7</b>
<b>1.Татварын орлого</b>	<b>13,941.3</b>
1.1.Орлогын албан тавар	2,926.0
1.2.Нийгмийн даатгалын орлого	2,987.5
1.3.Хөрөнгийн албан татвар	213.4
1.4.Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,441.8
1.5.Онцгой албан тавар	1,132.2
1.6.Тусгай зориулалтын орлого	17.2
1.7.Гадаад үйл ажиллагааны орлого	1,081.9
1.8.Бусад татвар	2,141.3
<b>2.Татварын бус орлого</b>	<b>1,830.4</b>
2.1.Нийтлэг татварын бус орлого	1,531.7
2.2.Тусламжийн орлого	298.5

### 4.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого



Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу ээс, нүүрснээс 2022 оны төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын гурваас дээш хувийг бүрдүүлэх тул эдгээр бүтээгдэхүүн гол нэр төрлийн эрдэс баялагт тооцогдож байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасны дагуу тооцоход 2022 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 6,306.0 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 73.4 ам.доллар байна.



Ирэх онд зэсийн зах зээлийн үнэ 8,915.6 ам.доллар буюу тэнцвэржүүлсэн үнээс 41.4 орчим хувиар их байх төлөвтэй байна. Улмаар Төсвийн тогтворжуулалтын санд 2022 онд зэсийн орлогоос 381.3 тэрбум төгрөг, нүүрсний орлогоос 262.1 тэрбум төгрөг, нийт 643.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

#### 4.4. Уул уурхайн салбарын орлого



Засгийн газар хилийн нэвтрүүлэх хүчин чадал, экспортыг нэмэгдүүлэх бодлогыг эрчимжүүлэн ажиллана. Энэ хүрээнд голлох хилийн боомтод ухаалаг гарц, гаалийн лаборатори, дээж авагч, өндөр хүчин чадлын рентген суурилуулж, хил нэвтрэх үйл ажиллагаа, гаалийн байгууллагын үйлчилгээг шуурхай, цахим болгох арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед экспортыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 185 дугаар тогтоолоор нүүрсний экспорт бүхий хилийн боомт, улсын хилийн бүс, зурвас газруудад чингэлэгт тээврийн терминал байгуулах шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхэд бэлэн болоод байна. Энэ нь нүүрсний тээвэр, хилийн хяналтын үйл ажиллагааг хялбаршуулж, экспортыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.



Дээрх арга хэмжээний үр дүнд уул уурхайн салбарын орлого 2022 онд 4.3 их наяд төгрөгт хүрч, төсвийн нийт орлогын 26 орчим хувийг бүрдүүлнэ.

График № 24. Уул уурхайн болон бусад салбараас төвлөрүүлэх орлого, их наяд төгрөг



Нүүрсний экспортын гарц нэмэгдэж, ирэх онд 36.7 сая тонн нүүрс экспортолно гэж үзлээ.

Зэсийн зах зээлийн үнийг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагын

төсөөлөлд үндэслэн тонн тутамд 8,915.6 ам.доллар, зэсийн баяжмалын экспортын хэмжээг 1.2 сая тонн байхаар тооцлоо. Уул уурхайн салбарын орлогыг бүтээгдэхүүнээр задлан харуулбал:

Хүснэгт № 6. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө, тэрбум төгрөг


Үзүүлэлт	Зэс	Нүүрс	Алт	Бусад	Нийт
АМНАТ	958.1	799.0	166.8	227.7	2,151.7
ААНОАТ	248.3	464.3	50.0	190.4	953.1
Ногдол ашиг	238.8	138.1	-	28.0	419.5
Гаалийн татвар, хураамж	177.8	73.3	-	63.2	314.4
Бусад	213.0	119.3	18.8	86.6	423.1
<b>Нийт</b>	<b>1,836.2</b>	<b>1,594.0</b>	<b>235.7</b>	<b>596.0</b>	<b>4,261.8</b>

#### 4.5. Эдийн засаг дахь татварын ачаалал болон татварын орчин



Олон улсын жишигт татварын орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар эдийн засаг дахь татварын ачааллыг тооцдог бөгөөд манай улсын хувьд 2022 онд 31.2 хувь байгаа нь дэлхийн дундаж түвшинтэй ойролцоо байна.

График № 25. Татварын хувь хэмжээ /улсуудаар/, хувь



Эх үүсвэр: tradingeconomics.com

Дэлхийн 112 улс орнуудын аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг харьцуулсан судалгаанаас<sup>4</sup> үзэхэд Монгол Улс татвар багатай улсын ангилалд орж байна. Тухайлбал, өрхийн орлого, иргэдийн амьжиргаанд гол нөлөөлөл үзүүлдэг хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ манай улсын хувьд бусад

<sup>4</sup> www.tradingeconomics.com

улсуудтай харьцуулахад бага байгаа нь уг судалгаанаас харагдаж байна.

*Хүснэгт № 7. Олон улсын дундаж татварын хувь хэмжээ*


Үзүүлэлт	ХХОАТ	ААНОАТ	НӨАТ
Дундаж /татварын хувь хэмжээ/	30	23	16
Монгол Улс /татварын хувь хэмжээ/	10	10/25	10

## 4.6. Татварын орлого



Ирэх онд татварын нийт орлогыг энэ оны батлагдсан дүнгээс 31.2 хувиар нэмэгдүүлэн 13.9 их наяд төгрөгт хүрнэ гэж тооцлоо. Үүнээс 24.7 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 21.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 21.0 хувийг орлогын албан татвар, 8.1 хувийг онцгой албан татвар, үлдсэн хэсгийг бусад татвар эзэлж байна.

*График № 26. Татварын орлогын бүтэц, хувь*



Ирэх 2022 онд Оюутолгойн далд уурхай, Тавантолгойн цахилгаан станц, Газрын тосны бүтээгдэхүүн дамжуулах хоолой, Богдхан төмөр зам, улсын чанартай томоохон төмөр зам, авто замын төслүүдийг хэрэгжүүлж эхлүүлэхээр тооцсон болно.

### 4.6.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар




Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын төсөөллийг макро эдийн үндсэн үзүүлэлтүүд болон уул уурхайн гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, аж ахуйн нэгжийн тайлангийн үзүүлэлтэд үндэслэн ирэх онд 2,015.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.



Ирэх онд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сэргэж, уул уурхайн гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнэ, биет


хэмжээ өсөх хандлагатай байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн 46.8 их наяд төгрөгт, эдийн засгийн бодит өсөлт 5.0 хувь, экспортын хэмжээ 8,760.0 сая ам долларт хүрэхээр байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын өсөлтөд голлон нөлөөлөхөөр байна.

*График № 27. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого /уул уурхай, уул уурхайн бус салбараар/, тэрбум төгрөг*



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш үүссэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын үйл ажиллагааны орлогын 40 хувийг харьяа аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлнэ. Улмаар ирэх онд 588.2 тэрбум төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжихээр тооцлоо. Үүний дийлэнх хэсэг буюу 40.9 хувийг Улаанбаатар хотод, 33.6 хувийг Өмнөговь аймагт, 11.6 хувийг Орхон аймагт тус тус хуваарилахаар байна.

*График № 28. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах бүтэц, хувь*



Өнгөрсөн 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу жижиг, дунд бизнес эрхлэгчдэд татварын томоохон дэмжлэгүүдийг үзүүлж байна.





Тухайлбал, 50 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж өөрийн хүсэлтээр жилд нэг удаа тайлан гаргаж, борлуулалтын орлогын 1 хувиар татвар төлөх, 300 сая төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж ашгийн 1 хувиар татвар төлөх бол жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэлх борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн төлсөн татварын 90 хувийг буцаан олгоно.



Ингэснээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын буцаан олголтын хэмжээ ирэх онд 120 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо. Өнгөрсөн жилийн татварын тайлангийн мэдээгээр жилийн 1.5 тэрбум төгрөг хүртэл борлуулалттай аж ахуйн нэгжийн тоо 128.7 мянга буюу нийт тайлан ирүүлсэн татвар төлөгчийн 96.7 хувийг эзэлж байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын буцаан олголт өсөхөд голлон нөлөөлж байна.



Татварын шинэчлэлийн хүрээнд татвараас зайлсхийх явдлын эсрэг олон улсын түгээмэл дүрмийг нэвтрүүлсэн.



Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа үндэстэн дамнасан групп компани үнэ шилжилтийн тайланг гаргаж, үүнд татварын алба хяналт тавьж, татвараас зайлсхийх явдлыг хязгаарлан татварын суурийг хамгаална. Өнгөрсөн оны байдлаар үнэ шилжилтийн ажил гүйлгээний тайланг 54,462 аж ахуйн нэгж, дотоод үнэ шилжилтийн тайланг 5,226 аж ахуйн нэгж, ерөнхий үнэ шилжилтийн тайланг 5,142 аж ахуйн нэгж, улс бүрээр үнэ шилжилтийн тайланг 6 аж ахуйн нэгж гаргаж татварын албанд хүргүүлсэн байна.

#### 4.6.2 Хувь хүний орлогын албан татвар




Цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор Засгийн газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд дундаж цалингийн хэмжээ 2021 онд харьцангуй тогтвортой байсан ба ирэх онд хувь хүний орлогын албан татварын орлогыг 2021 оны түвшнээс 13.8 хувиар өсгөж 1,205.1 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.17-д заасны дагуу Хувь хүний орлогын

албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татварын орлого нь аймаг, нийслэлийн орлогоос сум, дүүргийн орлого руу шилжсэн.

График № 29. Хувь хүний орлогын албан татварын орлого, тэрбум төгрөг



#### 4.6.3 Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар



Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, цахим төлбөрийн баримтын системийн хамрагдалтын түвшин, өмнөх жилүүдийн гүйцэтгэл зэргийг харгалзан 2022 онд дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого энэ оны батлагдсан дүнгээс 17.7 хувиар өсөж 1,495.0 тэрбум төгрөгт хүрэхээр байна.



Засгийн газар экспортыг нэмэгдүүлэх, Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц хөтөлбөр зэрэг эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлсний үр дүнд нэмэгдсэн өртгийн албан татварын хамрагдалт нэмэгдэнэ.

График № 30. НӨАТ-ын татвар төлөгч болон орлого



Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем, цахим төлбөрийн баримтын системийн шинэ хувилбаруудыг нэвтрүүлэн, ашиглахад илүү энгийн хялбар болгож, хамрах хүрээг өргөтгөх бодлогын үр дүнд далд эдийн засаг буурч, татварын бүртгэл, хяналтын тогтолцоо эрс


сайжирснаар нэмэгдсэн өртгийн албан татварын орлого сүүлийн 3 жилд дунджаар 25 хувиар өссөн байна. Тухайлбал, цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн баримтын тоо энэ оны эхний 8 сарын байдлаар 403.2 саяд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 21.4 хувиар өссөн байна.

#### 4.6.4 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар



Автобензин, дизелийн түлшний хэрэглээ, импорт болон үнийн хандлага зэрэгт үндэслэн ирэх онд автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлогоор 400.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

График № 31. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлого, тэрбум төгрөг




#### 4.6.5. Суудлын автомашины онцгой албан татвар

Монгол Улсад импортолж байгаа нийт тээврийн хэрэгслийн 70 орчим хувийг хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин эзэлж байна.

Суудлын автомашины импорт, импортолсон автомашины насжилт, хөдөлгүүрийн багтаамж зэргийг харгалзан ирэх онд суудлын автомашины онцгой албан татварын орлогоор 260.0 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

График № 32. Суудлын автомашины импортын тоо



Эх үүсвэр: ГЕГ-ын статистик мэдээ

#### 4.6.6 Согтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар



Согтууруулах ундаа, тамхины хэрэглээний түвшин, орлогын гүйцэтгэл зэргийг үндэслэн 2022 онд согтууруулах ундаа, тамхинд ногдуулах онцгой албан татварын орлогоор 472.2 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо. Энэ нь 2021 оны батлагдсан хэмжээнээс 12.6 хувиар нэмэгдэхээр байна.


Бараа, бүртгэлийн нэгдсэн системээр дамжуулан иргэд тамхи, согтууруулах ундаа зэрэг онцгой албан татвартай барааны гарал үүсэл, импортолсон, үйлдвэрлэсэн хугацааны мэдээллийг хянах боломжтой болсноор иргэдийн эрх гийнашгийг хохироосон хуурамч бүтээгдэхүүн худалдаалагдахаас сэргийлж байна.

#### 4.6.7 Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого



Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, импортын барааны бүтцийн өөрчлөлт болон өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэлийн хэмжээтэй уялдуулан ирэх онд гаалийн албан татварын орлогоор 1,081.9 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 2,216.8 тэрбум төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлнэ.

График № 33. Импортын гаалийн болон НӨАТ, тэрбум төгрөг



#### 4.6.8. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр



Олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан эрдэс бүтээгдэхүүний үнийн таамаглал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгжийн 2022 оны олборлолтын төлөвлөгөө, өмнөх онуудын гүйцэтгэл зэрэгт үндэслэн ирэх онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 2,151.7 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.



Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 44.5 хувь буюу 958.1 тэрбум төгрөгийг зэсийн баяжмалаас, 37.1 хувь буюу 799.0 тэрбум төгрөгийг нүүрснээс, 7.8 хувь буюу 166.8 тэрбум төгрөгийг алтнаас төвлөрөх орлого эзэлж байна.

Ирэх онд нүүрсний экспорт 36.7 сая тонн, зэсийн баяжмалын экспорт 1.2 сая тонн, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаах алтны хэмжээ 20.0 тонн байхаар, харин коксжих нүүрсний үнэ тонн тутамд 128.7 ам.доллар, зэсийн үнэ тонн тутамд 8,915.6 ам.доллар, алтны үнэ унц тутамд 1,821.0 ам.доллар байхаар тус тус төсөөллөө.

Засгийн газрын 2021 оны 174 дүгээр тогтоолын дагуу экспортын нүүрс болон төмрийн хүдэр, баяжмалын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдох борлуулалтын үнэлгээг жишиг үнээр тооцож ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөсөн болно.

#### 4.6.9 Агаарын бохирдлын төлбөр



Агаарын бохирдлын төлбөрийн орлогыг ирэх онд 45.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Үүний 95.5 орчим хувь буюу 43.0 тэрбум төгрөгийг олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөрөөр, үлдсэн 2.0 тэрбум төгрөгийг автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийнд ногдуулах төлбөрөөр тус тус төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

#### 4.6.10 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар



Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого ирэх онд 158.5 тэрбум төгрөгт хүрч, энэ оны батлагдсан хэмжээнээс 25.2 хувиар өсөхөөр тооцлоо.

График № 34. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого, тэрбум төгрөг



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.16-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого нь аймаг, нийслэлийн орлогоос сум, дүүргийн орлого руу шилжсэн. Иймд ирэх 2022 онд үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг сум, дүүргийн татварын орлого болохоор тооцлоо.

#### 4.6.11 Газрын төлбөрийн орлого



Улсын хэмжээнд олгогдсон газрын эрхийг бүрэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн сан үүсгэн, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахимжуулах замаар газрын төлбөрийг бүрэн хураах цогц бодлогын арга хэмжээг Засгийн газар шат дараалан авч хэрэгжүүлж байна.




Уг бодлогын арга хэмжээний үр дүнд 2021 оны хагас жилийн байдлаар газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй 362 мянган нэгж талбараас 350.5 буюу 96.7 хувийг бүрэн бүртгэж, газрын төлбөрийн ногдуулалт хийсэн байна.



Түүнчлэн, иргэн, аж ахуйн нэгжид газрын төлбөрийг е-баримтын төлбөрийн систем ашиглан цахимаар төлөх боломж олгож, татвар төлөгчдийн цаг, зардлыг хэмнэх технологийн шийдлийг энэ оноос бүрэн нэвтрүүлэн амжилттай хэрэгжүүлж байна.

Ирэх онд газрын бүртгэл, төлбөр ногдуулалт, хураалтыг улам сайжруулж, газрын төлбөрийн орлогоор 182.6 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцов.

График № 35. Газрын төлбөрийн орлого, тэрбум төгрөг



Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.14-д заасны дагуу газрын төлбөрийн

орлого нь аймаг, нийслэлийн орлогоос сум, дүүргийн орлого руу шилжсэн. Иймд ирэх 2022 онд газрын төлбөрийн орлогыг сум, дүүргийн татварын орлого болохоор тооцлоо.

#### 4.6.12 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр



Монгол Улсын хэмжээнд 2021 оны хагас жилийн байдлаар 6.2 сая га талбайд ашигт малтмалын ашиглалтын 1,722, хайгуулын 899, нийт 2,621 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд үндэслэн ирэх онд тусгай зөвшөөрлийн төлбөрөөр 31.4 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр тооцсон.

#### 4.7. Татварын бус орлого

Ирэх онд нийт татварын бус орлогыг 1,830.4 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Үүний 25.4 хувийг ногдол ашгийн орлого, 16.4 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 16.3 хувийг тусламжийн орлого, 15.2 хувийг газрын тосны орлого, 8.2 хувийг навигацыйн орлого тус тус эзэлж байна.

##### 4.7.1 Газрын тосны орлого

Монгол Улсын Засгийн газраас нийт 25 талбайд 21 гэрээлэгч аж ахуйн нэгжтэй бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

График № 36. Газрын тосны экспортын хэмжээ, үнэ



Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс “Петрочайна дачин тамсаг” ХХК нь “Тосон-Уул 19”, “Тамсаг 21” талбайд, “Доншен газрын тос” ХХК нь “Зүүнбаян 97” талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Нийт газрын тосны 93 гаруй хувийг “Петрочайна дачин тамсаг” ХХК, 7 орчим хувийг “Доншен газрын тос” ХХК экспортолж байна. Ирэх онд газрын тосны нийт экспортын хэмжээг 6.3 сая баррель, нэг баррель газрын

тосны үнийг 65 орчим ам.доллар байхаар төсөөлж нийт 277.5 тэрбум төгрөгийг газрын тосны орлогоор төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

#### 4.7.2 Навигацийн орлого



Ирэх онд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөө аажмаар буурч, олон улсын нислэгийн тоо 2021 оны төвшнөөс өсөхөөр Олон улсын агаарын тээврийн холбоо (IATA)-оос таамагласныг үндэслэн манай улсын газар нутаг дээгүүр дамжин өнгөрөх, буух, хөөрөх агаарын тээврийн хэрэгсэлд үзүүлэх навигацыйн үйлчилгээний орлогоор улсын төсөвт 150.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ гэж тооцлоо.

#### 4.7.3 Хувьцааны ногдол ашиг



Төрийн өмчийн хуулийн этгээдүүдийн ногдол ашгийн бодлогын шинэчлэлийн хүрээнд төрийн өмчит компаниуд ашигтай ажилласан эсэхээс үл хамаарч тодорхой бодлогоор ногдол ашиг хэлбэрээр төрийн өмчийн өгөөжийг төсөвт жил бүр төвлөрүүлж ажиллана.

Үүний дагуу олон улсын гэрээ болон тусгайлсан хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, ашигтай ажиллах боломжгүй, үнэ тарифыг төрөөс зохицуулдаг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс бусад этгээд нь ногдол ашиг хуваарилахдаа санхүүгийн тайлант жилийн цэвэр ашгийн хэмжээнээс үл хамаарч цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувийн аль их дүнгээр ногдол ашиг тооцно. Ингэснээр ирэх 2022 онд 464.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг Ирээдүйн өв сан болон улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

#### 4.8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт



Татварын шинэчлэлийн хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж татвараа тайлагнаж төлсний дараа төлсөн татварыг буцаан олгох замаар татварын хөнгөлөлт эдлүүлэх бодлогыг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бүртгэл, ангилал, тайлагналыг олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн Дэлхийн банктай хамтран 2019 онд Сангийн сайдын баталсан “Татварын

зарлагад шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-ын дагуу 2022-2024 оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төсөөллийг тооцлоо.

Татварын хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нийт татварын орлогод эзлэх хувь хэмжээ 2022 онд 5.2 хувь, 2023 онд 5.1 хувь, 2024 онд 5.0 хувь болж жил дараалан буурахаар байна.

*Хүснэгт № 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ, тэрбум төгрөг*

Үзүүлэлт	2022 Төс	2023 Төс	2024 Төс
<b>Татварын орлогод эзлэх хувь</b>	<b>5.2</b>	<b>5.1</b>	<b>5.0</b>
<b>Хөнгөлөлт, чөлөөлөлт</b>	<b>751.3</b>	<b>808.0</b>	<b>861.4</b>
ААНОАТ	228.3	246.4	255.6
НӨАТ	166.2	181.5	198.4
Гааль	23.1	26.2	30.2
ХХОАТ	203.9	219.0	236.0
ОАТ	129.8	134.9	141.2


## 5. УРСГАЛ ЗАРЛАГА



### 5.1. 2022 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм

Ирэх 2022 онд урсгал төсөв нийт дүнгээрээ 2021 оны түвшинээс 1.4 хувиар өсөж байгаа нь өмнөх жилүүдийн дундаж өсөлттэй харьцуулахад 10 дахин буурч байна.

График № 37. Урсгал зардлын өсөлт /их наяд төг, хувиар/



Бүтцийн хувьд авч үзвэл цалин хөлс 41 хувиар, нийгмийн халамжийн шилжүүлэг 81 хувиар буурч байгаа бол хувийн хэвшилд шилжүүлэх ажил үйлчилгээний төлбөр 16 хувиар, нийгмийн суурь үйлчилгээг үр дүнд суурилсан санхүүжилтийн зарчмаар хуваарилах зардал 2.4 дахин, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал тус бүр 6 хувиар тус тус өсөж байна.

График № 38. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар/



#### 2022 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан БОДЛОГО:

- Хувийн хэвшилээр гүйцэтгүүлэх боломжтой зарим ажил, үйлчилгээг төр өөрөө хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж орон тоо, урсгал зардлын өсөлтийг бууруулна.
- Боловсрол, соёл, спорт, хүүхэд хамгааллын салбарт санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлж, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлнэ
- КОВИД-19 цар тахлын эрсдэлтэй нүүр тулж ажиллаж байгаа төрийн байгууллагаас бусад төсөвт байгууллагын тэвчиж болох урсгал зардлыг бууруулж хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллана.
- Нийгмийн халамжийн тогтолцоог шинэчилж хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулна
- Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ болон төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулж, эдгээртэй холбоотой орон тоо, урсгал зардлыг бууруулж, иргэдийн цагийг хэмнэнэ.
- Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2021 оны түвшинд хадгална.

#### 2022 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан ЗАРЧИМ:

- **Үр ашигтай байх:** Санхүүжилтийн механизмыг нь өөрчлөх замаар нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг салбаруудад тогтолцооны шинэчлэл хийж төсвийг нь дахин хуваарилж, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.
- **Ил тод, шуурхай байх:** Бүх салбарын төрийн үйлчилгээг цахимжуулж, мэдээллийг ил тод, ойлгомжтой болгоно. Иргэд хүргэх төрийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй хүргэнэ.
- **Хэмнэлттэй байх:** Ухаалаг, хэмнэлттэй техник технологийн дэвшлийг ашиглан бүх шатны төсвийн байгууллагын захиргааны удирдлага, үйлчилгээ болон хөрөнгийн ашиглалтын зардлыг бууруулна

Үр дүн, чанарт суурилсан төрийн үйлчилгээний санхүүжилтийн хуваарилалтын шинэчлэл, халамжийн тогтолцооноос олгодог байсан хүүхдийн мөнгийг Хуримтлалтай Монгол хүүхэд хөтөлбөрт шилжүүлэхээр тооцсон нь

нэгдсэн төсвийн урсгал зардлын өөрчлөлтөд голлон нөлөөлж байна.

## 5.2. Эрүүл мэнд



### Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

Эрүүл мэндийн салбарт чанар, үр дүн, гүйцэтгэлд суурилсан “иргэнээ дагасан” санхүүжилтийн тогтолцоог энэ оноос хэрэгжүүлж эхлүүлээд байна. Уг шинэчлэлийг 2022 онд үргэлжлүүлж тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас нэг худалдан авагчийн зарчмаар санхүүжүүлэхэд улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэх хөрөнгийг төсөвт тусгалаа.

Ингэснээр эрүүл мэндийн салбарт санхүүжилтийн хуваарилалтын бодлогоор дамжуулан иргэнд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх зорилтыг хангах болно.



### Эрүүл мэндийн байгууллагуудын засаглалыг сайжруулна.

Эхлүүлсэн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхэд гүйцэтгэл, үр дүнгээр тооцож санхүүжилтээ авах эрүүл мэндийн байгууллагын менежментийг сайжруулах шаардлагатай байна. Үүний тулд Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд заасан эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлүүдийг байгуулж, чадавхыг нь сайжруулахад анхаарна. Ингэснээр эрүүл мэндийн байгууллагууд өөрсдөө бие даан төсвөө захиран, зарцуулах, бүтэц орон тоог салбарын хэмжээнд баримталж байгаа бодлоготой уялдуулан зохион байгуулах, эмч, ажилчдын цалин хөлсийг чанар, үр дүн, гүйцэтгэлээр олгох боломж бүрдэх юм.



### Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнг хянаж үнэлэх чадавхыг сайжруулна.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэл иргэнд бодитойгоор хүрч байгаа эсэхийг тодорхойлох нь хэрэгжүүлэлтийн үед хийгдэх чухал ажил юм. Иймд эрүүл мэндийн байгууллагын үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэхэд техник технологийн дэвшлийг ашиглах зэргээр эрүүл мэндийн байгууллага, иргэдийн хяналт оролцоог сайжруулна.



### Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын нийгмийн баталгаа

Эрүүл мэндийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулийн дагуу тэтгэвэрт

гарах 1121 хүнд олгох нэг удаагийн тэтгэмж болон өрх, сум, тосгоны эмнэлэг, аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа эмнэлгийн болон эмнэлгийн бусад мэргэжилтэнд 3 болон 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж авах 4558 хүний тэтгэмжийн зардлыг тус тус тусгав.



### Эмийн хяналт, зохицуулалтын удирдлагыг сайжруулна.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд эмийн хяналт, зохицуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор эмийн хяналт, зохицуулалтын агентлагийг байгуулсан. Мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллаж байгаа эмийн хяналтын байцаагч, эмийн хяналтын лабораторийн ажилтан нийт 52 албан хаагчийг эмийн хяналт, зохицуулалтын агентлагийн харьяанд ажиллуулах шийдвэр гарсны дагуу холбогдох зардал, орон тоог шилжүүлэхээр тооцов.



### Ковид-19-ийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний зардлыг үргэлжлүүлэн санхүүжүүлнэ.

Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2021 оны А/387/99 дугаар хамтарсан тушаалаар Ковид-19 цар тахлын халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, эмчлэх, вирусийн эсрэг дархлаажуулах арга хэмжээг цогц байдлаар харж, санхүүжилтийг нь улсын хэмжээнд оновчтой хуваарилах зохицуулалт болон цар тахлын эсрэг хэрэгжүүлэх тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээг баталсан.

*Хүснэгт № 9. Ковид-19 халдварыг эмчлэх тусламж үйлчилгээний тариф (мянган төгрөг)*

Тусламж үйлчилгээний багц	Тариф
Тандалтын ПГУ сорьц цуглуулах	5.0
Хөнгөн тохиолдлыг ӨЭМТ-ын хяналтад гэрээр эмчлэх	160.0
Хөнгөн тохиолдлыг тусгаарлан эмчлэх	780.0
Хүндэвтэр тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх	2,180.0
Хүнд тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх	4,200.0
Маш хүнд тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх	7,440.0
Вакцинжуулалт	5.0
Тандалтын сорьцод ПГУ Cov-SARS 2 шинжилгээ хийх	50.0

Ковид-19 вирусийн халдвараар өвчилсөн хүний эмчлэх тарифыг хүндрэлийн зэргээс нь

хамааруулан ялгаатай тогтоож төр, хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагад гүйцэтгэлээр нь санхүүжүүлж байна. Гэвч хөнгөн хэлбэрийн халдварыг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж байгаа нь орны ачааллыг нэмэгдүүлж, санхүүжилтийг үр ашиггүй болгох тохиолдлууд байсаар байна.

Тиймээс халдварт өртсөн хүнд тусламж үйлчилгээ үзүүлэх зураглалыг тодорхой болгох, дуудлага хүлээн авч хүндрэлийн зэргийг тодорхойлох, зөвлөгөө өгөх, хэвтүүлэн эмчлэх шаардлагатай өвчтөнийг эмнэлэгт хуваарилах үүрэг бүхий зохицуулалтын нэгдсэн төвийг түр хугацаанд дотоод нөөц боломждоо тулгуурлан зохион байгуулах, өрхийн эмнэлгээр үзүүлэх тусламж үйлчилгээний жишиг багц, зааврыг иргэдэд ойлгомжтой байдлаар бэлтгэж хүргүүлэх, эхний ээлжид өрхийн эмнэлгээр үзүүлсэн тусламж үйлчилгээний төлбөрийн баталгаажуулалтыг ЭМД-ын байгууллагаас иргэний гар утасны автоматаар хүргүүлдэг байх зэргээр тусламж үйлчилгээний хяналт, үр дүн, санхүүжилтийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.



### Иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

Манай улсын хүн амын тэргүүлэх таван өвчлөлд амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах эрхтний эмгэг, бэлгийн замын халдварт өвчин, зүрх судас, гэмтэл, хордлого болон гаднын бусад шалтгаан багтаж байна. Нас баралтын хувьд, зүрх судас, гэмтэл, хордлого, амьсгалын тогтолцоо, хавдар, хоол боловсруулах эрхтний өвчлөл тэргүүлэх шалтгаан болж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 18-аас дээш насны иргэдэд 12 төрлийн оношилгоо, шинжилгээ хийлгэх 43-75 мянган төгрөгийн багцыг 2018 оноос эхлэн санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Гэвч 2020 оны статистикаар 18-аас дээш насны хүн амын 7.9 хувь нь тус багцын шинжилгээнд хамрагджээ. Тиймээс хамрах хүрээг өргөтгөх зорилгоор насны багцыг шинэчилж, хүн амыг жилд нэг удаа үзлэгт хамруулах ажлыг 2022 оноос эхлүүлэхээр төлөвлөв. Өвчнийг эрт үед нь оношилж илрүүлснээр хүндэрсэн хойно нь биш, даамжрахаас нь өмнө эмчилж иргэн болон төрөөс их хэмжээний зардал гаргахаас хамгаалах болно.


## 5.3. Боловсрол



### Ерөнхий боловсролын шинэчлэл:

Өнөөдөр нэг суралцагчид ногдох зардал байршил, хүн амын төвлөрөл болон сургуулийн хэв шинжээс хамаарч ихээхэн хэлбэлзэлтэй байна.

График № 39. Нэг хүүхдэд ногдох урсгал зардал, сургуулийн хэв шинжээр /сая төгрөг/



Нэг хүүхдийг сургаж буй дундаж урсгал зардал ихээхэн хэлбэлзэж байгаад сургалтын хөтөлбөрийн онцлог, байршил, хэв шинж болон сургуулийн хүртээмжээс хамааран багш-сурагчийн тооны харьцаа, нэг бүлэгт хуваарилагдах хүүхдийн тоо болон барилга байгууламжийн хүчин чадлын ашиглалт, сургалтын орчин, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний хүрэлцээтэй байдал зэрэг хүчин зүйл ихээхэн нөлөөлж байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд суралцагчийн сурлагын чанар, үр дүнд чиглэсэн санхүүжилтийн тогтолцоог бий болгоно. Сургалтын хөтөлбөр, хичээл бүрийн бодит өртгийг тооцож, сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байгаа суралцагчийн тоотой уялдуулсан хувьсах зардлын санхүүжилтийг ерөнхий боловсролын сургуулиудад олгоно. Хувьсах зардлын бүрэлдэхүүнд сургалтын орчин, тоног төхөөрөмж, материалын зардлыг шингээж, багшийн тухайн хичээлийн хүрээнд ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Ерөнхий боловсролын сургуулийг төсвийн хагас бие даасан тогтолцоонд шилжүүлж, сургуулийн удирдлагад өөрийн сургалтын орчин нөхцөл, сургалтын чанарыг сайжруулахад зориулж санхүүгийн эрх мэдлийг олгох бөгөөд үйл ажиллагаанд нь эцэг эх, багш, ажиллагчдаас бүрдсэн зөвлөлөөр дамжуулж төсвийн болон үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлнэ.





Суралцагчдын ахиц дэвшлийн үнэлгээг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар хэмждэг үнэлгээний хараат бус, бие даасан тогтолцоог бий болгож, сургуулиудын санхүүжилтийг тус үнэлгээний үр дүнтэй уялдуулна. Багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын ахиц дэвшлээр хэмжиж, түүнд тохирсон цалин, урамшууллыг олгох тогтолцоог бий болгоно. Ингэснээр ур чадвартай, сурган хүмүүжүүлэх арга барил сайтай багш өөрийн хөдөлмөрийг шударгаар үнэлүүлж, түүндээ тохирсон цалин, урамшууллыг авах нөхцөл бүрдэнэ.



Сурлагын ахиц дэвшлийг үнэлэх болон ЕБС-н төгсөх ангийн суралцагчдаас авдаг ЭЭШ-ийг зохион байгуулдаг Боловсролын үнэлгээний төвийн тогтолцоог цаашид хараат бус, бие даасан хэлбэрээр улам бэхжүүлж, санхүүжилт олгодог, гүйцэтгэлд хяналт тавьдаг бүтцээс тусад нь хөгжүүлнэ.

Цаашлаад Монгол сурагчид олон гадаадын бусад улсуудын сурагчидтай харьцуулахад аль түвшинд байгааг мэдэхийн тулд Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын гишүүн орнуудын сурагчдын суурь боловсролын түвшинд эзэмшсэн чадварыг үнэлдэг Суралцагчдын үнэлгээний олон улсын судалгаа /PISA-Program for International Student Assessment/-нд туршилтын байдлаар хамрагдах зорилготой байна.

**Ерөнхий боловсролын сургуулиудын бүтэц, байршил, хэв шинжийг газар зүйн мэдээллийн систем /GIS/-ийн тусламжтайгаар оновчтой тогтооно:**




Газарзүйн мэдээллийг цуглуулах, хадгалах, шинжлэх, харуулах зориулалт бүхий GIS системийг боловсролын мэдээллийн системтэй холбож, боловсролын макро түвшний төлөвлөлт, шийдвэр гаргалтдаа ашигладаг болно.

Зарим хөдөөгийн сумдын сургуулиудын хувьд бүлэг дүүргэлт бага, нарийн мэргэжлийн багш хүрэлцээгүй, сургалтын хэрэглэгдэхүүний зардал хангалтгүй бөгөөд хуваарилагдсан төсвийн дийлэнх нь барилгын ашиглалтын зардлаа санхүүжүүлэхэд зарцуулж байна. Ийм тохиолдолд хүртээмжийг хангаж байна гэж үзэж болох боловч хүүхдэд олгож байгаа

боловсролын чанарын хувьд хангалтгүй байсаар байна.

График № 40. ЕБС-н бүлэг дүүргэлт ба нэг сурагчид ногдох зардлын хамаарал /2021 он/



Харин эсрэгээрээ нийслэлийн зарим өндөр ачаалалтай сургуульд нэг ангид 50-60 хүүхэд суралцдаг бөгөөд энэ тохиолдолд багш хүүхдэд бүрд хүрч ажиллах боломжгүй болдог бөгөөд энэхүү багшийн хүртээмжгүй байдал нь мөн л сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх шалтгаан болж байна.

Түүнчлэн нийслэлийн зарим томоохон сургуульд хамран сургах тойргийн биш хүүхдүүд хотын өнцөг булан бүрээс ирж суралцдаг нь хотын түгжрэлийн нэг шалтгаан болж байна. Тухайлбал нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг дунджаас олон буюу 1,600-с дээш сурагчтай 18 ЕБС-д нийт 52.4 мянган хүүхэд суралцаж байгаагийн 31.0 мянган хүүхэд нь хамран сургах тойргийн сурагч биш байна<sup>5</sup>.

Тиймээс газарзүйн мэдээллийн систем, боловсролын мэдээллийн систем хоёрыг нэгтгэсэн системийг төлөвлөлтөд ашиглаж шинээр сургууль барих байршлыг тодорхойлох, бүлэг дүүргэлт багатай сургуулиудын бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой байдлаар дахин зохион байгуулах зэрэг бодлогын төлөвлөлтийг алдаагүй хийх боломжтой болно.

**Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийг хэрэгжүүлнэ:**



Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хуулийг хэрэгжилтийг хангаж ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн бүх хүүхдэд үдийн хоолоор үйлчилнэ.

Сургуулийн үдийн цайнаас хүүхэд өдөрт хоолноос авах илчлэг, шимт бодис, амин дэмийнхээ 15 орчим хувийг авдаг байсан бол

<sup>5</sup> Боловсролын мэдээллийн систем

үдийн хоолны үйлчилгээ үзүүлж эхэлснээр энэ нь 35 орчим хувь болж нэмэгдэх бөгөөд хүүхдийн сургуульдаа явах, суралцах эрмэлзлийг нэмэгдүүлэх, цаашлаад эрүүл, зөв хооллолттой иргэн болж өсөж торниход өндөр ач холбогдолтой.

### **Боловсролын байгууллагуудын засаглалыг сайжруулна:**



Боловсролын чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх, хоорондын уялдаа холбоог хангах өөрчлөлтийг төсвийн төсөлд тусгалаа.

Ерөнхий боловсролын сургуульд чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийг олгох, сургуулийн удирдлагатай гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хянах, төсвийн болон үйл ажиллагааны хяналт тавих чиг үүрэгтэй Боловсролын ерөнхий газрыг байгуулна. Тус байгууллагын бүтцэд багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Насан туршийн боловсролын үндэсний төв, Их сургуулиудын хотхоны ашиглалтын өмнөх захиргаа зэрэг байгууллагуудыг нэгтгэх бөгөөд ингэснээр ажлын уялдаа холбоо сайжрах, чиг үүргийн давхардал арилах, нэгдмэл удирдлагаар хангагдаж ажиллах боломжтой болно.

### **Боловсролын цахим шилжилт:**



Суралцагч гэртээ эсвэл ангидаа ТВ эсвэл интернэтээр заах арга сайтай, мэргэшсэн багшийн хичээлийг үзэх, виртуал орчны сургалтад хамрагдах, дижитал номын санд хичээллэх зэрэг орчин үеийн мэдээлэл, холбооны технологийн давуу талыг сургалтад ашиглах зайлшгүй шаардлагатай байна. Тиймээс үүсээд байгаа энэ хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсролын салбарын цахим шилжилтийг хэрэгжүүлж, орон зай, цаг хугацаанаас үл хамаарч боловсрол олж авах үйл явцыг тасралтгүй болгоно.

### **Сургалтын чанарт суурилсан багшийн цалин, урамшууллын тогтолцоо:**



Багшийн заах арга зүйг сайжруулах, мэргэжил дээшлүүлэх цахим сургалтын орчныг бий болгож багшийг өөрөө өөрийгөө хөгжүүлэх, ур чадвараа нэмэгдүүлэх боломжоор хангана. Багшийн цалин хөлсний шударга тогтолцоог бий болгож, суралцагчдын чанарт ахиц гарсан тохиолдолд урамшуулал, нэмэгдлүүдийг бүрэн авдаг болно.

### **Мэргэжлийн боловсролын шинэчлэл:**



Аж үйлдвэрлэлийн IV хувьсгалын нөлөөгөөр шинээр бий болж байгаа ажлын байранд шаардлагатай мэргэжлийн ажиллах хүчийг бэлтгэх сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн сургуулийн өрсөлдөөний бий болгох замаар чадамжийн гүйцэтгэлийн шалгуурыг хангасан мэргэжилтэй ажилтан сургаж, бэлтгэхэд чиглүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагуудыг ажил мэргэжлийн стандартад үндэслэсэн мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан санхүүжилтийн механизмд шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.

Боловсролын шинэчлэлийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх асуудлыг уялдаатай авч хэрэгжүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцаас МБС-ын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсвийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад шилжүүлнэ.

Түүнчлэн 2022 оноос эхлэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчдад сар бүр олгодог 200.0 мянган төгрөгийн тэтгэлгийг суралцагчийг төгсөхөд нь 1 удаа олгодог болно.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг чанаржуулах, ажил олгогчтой харилцан ашигтай хамтран ажиллах, мэргэжилтэй ажилтан бэлдэх салбарын нэр хүнд, үнэлэмжийг өсгөж мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг хангах, үр дүнг хянаж баталгаажуулах, сургалтын чанарыг тасралтгүй дээшлүүлэх чанарын удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх шаардлагын хүрээнд мэргэжлийн боловсролын шинэчлэлийг мөн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөрийг нутагшуулах, суралцагсдын өрсөлдөх чадвар нэмэгдэх, ингэснээр ирээдүйд хийгдэх томоохон бүтээн байгуулалтад гар бие оролцох үндэсний хэмжээний мэргэжилтэй ажилтнуудын нөөц бүрдэх, чадварлаг багш ажлын гүйцэтгэл, үр дүндээ тохирсон цалин хөлс авах боломжтой болно.



**Дээд боловсролын санхүүжилтийг эрэлтэд нийцсэн, хөгжлийн тэргүүлэх чиглэл,**

**өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглүүлнэ**  
Оюутан суралцагчдад чанартай боловсрол эзэмшүүлэх замаар оюутны боловсролдоо оруулсан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг өсгөх, чанартай мэргэжилтний оролцоогоор хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх, нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор төрөөс дээд боловсролын салбарт дараах шинэчлэлийг хийхээр төлөвлөлөө.



**Үндэсний эрэмбэ тогтооно.** Их, дээд сургуулиудад төгсөгчдийн ажил эрхлэлт, багшлах боловсон хүчний ур чадвар, сургалтын бааз суурь, шинжлэх ухааны судалгааны ажилд оруулдаг хөрөнгө оруулалт зэргийг харгалзан “ҮНДЭСНИЙ ЭРЭМБЭ” тогтоож, цаашид төрөөс буюу Боловсролын зээлийн сангаас олгож байгаа сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийг зөвхөн үндэсний эрэмбийн эхний 10 сургуульд тэргүүлэх, нэн шаардлагатай, эрэлттэй мэргэжлээр амжилттай үнэлгээтэй суралцаж байгаа оюутан суралцагчдад олгодог байхад чиглүүлнэ.



**Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг олгоно.** Монгол залуучуудын дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудын суралцах тэгж боломжийг хангах зорилгоор тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, нийслэлийн хорооноос хамгийн өндөр оноо авсан тус бүр нэг иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн бэлтгэл хөтөлбөрт суралцуулж, бэлтгэл хөтөлбөрөө төгссөний дараагаар дэлхийн шилдэг их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт амжилттай элссэн тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгоно. Нэрэмжит тэтгэлгээр тэргүүлэх болон нэн шаардлагатай мэргэжилтэн бэлтгэнэ. Мөн Монгол Улс болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олимпиадад медальт байрт шалгарсан сурагч дэлхийн шилдэг 100-д багтсан их, дээд сургуулийн бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах эрх авсан бол сургалтын тэтгэлэгт хамруулна.



**Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгоно.** Боловсролын зээлийн сангаас олгодог гадаадын өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд магистр, докторын хөтөлбөрөөр

суралцагчдад олгодог сургалтын төлбөрийн зээл, тэтгэлэгт хамрагдан суралцаж байгаа Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаадын өндөр хөгжилтэй орны их, дээд сургуульд бэлтгэгдсэн өндөр ур чадвартай ахисан түвшний мэргэжилтнийг нэмэгдүүлэх зорилгоор өндөр хөгжилтэй оронд магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагсдад Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлгийг олгоно.



**Шинжлэх ухаан:** Ирэх 2022 онд шинжлэх ухаан, технологийн салбарт дараах бодит шинэчлэлийг хийх суурь бэлтгэлийг хангана. Үүнд: Эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүдийн үндсэн чиглэлийг тогтоож бүтээмжийг нэмэгдүүлэх, хүрээлэнгүүдийн өртөг, зардлын тооцоог нарийвчлан гаргаж өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтийн хосолсон тогтолцоог нэвтрүүлэх замаар үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг хийх бэлтгэл ажлыг тооцоо судалгааны үндэслэлийг боловсруулна. хийхээр төлөвлөж, бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

Монгол хүний оюун ухаан, сэтгэл судлалын хөгжлийг судлах зорилгоор Тархи, сэтгэл судлалын хүрээлэнг, орчин үеийн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зорилгоор Ой модны сургалт, судалгааны хүрээлэн, Дулааны технологи, үйлдвэрлэлийн хүрээлэнгүүдийг авч төсвөөс санхүүжүүлж Шинжлэх ухаан технологийн сангийн харьяанд ажиллуулна.



Олон улсын Монгол судлалын үйл ажиллагааг өргөжүүлэх, дэлхийн Монгол судлаач эрдэмтдийн хооронд мэдлэг, мэдээлэл солилцох үйл явцыг дэмжих зорилгоор Олон улсын монгол судлаач эрдэмтдийн олон улсын 12 дугаар их хурлыг зохион байгуулах зардлыг тусгав.

#### 5.4. Нийгмийн хамгаалал



**Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах, төсвийг үр ашигтай зарцуулах санхүүжилтийн шинэчлэл хийнэ.** Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2017 онд 900.1 сая төгрөг байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 8.0 тэрбум төгрөгт хүрч даруй 8.8 дахин нэмэгдсэн байна. Хэдийгээр хүүхэд хамгааллын төсөв нэмэгдсэн боловч хүчирхийлэлд өртсөн болон өртөх

эрсдэлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээг иж бүрэн, тасралтгүй, тогтвортой хүргэх, хамгааллын үйлчилгээний үе шат, кейс менежментийг бүтэн зургаар нь төлөвлөж, хэрэгжүүлэх, хянах, санхүүжүүлэх асуудлыг хэрхэн зохицуулахыг хуульчилж өгөөгүйгээс хуваарилсан санхүүжилт үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулагдаж байна

Түүнчлэн хүүхэд хамгааллын асуудалд чухал үүрэгтэй “хамтарсан баг”-ийн үйл ажиллагаанд дээрх хөрөнгөөс зардал хуваарилагдахгүй байгаа нь үйлчилгээг хүргэх үйл явц, зардлын жишиг норматив, зардал тооцох аргачлал тодорхойгүй байгаатай холбоотой байна.

Тиймээс хүүхэд хамгааллын үйлчилгээ хүргэх зураглал, жишиг өртгийг нарийвчлан тооцож санхүүжилтийг оновчтой хуваарилах зорилгоор холбогдох зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байгаа бөгөөд ингэснээр хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч санхүүжилтийн үр ашиг, үр дүн дээшлэх болно.

## 5.5. Байгаль орчин



### Цөлжилт, газрын доройтлыг бууруулах, ойжуулалтын чиглэлээр

Эх дэлхий, байгаль орчноо хайрлан зохицон амьдрах монгол уламжлал, зан заншлаа эрхэмлэн, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой мод усны нөөцийг хамгаалах экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний санаачилгыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 6.3 мянган га талбайд ойжуулалт, ойг нөхөн сэргээх, үр тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх, 65.0 мянган га талбайд ойн хөнөөлт шавжийн голомттой ойн санд тэмцлийн ажил явуулах, 1600.0 мянган га талбайд ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж хомсдол, доройтлыг бууруулж, ойн төлөв байдлыг үнэлэх, 1.5 мянган га талбайд ойн төлөв байдлыг сайжруулах, ойн арчилгаа цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, судалгаа, зураг төсөл боловсруулна.

## 5.6. Хөдөө аж ахуй



Мал, амьтныг эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлнэ. Мал эмнэлэг, ариун цэврийн стандартыг олон улсын түвшинд

хүргэх, өвчнөөр тайван бүсийг байгуулах, мал, амьтны гоц халдварт, халдварт, халдваргүй өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлах, эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх, халдварт өвчингүй, тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.



Ирэх онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх болон малчид, тариаланчдыг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдэд ноос, улаанбуудай, сүү, мах, арьс ширний урамшуулал олгох арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Түүнчлэн малчдыг дэмжих зээл болон ноолуур, газар тариалангийн зээлийн хүүгийн хөнгөлөлт олгох зардлыг төсвийн төсөлд тусгав.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд олгож байгаа төсвийн урамшууллын тогтолцоог шинэчлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, салбарын бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, бүтээмж, экспортыг нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрүүдийг дэмжихэд чиглүүлэн төрийн бодлогын хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### Хөдөө аж ахуйн корпорац



Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэх технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийг үр ашигтай хөгжүүлэх чиг үүргийг төсвөөр бус харин аж ахуйн тооцоонд шилжүүлж үр ашигтай ажиллуулах боломжтой байна.

Иймд Хөдөө аж ахуйг дэмжих санг “Хөдөө аж ахуйн корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр ажиллуулахаар тооцож холбогдох төсвийг шилжүүлэв.

## 5.7. Соёл, нийтийн биеийн тамир



**Соёлын, нийтийн биеийн тамирын салбарт гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлнэ.**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу орон нутгийн соёлын байгууллагуудыг хагас бие даалгаж чанар, хүрсэн үр дүн, гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхээр тооцож Соёлын сайдын багц руу шилжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Ингэхдээ иргэдэд үзүүлэх соёлын болон нийтийн биеийн тамирын үйлчилгээний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тухайн орон нутгийн онцлог, нөөц бололцоонд тохирсон байдлаар боловсруулж, үзүүлж байгаа үйлчилгээ тус бүрээр нь холбогдох байгууллагын үйл ажиллагааг үнэлж шалгуур үзүүлэлтээ биелүүлсэн хувь хэмжээгээр санхүүжүүлэх тогтолцоонд шилжүүлнэ.

## 5.8. Бусад



**Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж чанар, үр дүнд суурилсан үйлчилгээг төр худалдан авдаг тогтолцоонд шилжинэ.**

Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах цэвэрлэгээ, засвар, харуул хамгаалалт, хоол үйлдвэрлэл, автомашины үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, ажил үйлчилгээний тарифыг өрсөлдөхүйц хэмжээнд үндэслэлтэй тогтоож шаардлагатай санхүүжилтийг хувийн хэвшилд шилжүүлэх чиглэл баримталж шаардлагатай зохицуулалтыг төсөвт тусгав. Ингэснээр төр зөвхөн үндсэн чиг үүргээ гүйцэтгэж төрийн алба цомхон байх боломж бүрдэхийн зэрэгцээ хувийн хэвшлээ дэмжсэн бодлого хэрэгжих нөхцөл бүрдэнэ.



**Гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын чиглэл ба зохицуулалт**

1. Тагнуулын байгууллага, батлан хамгаалах салбарын анги, байгууллага, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулж тэдгээрийн зардлыг бараа, үйлчилгээ худалдан авах зардал хэлбэрээр гэрээний үндсэн дээр хувийн хэвшилд шилжүүлнэ.

2. Цөөн ажилтантай байгууллагын хувьд үйл ажиллагаа, байршлыг ойр байх нөхцөлийг харгалзан ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшилд шилжүүлнэ. Хэрэв хувийн хэвшил гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй бол тухайн орон нутгийн төрийн өмчийн байгууллага үйлчилгээг багийн хэлбэрээр зохион байгуулж гүйцэтгүүлэх зэргээр аль тохирох хэлбэрийг сонгон хэрэгжүүлнэ. Тухайлбал:

- боловсролын салбарт бүх шатны сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагын цэвэрлэгээ, үйлчилгээ, сантехникийн ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх хэлбэрт шилжүүлэх. Нийслэл, аймгийн төвд хэд хэдэн сургууль, цэцэрлэг, соёлын байгууллагыг хамруулсан байдлаар;
- эрүүл мэндийн салбарт байршил ойр байх нөхцөлийг харгалзан хэд хэдэн эмнэлэг болон эрүүл мэндийн салбарын бусад байгууллагуудад хамтран цэвэрлэгээ, үйлчилгээ, сантехникийн ажил гүйцэтгэх боломжтой байхаар;
- сумдад төсвийн байгууллагын ажилтан цөөн тул сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын байгууллага болон Засаг даргын Тамгын газар зэрэг бүх төсвийн байгууллагыг хамруулсан байхаар;
- төрийн захиргааны бусад байгууллага мөн адил байршил ойр байх нөхцөлийг харгалзан цэвэрлэгээ, үйлчилгээ, сантехникийн ажлыг гүйцэтгэх боломжтой байхаар;

3. Цэвэрлэгээ, үйлчилгээнд зарцуулах зардлыг байгууллагын нийт талбайн хэмжээ болон одоо уг үйлчилгээг үзүүлж байгаа ажилчдын цалин, бусад зардлыг тусган тооцож хуваарилна.

4. Эмнэлэг, сургуулиуд, сургуулийн дотуур байр болон бусад төсвийн байгууллагын халаалтын зуух, гал тогооны ажлыг орон тооны ажилчид гүйцэтгэж байгаа байгууллага уг ажлаа түрээсээр гүйцэтгүүлэх хэлбэрт шилжиж цалин, НДШ, нэмэгдэл хөлс, урамшуулал, хөнгөлөлт, хоолны материал, цахилгаан эрчим хүч, түлш халаалт, төрийн өмч, техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, чанар байдлын үнэлгээ, эзэмшин үйл ажиллагаа явуулах ажлын байр болон бусад зардлыг бараа, үйлчилгээ худалдан авах зардалд тусган санхүүжүүлнэ.

5. Эмнэлэг, сургууль, сургуулийн дотуур байр зэрэг төсвийн газрын халаалтын зуухны галч, механикч, слесарийг гэрээгээр ажиллуулах. Уг үйлчилгээг хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэн

зохион байгуулах ажлыг төсвийн ерөнхийлөн захирагч хариуцна.

6. Төсвийн байгууллагад ажиллаж байгаа малчин, моторчин, жолооч, слесарь, жижүүр, харуул, манаач, сахиул зэрэг бусад төрлийн туслах чанарын болон хугацаа зааж ажиллуулдаг ажилтныг мөн адил гэрээгээр ажиллуулах ажлыг зохион байгуулна.



**Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байгууллагуудын санхүүжилтийн зарчим, хэлбэрийг өөрчилнө.** Төрийн үйлчилгээний

чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарын зарим байгууллагуудыг санхүүгийн хувьд хагас бие даалгаж, үр дүн, чанар, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэх болсонтой холбогдуулан ерөнхий болон сургуулийн өмнөх боловсрол, анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг босоо хэлбэрээр буюу улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ.

Түүнчлэн 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөх Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.1 болон мөн дээрх хугацаанаас эхлэн мөрдөгдөх Төсвийн тухай хуулийн 61.1-д заасны дагуу тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг орон нутаг дахь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Соёлын хэлтсийг тус тус босоо удирдлагатай зохион байгуулалтад шилжүүлнэ.



**Батлан хамгаалахын сайдын харьяа Цэргийн төв эмнэлэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын харьяа Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн санхүүжилтийг нэг худалдан авагчийн зарчимд шилжүүлнэ** Төрийн тусгай албан хаагчдад үйлчилдэг дээрх 2 эмнэлэгт улсын төсвөөс хуваарилдаг төсвийг нэг худалдан авагчийн зарчмаар буюу эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлнэ. Ингэснээр эдгээр эмнэлгүүд нь лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг бусад эмнэлгүүдийн нэгэн адилаар хүрэх үр дүнгийн гүйцэтгэлээрээ санхүүжилт авдаг болно.



**Нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулж, дотоодын цэргийн гэрээт хамгаалалтыг сайжруулна.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Дотоодын

цэргийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах, улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, хамгаалалтын дэглэм журмыг сахиулахад шаардлагатай санхүүжилтийг тусгав.



**Экологийн шинжээч ажиллуулж хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт үйлдлийн байгаль орчинд учирсан хохирлыг шинжлэн тогтооно.** Монгол Улсын эрүүгийн хуульд заасан байгалийн тэнцэл алдагдуулах 9 төрлийн гэмт хэргийг хуульчлан эдгээр гэмт хэргүүдийг мөрдөн шалгах чиг үүрэгтэйгээр экологийн цагдаагийн алба байгуулагдан ажиллаж байгаатай холбоотойгоор дээрх гэмт хэргийг мөрдөн шийдвэрлэх явцад гэмт үйлдэл, эзэн холбогдогчийг тогтоох, байгаль орчинд учирсан хохирол, нөхөн төлбөрийг шинжлэн тогтоох зорилгоор Шүүхийн шинжилгээний байгууллагад экологийн шинжээч ажиллуулна.



**Зөрчлийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем хэрэгжсэнээр зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл, зөрчлийн хэргийн шийдвэрлэлт, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, шийдвэрлэсэн мэдээллийг нэгтгэн, төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох дундын нэгдсэн санг бий болгоно.**

Хаалттай болон хязгаартай цахим мэдээллийн сангийн хяналт, мониторингийн нэгдсэн систем байгуулж, техник тоног төхөөрөмжийг шинэчилнэ.



**Согтуурах, мансуурах донтой тэмцэнэ, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангах замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулна.** Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх зүүн бүсийн салбар эмнэлэг байгуулж, согтууран мансуурахаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг идэвхжүүлнэ. Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлж байгаатай холбоотойгоор хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд цахим гав нэвтрүүлэх замаар гэмт хэргийн улмаас учирсан хохирол барагдуулалтыг үргэлжлүүлэн нэмэгдүүлнэ.



**Цахим гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.** Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цахим гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж, төрөөс иргэдэд нэг удаа цахим гарын үсэг үнэ төлбөргүй олгох дэд бүтцийг бий болгоно. “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, цахим архив, цахим албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулах, газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийн үйл ажиллагааг боловсронгуй болгоно.



**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлж цахим виз олгож, визийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.** Хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор Гадаадын иргэн, харьяатын газар гадаадын иргэдэд цахим визийг олгоно. Визийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, Монгол Улсаас хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудыг уг мэдээллийн сантай холбох ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.



**Шүүхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангана** Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу шүүгч, шүүгчийн туслах албан хаагчдын цалин, нийгмийн асуудал, Шүүхийн сахилгын хорооны Мөн тус хуулийн 24 дүгээр зүйлд Улсын дээд шүүхийн дэргэд шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах, судалгаа хийх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллахаар тус тус заасны дагуу 2022 оны улсын төсөвт холбогдох зардлын төсвийг тооцож тусгасан. хүрээлэнтэй холбоотой зардлыг төсөвт тооцож тусгав.

Мөн тус хуулийн 24 дүгээр зүйлд Улсын дээд шүүхийн дэргэд шүүхийн хэрэгцээ, судалгаанд тулгуурлан сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах, судалгаа хийх, олон нийтэд мэдээлэх үүрэг бүхий Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн ажиллахаар тус тус заасны дагуу 2022 оны улсын төсөвт холбогдох зардлын төсвийг тооцож тусгасан.



**Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.** Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны хууль, эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлэх хүрээнд Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Хуулийн 7.1 дэх заалтад “Зэвсэгт хүчин нь хуурай замын цэрэг, агаарын цэрэг, барилга-инженерийн цэрэг, кибер аюулгүй байдлын цэрэг болон тусгай хүчний цэрэг”-ээс бүрдэхээр заасны дагуу холбогдох төсвийг тусгав.



**Зарим яам, агентлагийг шинээр байгуулж, харьяаллын зохицуулалт хийнэ** Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлд хөгжлийн бодлого, төлөвлөлт нь тогтвортой байна гэж заасны дагуу Хөгжлийн яам байгуулах, төрийн үйлчилгээ болон төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах арга хэмжээг нэгдсэн бодлого, удирдлагаар хангах зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулахаар тус тус тооцож холбогдох төсвийг тусгав.

Боловсролын шинэчлэлийг ирэх онд хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Боловсролын ерөнхий газар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг, цөлжилтөөс сэргийлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг зохицуулалтаар хангах зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын сайдын харьяа Ойн судалгаа, хөгжлийн төвийг өөрчлөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн судалгаа, хөгжлийн газар болгон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус тус байгуулахаар тооцлоо. Мөн төрийн худалдан авах ажиллагааны нэгдмэл байдлыг хангаж, зохицуулалтыг сайжруулах зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны газар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг Сангийн сайдын эрхлэх асуудлын харьяанд шилжүүлэхээр тооцов.

Түүнчлэн бодлогын уялдаа, үр дүнг сайжруулах зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалт болон цөмийн энергийн судалгаа, бодлогын асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд, хүүхэд харах үйлчилгээ болон жендерийн тэгш байдлын асуудлыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус тус

харьяалуулахаар тооцож ирэх оны төсөвт холбогдох өөрчлөлтийг тусгав.



### Гаалийн болон хяналт шалгалтыг нэгдсэн бодлогоор хангана.

Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн бүрдүүлэлт хийх, хяналт шалгалт хийх ажлыг нэгдсэн бодлогоор хангах ажлын хүрээнд Гаалийн болон хяналт шалгалтын тухай хуулийн төслийг боловсруулан, уг хуулийн төсөлд туссаны дагуу Буянт-Ухаа хилийн мэргэжлийн хяналтын алба, Сэлэнгэ аймгийн хилийн мэргэжлийн хяналтын алба, Замын-Үүд хилийн мэргэжлийн хяналтын алба болон хилийн мэргэжлийн хяналтын чиг үүргийг гүйцэтгэж буй албан хаагчдыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Гаалийн ерөнхий газарт шилжүүлэх өөрчлөлтийг тусгав.



### Сонгуулийн зардлыг төсөвт тусгана.

2021 онд Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэгт заасны дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах, арга зүйн удирдлагаар хангахад шаардлагатай зардлыг 2022 төсвийн төсөлд тусгалаа.

## 5.8. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт



Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) нь эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүд түүнчлэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний ялгаатай хэрэгцээнд анхаарч, тэдний эрхийн зөрчилтэй асуудлуудыг илрүүлэн, санхүүгийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлдог үр дүнтэй арга хэрэгсэл юм. Сүүлийн үед улс орнууд төрийн санхүүгийн удирдлагадаа ЖМТ-ийг нэвтрүүлэх хандлага ихсэж байгаа бөгөөд олон улсын хөгжлийн байгууллагууд ч үүнийг сайшаан дэмжиж, үзүүлэх техник туслалцааныхаа нэг хэсэг болгож байна.

ЖМТ нь Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд болон төсвийн орлого, зарлагад жендерийн дүн шинжилгээ хийх замаар асуудлын шалтгааныг илрүүлж асуудлыг хэрхэн шийдэх аргыг өртгийн хамт тогтоож санхүүжүүлэх, хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлж хэмжихэд чиглэгддэг ба энэ шинж чанараараа үр дүн (хөтөлбөр)-д суурилсан төсөвлөлтийн нэг хэсэг гэж тооцогддог.

Европын холбоо/Дэлхийн банкны санаачилга, дэмжлэгээр Сангийн яам ЖМТ-ийг хөдөлмөр эрхлэлт, боловсролын салбарын сонгосон

хөтөлбөрүүдэд туршин нэвтрүүлэх ажлыг 2020 оноос эхлүүлээд байна. Энэ хүрээнд Монгол улсад ЖМТ-ийг нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу бүх ТЕЗ нараас судалгаа авч ЖМТ-г төсвийн төлөвлөлтдөө ашиглах хэрэгцээ, сонирхлыг тогтоох, туршилтын яамдын бодлогын болон төсвийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах, кейс дээр ажиллаж асуудал ба шийдлээ өөрсдөө тодорхойлох болон төсвийн төслөө хэрхэн бэлдэх талаар техникийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байна.

ЖМТ-ийг нэвтрүүлэх нь дунд болон урт хугацааны турш салбар дундын асуудлыг цогц байдлаар хамруулж аажмаар явагдах үйл явц бөгөөд цаашид арга аргачлал, чадавхыг сайжруулах зэргээр үе шаттай нэвтрүүлэхээр зорьж байна

### Хөдөлмөр эрхлэлт (ХЭ)-ийг дэмжих хөтөлбөрт хийсэн жендерийн дүн шинжилгээ

Гол дүгнэлт: 1/ эмэгтэйчүүд хөтөлбөрүүдэд олноор хамрагдаж байгаа боловч тэд голдуу өртөг багатай хөтөлбөрт хамрагдаж байна; 2/ эмэгтэйчүүдэд хуваарилагдсан нөөц эрэгтэйчүүдийнхээс 15.1 хувиар бага байна; 2/ аль ч хүйсийн хувьд хөтөлбөрт хамрагдсаны дараах үр дүнгийн мэдээлэл хангалтгүй байна;

*Хүснэгт № 10. Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд дэх жендерийн харьцуулалт (2020 оноор, хувиар)*

Хөтөлбөр	ҮШХ	Эр	Эм	Хуваарилсан хөрөнгө
1.ХБИ-ийн ХЭ дэмжих;	10.3%	11%	10%	21.7%
2.Залуучуудын ХЭ, гарааны бизнесийг дэмжих;	9.6%	9%	10%	7.5%
3.Ажилд бэлтгэх;	67.5%	71%	65%	63.1%
4.Хөдөлмөрт бэлтгэх, ХЭ ур чадвар олгох;	9.4%	7%	11%	1.3%
5.Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	3.2%	2%	4%	6.4%

*ҮШХ - Үр шим хүртэгчид, ХБИ-Хөгжлийн бэрхиээлтэй иргэн*

Хэрэгжүүлэх арга хэмжээ: 1/Нэн тэргүүнд ХЭДС-д дүн шинжилгээ хийхэд хангалттай байх түвшинд мэдээллийн чанарыг сайжруулах; 2/ Хөтөлбөр нь үр шим хүртэгчдэд хир өгөөжтэй байсныг үнэлэх үр дүнгийн үзүүлэлттэй болох; 3/ хөтөлбөрүүдэд жендерийн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн шалгуурыг тусгадаг байх.



## 5.9. Засгийн газрын тусгай сангууд

Монгол Улсын 2022 оны төсвийн жилд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 5,213.3 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 90.0 хувь буюу 4,690.4 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 10.0 хувь буюу 522.9 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

*Хүснэгт № 11. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум төгрөг/*

ЗГ-ын тусгай сан	2021 төсөв	2022 төсөл
1 Боловсролын зээлийн сан	53.9	79.4
2 Нийгмийн даатгалын сан	2,567.1	2,718.6
3 Соёл, урлаг хөгжүүлэх сан	1.8	2.0
4 Засгийн газрын нөөц сан	100.0	80.0
5 Нийгмийн халамжийн сан	2,994.7	490.4
6 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	38.5	84.3
7 Эрүүл мэндийг дэмжих сан	3.0	3.0
8 Байгаль орчин, уур амьсгалын сан	1.0	0.8
9 Шинжлэх ухаан, технологийн сан	5.4	13.1
10 Улсын авто замын сан	55.0	75.0
11 Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	3.9	4.1
12 Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан	0.2	0.2
13 Зэвсэгт хүчний хөгжлийн сан	35.0	35.0
14 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	69.6	92.9
15 Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	0.6	0.6
16 Спортыг дэмжих сан	0.5	2.5
17 Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан	50.0	50.0
18 Хөдөө аж ахуйг дэмжих сан	33.8	-
19 Эрүүл мэндийн даатгалын сан	1,210.7	1,481.4
<b>НИЙТ</b>	<b>7,224.7</b>	<b>5,213.3</b>



### Боловсролын зээлийн сан

Боловсролын зээлийн санд нийт 79.4 тэрбум төлөвлөлөө. Үүнд оюутны хөгжлийн зээлд 21.8 тэрбум төгрөг, гадаадад суралцагсдын зээлд 18.7 тэрбум төгрөг, бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, нэг өрхөөс 3 хүүхэд нь зэрэг их, дээд сургуульд суралцаж байгаа бол 1 хүүхдийн тэтгэлэгт 13.5 тэрбум төгрөг, оюутанд зориулсан сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлийн батлан даалт болон хүүгийн татаас 8.0 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгт 4.9 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэгт 3.4 тэрбум төгрөг, сувилагч мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрийн тэтгэлэгт 1.9 тэрбум төгрөг, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаадад

суралцаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрийн тэтгэлэгт 1.9 тэрбум төгрөг, багш мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд суралцаж байгаа суралцагчдын болон орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэгт 2.3 тэрбум төгрөг, Орон нутгаас суралцаж байгаа оюутны замын зардлын хөнгөлөлтөд 1.0 тэрбум төгрөг, Засгийн газар хоорондын гэрээний дагуу гадаад улсаас Монгол улсад суралцаж байгаа гадаад оюутнуудын амьжиргааны тэтгэлэгт 0.6 тэрбум төгрөгийг тус тус тусгав.

## Нийгмийн халамжийн сан



Халамжийн сангийн нийт зарлага 490.4 тэрбум төгрөг байгаа нь урьд оноос 2,504.4 тэрбум төгрөгөөр буурч байна. Зардал буурсан шалтгааныг арга хэмжээгээр нь авч үзэхэд 2021 онд коронавируст халдварын цар тахлын үед иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор Засгийн газраас хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүүхэд бүрд 100 мянган төгрөг байхаар олгохоор тооцож 1,440.0 тэрбум төгрөгийг зарцуулсан мөн хөл хорионы үед иргэн бүрд 300.0 мянган төгрөгийг олгох 1,012.0 тэрбум төгрөг тус тус зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт № 12. Нийгмийн халамжийн сангийн зарлага /тэрбум төгрөг/*

Халамжийн сан	2021	2022 төсөл
Халамжийн тэтгэвэр	194.5	119.5
Жирэмсэн эхийн тэтгэмж	12.8	11.3
Алдарт эхийн тэтгэмж	30.4	31.3
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	1,440.0	-
Асаргааны тэтгэмж	61.0	59.4
Олон нийтийн оролцоо	1.8	2.7
Амьжиргааг дэмжих тусламж	41.0	45.3
Асрамжийн үйлчилгээ	0.3	0.6
Хүнсний талон	33.7	33.2
ХБИ тэтгэмж	10.1	9.8
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	25.1	26.0
Цалинтай ээж	104.9	123.0
Насны хишиг	24.4	25.4
Бусад	2.6	2.8
Иргэн бүрд 300.0 мянга	1,012.0	-
<b>НИЙТ</b>	<b>2,994.7</b>	<b>490.4</b>

Ирэх онд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Ирээдүйн өв сангаас санхүүжүүлэх ба ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломж бүрдэх юм.

## Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр тогтоолоор “Хөдөлмөрт бэлтгэх”, “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх хөтөлбөрүүдээс гадна Халамжаас-Хөдөлмөрт” шилжих бодлогын ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай хүнсний талонд хамрагддаг өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай гишүүнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах, мөн Ковид-19 цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах чиглэлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулна

### Мэргэжлийн боловсролыг дэмжих сан



Мэргэжлийн боловсролыг дэмжих сангийн 2022 оны төсвийн нийт зардлыг 92.9 тэрбум төгрөгөөр тусгалаа. Үүнд 2022 оноос хэрэгжих мэргэжлийн боловсролын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд бэлтгэж байгаа ажил мэргэжлийн стандартад үндэслэсэн мэргэжлийн өөрийн өртөгт суурилсан санхүүжилтэд 74.3 тэрбум төгрөг, МСБ-д суралцагчдад олгодог 200.0 мянган төгрөгийн тэтгэлгийг тухайн суралцагчийг МСБ-г төгссөний дараагаар нэг удаа бөөнд нь олгоход 18.6 тэрбум төгрөгийг тус тус тусгалаа.

### Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсөвт нийт орлогын хэмжээг 2,379.5 тэрбум төгрөг, нийт зарлагын хэмжээг 2,750.9 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Энэ нь 2021 онтой харьцуулахад орлого 575.7 тэрбум төгрөгөөр, зарлага 156.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

*Хүснэгт № 13. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/*

Үзүүлэлт	2021	2022
		Төсөв
<b>ОРЛОГО</b>	<b>1,803.7</b>	<b>2,379.5</b>

1 Шимтгэлийн орлого	1,800.2	2,372.4
2 Бусад орлого	3.5	7.1
<b>ЗАРЛАГА</b>	<b>2,594.3</b>	<b>2,750.9</b>
1. Тэтгэврийн даатгалын	2,313.4	2,449.8
2. Тэтгэмжийн даатгалын	160.2	171.5
3. УОМШӨ-ний даатгалын	34.6	33.6
4. Ажилгүйдлийн	58.9	63.7
5. Бусад зарлага	-	-
6. Ажиллагааны зардал	27.1	32.4
<b>Капитал банкнаас авах авлага</b>	<b>-103.7</b>	<b>-98.1</b>
<b>Улсын төсвөөс олгох татаас</b>	<b>593.9</b>	<b>459.9</b>

### Нийгмийн даатгалын сангийн орлого



Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2,379.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2021 онтой харьцуулахад 575.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Ирэх онд эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэх, дундаж цалин хөлс өсөх, орлогын боломжит бусад эх үүсвэр нэмэгдэх зэрэг төсөөлөлд үндэслэн тооцлоо.

Нийгмийн даатгалын санд 2021 оны эхний 6 сарын байдлаар 48.7 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 826.2 мянган даатгуулагч албан журмын даатгалд, 136.1 мянган даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдаад байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдлыг даван туулах, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасантай холбогдуулан 2021 оны эхний 5 сарын байдлаар 37.2 мянган ажил олгогч, 396.2 мянган албан журмын даатгуулагч 114.1 тэрбум төгрөгийн, 109.1 мянган сайн дурын даатгуулагч 10.9 тэрбум төгрөгийн, нийтдээ 125.0 тэрбум төгрөгийг шимтгэлээс чөлөөлөгдсөн байна.

Түүнчлэн Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл сунгасан бөгөөд хуулийг хэрэгжүүлэх хугацаанд нийт 18.5 мянган иргэн хамрагдан тэтгэврийн даатгалын санд 36.5 тэрбум

төгрөгийн орлого төвлөрүүлснээс 8.3 мянган хүн тэтгэвэр тогтоолгон, тэтгэвэрт нь 15.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэрийг ангилж үзвэл:

1/ Нийгмийн даатгалын санд 2022 онд төвлөрөх шимтгэлийн орлогыг 2,372.4 тэрбум төгрөг, бусад орлого 7.1 тэрбум байхаар тооцлоо.

2/ Цэргийн алба хаасны тэтгэвэр, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийн зардлыг хуульд заасны дагуу улсын төсвөөс олгох татааст нийт 459.9 тэрбум төгрөгөөр тооцлоо.


### Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зардал 2,750.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн 2021 онтой харьцуулахад 156.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

### Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 2,474.7 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,960.2 тэрбум төгрөгөөр тооцлоо. Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 76.0 хувийг өндөр насны тэтгэвэр, 12.0 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 8.0 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

График № 41. Нийгмийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Тэтгэврийн даатгалын сангаас 2022 онд нийт 472.6 мянган хүний тэтгэвэрт 2,448.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2021 онтой харьцуулахад 136.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2022 онд тэтгэврийн

насанд хүрч шинээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрэгтэй 13.1 мянга, эмэгтэй 50/55 насны 20.9/18.0 мянга, нийтдээ 52.2 мянган хүн байгаа бол тэтгэвэр нь зогсох 27.0 мянга хүн байна. Тэтгэвэр авагчдын тооны цэвэр өсөлтийг 20.9 мянган хүн байхаар тооцлоо.

Ирэх онд нийт өндөр насны тэтгэвэр авах хүний тоо 359.9 мянган хүн, зарцуулах хөрөнгө 1,879.6 тэрбум төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт нийт 74.5 мянган хүн зарцуулах хөрөнгө 297.9 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт нийт 18.1 мянган хүн зарцуулах хөрөнгө 82.9 тэрбум төгрөг, улсын төсвөөс тэтгэврийн зардлыг нь хариуцдаг 1/ цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах хүний тоо 2022 онд нийт 20.1 мянга; 2/ 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нийт 48.1 мянган иргэн тус тус тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаар байна. Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаас 459.9 тэрбум төгрөг байна. Үүнээс: цэргийн тэтгэвэрт 188.4 тэрбум төгрөг, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 246.4 тэрбум төгрөг тус тус олгохоор төсөвлөлөө.

Хүснэгт № 14. Улсын төсвийн татаас /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2019	2020	2021	2022
Улсын төсвийн татаас	601.6	399.4	593.9	459.9
Үүнээс:				
Цэргийн тэтгэвэр	130.5	155.9	173.3	188.4
1995 оноос өмнөх	235.6	211.7	253.9	246.4
НДС-н алдагдалд	235.5	31.8	166.7	25.1

### Тэтгэмжийн даатгалын сан



Тэтгэмжийн даатгалын сангийн орлого 2022 онд 198.9 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 174.8 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар тооцлоо

Хүснэгт № 15. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мянган хүн, тэрбум төгрөг/

Тэтгэмж	2021		2022		Өөрчлөлт	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
ХЧТА	116.0	26.4	118.3	28.3	2.3	1.9
Ж.А	64.6	109.9	67.2	117.8	2.6	7.9
Оршуулгын	16.4	16.4	17.2	17.2	0.8	0.8
<b>Нийт</b>	<b>197.0</b>	<b>152.7</b>	<b>202.7</b>	<b>163.3</b>	<b>5.7</b>	<b>10.6</b>

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл

төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

### ҮОМШӨ-ий даатгалын сан



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд 2022 онд 178.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд нийт 37.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас тахир дутуу болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 5.0 мянган иргэнд нийт 29.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.1 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 1.6 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

### Ажилгүйдлийн даатгалын сан



Ажилгүйдлийн даатгалын санд 2022 онд 42.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлагдаж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил олгох давтан сургалтын зардалд 64.4 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас 2022 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 25.6 мянган иргэнд 63.6 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

### Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкнаас авах 98.1 тэрбум төгрөгийн авлагыг тусгав.

## Эрүүл мэндийн даатгалын сан

### Сангийн орлого



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн орлогыг нийт 1,450.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд 2021 оноос нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын санд тусламж, үйлчилгээний санхүүжилтийг шилжүүлж байна. Үүний дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод улсын төсвийн шилжүүлэг, эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого аж, ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллага болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг тус тус тусгав.

### Сангийн зарлага



Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг 2020 оноос эхлүүлж эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлж байна.

Шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэний тарифаар тооцох зардлыг тусгав. Бүх шатны эмнэлгийн иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлээр олгох санхүүжилтэд нийт 1,358.4 тэрбум төгрөг төсөвлөв.

Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-д тус тус заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор хөнгөлөлттэй олгох эмийн нэр төрөл, жагсаалтын дагуу олгох эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 67.3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн сангийн хөрөнгийг 40.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

### Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн Капитал банкнаас авах авлагыг барагдуулахаар тооцож тусгав.

## 6. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



### 6.1. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2017-2021 ОНД:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2021 онд 6.5 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, 2017-2020 онд 4.3 их наяд төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.


*Хүснэгт № 16. Төсвийн хөрөнгө оруулалт 2017-2021 онуудад, тэрбум төгрөг*

		2017	2018	2019	2020	2021
1	Улсын төсөв	602.1	683.3	1,553.4	1,330.9	1,418.9
	Шилжих:	433.8	149.9	490.3	778.5	940.6
	Шинэ:	602.1	533.5	1,063.1	552.4	478.3
2	Концесс	177.7	82.9	144.7	323.5	266.3
	НИЙТ	779.9	766.2	1,698.1	1,654.4	1,685.2

Эх үүсвэр: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь ДНБ-ний 2.4%-4.6%-ийг эзэлж байна.


*График № 42. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь*



Эх үүсвэр: Сангийн яам

Энэ онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 1,418.9 тэрбум төгрөгийн 1101 төсөл, арга хэмжээ, концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 5 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 266.3 тэрбум төгрөг, нийт 1,685.2 тэрбум төгрөгийн 1106 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнийг барилга байгууламжийн төрлөөр харуулбал:

*График № 43. Улсын төсвийн хөрөнгийн зардал, эдийн засгийн ангиллаар.*



Эх үүсвэр: Сангийн яам

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2021 оны 09 сарын 29-ний байдлаар 43.2%-тай буюу 728.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдээд байна.

Мөн энэ онд 478.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 458 шинэ төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд худалдан авах ажиллагааны явц байдал 2021 оны 09 сарын 29-ний байдлаар 94%-тай байна.

Сангийн яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, 2021 оны төсвийн тухай хуулийн зорилтыг ханган ажиллах зорилтын хүрээнд хэрэгжилт, явц байдлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах, холбогдох байгууллагуудад чиглэл хүргүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

- I. Засгийн газрын 2021 оны 70 дугаар тогтоол;
- II. Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол;
- III. Засгийн газрын 19, 22, 36, 51 дүгээр тэмдэглэл.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийгмийн ач холбогдол бүхий эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг төлөвлөж, дараах зарчмын дагуу хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, олон жил үргэлжилж байгаа төслүүдийг ашиглалтад оруулах, шинээр хэрэгжүүлэх төслүүдийн гэрээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний дотор байгуулж дуусгах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулах, санхүүжилтийн шуурхай, нээлттэй, ил тод байдлыг төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан хангах, төсвийн жилд багтаан санхүүжүүлэхэд онцгой анхаарч ажиллах;
- Шинэ төрлийн COVID-19 вирусийн тархалттай холбоотойгоор эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг тэргүүн

ээлжинд санхүүжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх;

- Гаалийн шинэчлэл хөтөлбөрийг үргэлжлүүлж, экспортын эрдэс баялаг импортын бүтээгдэхүүнд тавих хяналт, үйлчилгээг сайжруулахад шаардагдах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх;
- Ашиглалтад орж аудитын дүгнэлт гарсан концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийн төлбөрийг тусгах;

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг олон улсын жишигт нийцүүлэх, сайжруулах бодлогыг арга хэмжээг амжилттай хэрэгжүүлж, энэ хүрээнд анх удаа “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх аргачлал”-ийг 2018 онд батлуулан улсын хэмжээнд ашиглаж эхлээд байна.



Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем, “төсвийн хөрөнгө оруулалт” гар утасны аппликэйшнийг 2019 оноос эхлэн нэвтрүүлж, төлөвлөлт, санхүүжилтийн үйл ажиллагааг цахимд шилжүүлж, төсвийн хөрөнгө оруулалтын ил тод, нээлттэй, шуурхай байдлыг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Шинээр концессын “Барих-Шилжүүлэх” гэрээ байгуулахгүй байх УИХ-ын шийдвэр гарч, хэрэгжиж дууссан “Барих-Шилжүүлэх” концессын төслүүдийн санхүүжилтийг хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтэд үндэслэн олгож байх бодлогыг баримталж байна.

## 6.2. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2022 ОНД

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дунд хугацаанд **төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээг тогтвортой түвшинд хадгалж, эдийн засгийн идэвхжилийг үргэлжлүүлэн дэмжих зарчим баримталж, төслүүдийг хөгжлийн бодлого, бүс, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулах бодлогыг хэрэгжүүлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хангах зорилгоор дараах чиглэл, зарчмыг баримтална. Үүнд:**

1

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг зорилтыг хангах ажиллана.

2

Боловсрол, эрүүл мэндийн салбарыг үргэлжлүүлэн дэмжиж, төвлөрлийг сааруулах төслүүдийг хэрэгжүүлнэ.

3

Төсвийн хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийн дагуу үнэлгээ хийгдсэн төслүүдийг төлөвлөнө.

4

Батлагдсан зураг төсөвтэй, газрын асуудал шийдэгдсэн байх.

5

Төсвийн хөрөнгө оруулалтыг тэгш хуваарилах бус тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлнэ.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ нь бодлогын баримт бичгүүдийг зорилтыг хангах, хуулиудын уялдаа холбоог хангасан байхаар онцлогтой боловсруулагдсан. Тухайлбал,**

УИХ-ын 2021 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд нийт **11.7 их наяд төгрөгийн 317 төсөл, арга хэмжээ батлагдсан, үүний 1.7 их наяд төгрөгийн 67 төсөл, арга хэмжээ нь** улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ байгаа тул 2022 оны төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд нь уг хөгжлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг хангахад чиглэсэн.



Түүнчлэн, Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиудын хүрээнд орон нутаг чиг үүргийнхээ дагуу зарим салбарын хөрөнгө оруулалтын төслүүд, их засварын санхүүжилтийг орон нутаг өөрөө бие даан шийдвэрлэх боломжийг хангасан. Энэ хүрээнд Улаанбаатар хотын авто замын болон нийтийн тээврийн чиглэлийн 492.0 тэрбум төгрөгийн төслүүдийг нийслэлийн төсвөөр орон нутаг өөрөө төлөвлөж, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх боломжийг бүрдүүлж өгөв.

**Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг аргачлал, цахим системд суурилсан үр ашигтай байх бодлогыг улсын**

## ХЭМЖЭЭНД БҮХ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАЛАА.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг 2021 оны 4 сарын 1-нээс эхлэн улсын хэмжээнд орон нутаг, салбар яам, Сангийн яам гэсэн 3 түвшинд 2 үе шаттай төлөвлөж, төслүүдийн эрэлт хэрэгцээ, нийгмийн ач холбогдлыг тооцох, мөн төслүүдийн хэрэгжүүлэх бэлэн байдал хэр хангагдсан талаар үнэлгээг 16 шалгуур үзүүлэлтээр цахим системээр төлөвлөн ажиллалаа.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг цахим систем, аргачлалын дагуу хэрхэн төлөвлөх талаар мэргэшүүлэх цахим сургалтыг үе шаттайгаар орон нутаг, Засгийн Газар, УИХ-ын түвшинд зохион байгуулж ажилласан.

“Төсвийн шинэчлэл”-ийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, энэ хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж улсын төсвийн хөрөнгө оруулалтын аргачлалын дагуу боловсруулсан, цахим системд төлөвлөсөн, бэлтгэл ажил бүрэн хангагдсан төслүүдийг төсвийн төсөлд тусгадаг болох, ингэснээр эдийн засгийг идэвхжүүлэхтэй холбоотой нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, оновчтой, үр ашиг бүхий төслүүдийг төсвийн боломжид тааруулан эрэмбэлэн санхүүжүүлэх зарчим, чиглэлийг баримталсан.

Засгийн газар 2022 оны хөрөнгө оруулалтаар урсгал зардал нэмэгдүүлдэг төслүүдийг бууруулах, контор болон автомашин худалдан авах төслийг огт тусгахгүй байх бодлого

барьсан нь өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтаас онцлог болсон.

**Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна.** Төсвийн төсөлд нийт 18.2 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 5334 төсөл, арга хэмжээний санал ирүүлсэн байна.

Нийт ирүүлсэн саналуудыг дээрх зарчим, шалгуур үзүүлэлтээр эрэмбэлснээр төсвийн төсөлд нийт **5,943.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2022 онд санхүүжих 2,137.0 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 1334 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгаад байна.**

Түүнчлэн, **тойргийн хөрөнгө оруулалтаас хөгжлийн хөрөнгө оруулалт руу шилжилт хийж**, энэ хүрээнд 2021 оны түвшнөөс зам тээврийн салбарын шинэ хөрөнгө оруулалтыг **7.5** дахин, барилга байгуулалтын салбарын шинэ хөрөнгө оруулалтыг **4.1** дахин, эрчим хүчний салбарын шинэ хөрөнгө оруулалтыг **6.4** дахин их төлөвлөлөө.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалт нь 2022 онд хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт байх бөгөөд дараах төслүүдийг онцолж байна. Тухайлбал,**

1. Залуу гэр бүлийг орон сууцжуулах зорилтын хүрээнд: "Залуус-1" орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн шугам сүлжээ төсөлд **29.9 тэрбум төгрөг**;
2. Төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд: "Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц төсөлд **100.0 тэрбум төгрөг**", "Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд бүтэц төсөлд **12.0 тэрбум төгрөг**", "Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл **45.9 тэрбум төгрөг**";
3. Эдийн засгийн өсөлтийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлэх зорилтын хүрээнд: Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам, Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4 км авто зам, Өндөрхаан хотоос Ульхан боомт хүртэлх 254 км авто зам зэрэг төслүүдэд нийт **455.6 тэрбум төгрөг**

4. Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд: Хөвсгөл аймагт баригдах “Найрамдал-2” цогцолбор төсөлд **30.0 тэрбум төгрөг**, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн өргөтгөлд **37.0 тэрбум төгрөг**, Нийслэлийн 2 дугаар төрөх эмнэлгийн барилгад **18.0 тэрбум төгрөгийн** хөрөнгө оруулалтын төслүүдийг тус тус онцолж байна.

**Орон нутгийн хөгжлийн дэмжиж, хөрөнгө оруулалтын хүртээмжийг нэмэгдүүлнэ.** Нийт хөрөнгө оруулалтын 57.3% буюу 1,225.0 тэрбум төгрөг нь орон нутагт, 26.6% буюу 568.2 тэрбум төгрөг нь нийслэлд, 15.1% буюу 325.4 тэрбум төгрөг улсын хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалт байна.

График № 44. 2022 онд санхүүжих дүн, тэрбум төгрөг



**Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд дэд бүтцийн салбаруудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж төлөвлөснөөр нийт шинэ хөрөнгө оруулалтын 41.87%-ийг эзэлж байна.** Мөн түүнчлэн нийт хөрөнгө оруулалтын 1,766.1 тэрбум төгрөг нь барилга байгууламж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын салбарт хийгдсэнээр 2022 оны ДНБ-ийг 820 гаруй тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.

Цаашлаад **урьдчилсан үнэлгээний /pre-screen/ аргачлалыг нэвтрүүлж**, хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн процесс, тогтолцоог бий болгож, улсын нийт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд **“үе-шатны-хянан баталгаажуулах”** схемийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.



Мөн төр хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин, бодлогыг олон улсын жишигт нийцүүлэх, ингэснээр дэд бүтэц, нийгмийн суурт үйлчилгээний салбарт ТХХТ-ийг нэвтрүүлж, хувийн хэвшил дээр суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжих, өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг хувийн хэвшлийн чадавхи, ур чадвар, технологит суурилан сайжруулах, төсвийн ачааллыг урт хугацаанд бууруулах зорилгоор **“Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай” хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар** бэлтгэж байна.

#### **Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийн тухай**

Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төслийн эргэн төлөлтийг 2016 оноос эхэлж улсын төсөвт тусган санхүүжүүлсэн.

Концессын төслүүдийн эргэн төлөлтөд 2016-2020 онд нийтдээ 786.8 тэрбум төгрөгийг олгосон. Улсын Их Хурлаас батлагдсан 2021 оны төсвийн тухай хуульд 5 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 266.3 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үүнээс 2 төслийн эргэн төлөлтийг бүрэн олгож дуусгасан.

2022 оны төсвийн төсөлд концессоор хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг тусгахдаа 2022 оны төсвийн хязгаар, Үндэсний аудитын газрын дүгнэлт, мөн тухайн ажлыг ашиглалтад хүлээн авсан улсын комиссын актыг үндэслэсэн. Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 7 төслийн эргэн төлөлтөд 2022 оны төсвийн төсөлд нийт 303.6 тэрбум төгрөг тусгасан. Эдгээр төслүүдээс 4 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг өмнөх онуудаас олгож эхэлсэн бөгөөд үлдсэн 3 төслийн ажлыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан төслүүд байна. Дараа оны төсвийн төсөлд тусгагдах төслүүдээс 3 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг бүрэн олгож дуусах юм.



## 7.ОРОН НУТГИЙН ТӨСӨВ



*Орон нутгийн төсөв 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн шинэчилсэн найруулга болон тус хуультай хамт баталсан “Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлтүүдийг тусгалаа.*

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль/цаашид МУЗЗНДНТУТ гэх/-ийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь нь аймаг, нийслэлийн төвлөрүүлэх татварын орлогод шилжсэн. Улмаар 2022 оны орон нутгийн төсвийн суурь орлого аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь болох 588.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлсэн байна.

Мөн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвар, газрын төлбөр болон үл хөдлөх хөрөнгийн албан татвар нь аймаг, нийслэлийн татварын орлогоос сум, дүүргийн татварын

орлого руу шилжсэн нь сум, дүүргийн төвлөрүүлэх татварын орлогыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлж байна.



Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасан орон нутгийн чиг үүрэг нь МУЗЗНДНТУТ хуулийн 3 дугаар бүлгийн нэгдүгээр дэд бүлгээр зохицуулагдах болсонтой холбогдуулан орон нутгийн суурь зарлагыг нэмэгдүүлэхээр байна.



МУЗЗНДНТУТ хуулийн өөрчлөлттэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 дахь хэсэгт заасан “орон нутгийн суурь зарлага”-ыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагыг болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлагын нийлбэр болгож өөрчилсөн ба Засгийн газрын 2021 оны 146 дугаар тогтоолд “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах арга хэмжээ”-г хэрэгжүүлэхээр туссан.




Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын дээрх өөрчлөлтүүдийн үр дүнд аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг 2022 онд 236.7 тэрбум төгрөг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 2022 онд 514.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

## 7.1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН



Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан /ОНХНС/ болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сан/ОНХС/-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 253.4 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь өмнөх оноос **25.1 тэрбум төгрөгөөр** нэмэгдсэн байна.

График № 45. Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, тэрбум төгрөг



*МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулга болон түүнийг дагаж батлагдсан Төсвийн тухай хуульд орсон өөрчлөлтийн нөлөөгөөр орон нутгийн төсвийн харилцаа, цаашилаад ОНХС-ийн зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлага үүссэнээс 2022 оны төсвийн жилд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар тусгалаа. Үүнд:*

1. ОНХНС нь уул уурхайн баялгийг тэгш хүртээмжтэй хуваарилах замаар бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангахад чиглэгддэг. Иймд ОНХНС-д ашигт малтмалын нөөц ашигласны

төлбөрийн эх үүсвэрээс төвлөрөх хувь хэмжээг нэмэгдүүлж **5 хувийг 10 хувь** болгон, харин импортоос бусад бараа, ажил, үйлчилгээний нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын эх үүсвэрийг хасах зохицуулалтыг хийлээ.



2. Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аймагт байгаль орчны нөхөн сэргээлт хийж иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлогоос тодорхой хэсгийг тухайн эх үүсвэрийг бүрдүүлж байгаа аймгуудад нэмэлтээр тус тус хуваарилахаар өөрчлөлт оруулж байна.



3. МУЗЗНДНТУТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “ОНХНС-с тухайн нэгжийн хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, эдийн засгийн чадавхыг харгалзан хөрөнгө хуваарилна” гэж тусгасанд нийцүүлж Төсвийн тухай хуульд заасан үндсэн **3** итгэлцүүрээр хуваарилахаар өөрчлөлт орууллаа.



4. МУЗЗНДНТУТХ-г дагаж Төсвийн тухай хуульд зааснаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын **40 хувийг** аймаг, нийслэлийн төсвийн татварын орлогод тооцох болсноор аймгийн орлогын эх үүсвэр тодорхой хэмжээгээр нэмэгдсэн. Иймд аймгийн ОНХС-с сумдын ОНХС-д хийгдэх шилжүүлгийн суурь дүнг **30 хувиас 50 хувь** болгон нэмэгдүүлээ.

## 8. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ



2021 онд гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслүүдийн санхүүжилт, татвар чөлөөлөлтийг бүрэн цахимжуулж, хүнд сурталгүй, цаасгүйгээр төслийн хэрэгжилтийг үр ашигтай явуулах боломжийг бүрдүүлж ажилласан бол 2022 оноос олон талт хамтын ажиллагааны хүрээнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл, арга хэмжээг нийгэм, эдийн засгийн ач холбогдол өндөртэй томоохон бүтээн байгуулалтад чиглүүлэх, хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд одоо хэрэгжиж байгаа төслүүдийг хугацаанд нь дуусгаж, гадаадын экспорт, импортын банкуудаар дамжих арилжааны зээлийн эх үүсвэрийг Монгол Улсын Хөгжлийн банк руу шилжүүлэх бодлого баримталж, бэлтгэл ажлыг шат дараатай хэрэгжүүлж ажиллана.

### 8.1. Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл

Монгол Улсын 2021 оны төсвийн тодотголоор гадаад төслийн зээлийн ашиглалт 1,205.1 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 150.3 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2022 онд 1,384.0 тэрбум төгрөгийн зээл, 298.5 тэрбум төгрөгийн тусламж авч ашиглахаар төсвийн төсөлд тусгав.

2022 онд авч ашиглах нийт зээл, тусламжийн 51.9 хувийг хөгжлийн түнш олон улсын байгууллага, 48.1 хувийг хөгжлийн түнш улс орнуудын эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд өмнөх жилүүдийн адил нийт зээл, тусламжийн санхүүжилтэд эзлэх Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилт өндөр хэвээр, 32 хувийг эзэлж байгаа бол Дэлхийн банк (ДБ)-ных 10 хувийг, Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ных 6 хувийг эзэлж байна. Түүнчлэн, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын зээл, тусламжийн санхүүжилт 20 хувийг эзэлж, Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих, 1008 айлын орон сууцны хороолол барих зэрэг томоохон төслүүдийг санхүүжүүлэх бол Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ)-ын зээлээр санхүүжүүлэх Газрын тосны үйлдвэр барих төсөл 10 хувийг, Бүгд Найрамдах Солонгос Улс

(БНСУ)-ын зээлээр санхүүжүүлэх Солонго 1, 2 орон сууцны хороолол барих, 10 аймгийн дулааны станц барих зэрэг төслүүдийн санхүүжилт нийт зээл, тусламжийн санхүүжилтийн 7 хувийг эзлэхээр байна.

Хүснэгт № 17. Гадаадын зээл, тусламжийн 2022 оны төлөвлөгөө /хөгжлийн түншээр/, тэрбум төгрөг

Хөгжлийн түнш	Зээл ашиглалт	Тусламж ашиглалт	Нийт дүн
АХБ	485.1	59.5	544.6
Хятад	249.3	100.6	349.9
Энэтхэг	164.0	-	164.0
Дэлхийн банк	149.0	16.9	165.9
БНСУ	116.2	-	116.2
ЕСБХБ	104.4	8.6	113.0
АНУ	-	95.6	95.6
Франц	8.8	-	8.8
ЕХОБ	25.0	-	25.0
АДБХОБ	20.0	-	20.0
Австри	20.5	-	20.5
Япон	21.8	-	21.8
Герман	1.9	12.6	12.6
ХААХОУС	5.4	-	5.4
Польш	6.3	-	6.3
Беларусь	6.2	-	6.2
Кувейт	-	4.7	4.7
Унгар	0.01	-	0.0
<b>Нийт дүн</b>	<b>1384.0</b>	<b>298.5</b>	<b>1682.5</b>

Эх үүсвэр: Сангийн яам

Засгийн газрын 2022 оны гадаад зээл, тусламжийн ашиглалтыг бүтцийн хувьд авч үзвэл 1,166.0 тэрбум төгрөг буюу 69.3 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 280.0 тэрбум төгрөг буюу 16.6 хувийг Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, шинэ дэд бүтцийг бий болгох, эрчим хүч, дулаан хангамжийг сайжруулах болон аймгуудын цэвэрлэх байгууламжийг барих зэрэг орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн дамжуулан зээлдүүлэх зардалд зарцуулах бөгөөд онцгой байдал, боловсрол, эрүүл мэнд, хотын хөгжил зэрэг салбарт урсгал зардлын санхүүжилтээр 236.5 тэрбум төгрөг буюу 14.1 хувийг ашиглахаар төлөвлөсөн.

## 8.2. Төслүүдийг санхүүжүүлэхэд баримтлах зарчим



Монгол Улсын Засгийн газрын Хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагаас 2022 онд авч ашиглах зээл, тусламжийн төслийн төсвийг төлөвлөхдөө эдийн засгийн өсөлтийг дэмжих, тэргүүлэх ач холбогдолтой томоохон төслүүдийг түлхүү санхүүжүүлэх, мөн коронавируст цар тахал (КОВИД-19)-аас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийн эсрэг эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй төслүүд, хэрэгжиж дуусах төслүүдийн санхүүжилтийг бүрэн тусгах, үргэлжилж буй төслүүдийн хувьд гэрээ хэлэлцээрт тусгагдсан төлөвлөгөөг харгалзан гэрээний хэрэгжилтийг хангах хэмжээнд, шинэ төслүүдийг ажил эхлүүлэх хэмжээнд ашиглалтыг тусгах зарчим баримталсан болно.

## 8.3. Гадаад зээл, тусламжаар 2022 онд санхүүжүүлэх салбар, чиглэл, томоохон төслүүдээр хийгдэх ажлууд

Гадаадын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн хөрөнгөөр 120 төсөл, тусламжийн эх үүсвэрийн хөрөнгөөр 31 төслийг 2022 онд хэрэгжүүлж, дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:



**Дэд бүтцийн бүтээн байгуулалт, нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх** чиглэлээр 2022 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 694.3 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн 39.4 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 43.6%-ийг эзэлж байна.



Дорноговь аймгийн Алтанширээ суманд жилд 1.5 сая тонн түүхий тос боловсруулж дотоодын хэрэгцээг бүрэн хангах үндэсний үйлдвэрийг БНЭУ-ын 1,236.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барьж байна. Төслийн хүрээнд газрын тос боловсруулах процессын үндсэн байгууламж болон бусад дагалдах барилга байгууламж, мөн үйлдвэрийн хотхоны 549 айлын бүтээн байгуулалтын ажил хийгдэнэ. 2022 онд төслийн хүрээнд үйлдвэрийн холбогдох барилга болон дагалдах байгууламж угсралтын ажил үргэлжилж, 35 МВт-ын хүчин чадалтай үйлдвэрийн цахилгаан станц барьж гүйцэтгэхээр төлөвлөсөн.



АХБ-ны 120.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар – Дархан чиглэлийн 204.11 км, Дархан – Алтанбулаг чиглэлийн 118 км, Хүйтний хөндий – Арвайхээр чиглэлийн 57.8 км-ын авто замын засвар шинэчлэлтийг хийж байна. Мөн ЕСБХБ-ны 137.0 сая ам.долларын зээлийн хөрөнгөөр Улаанбаатар – Дархан чиглэлийн 202.4 км авто замын нэмэлт 2 эгнээг шинээр барих бөгөөд замын дагуух бүх ус зайлуулах байгууламжийг шинэчилнэ. 2022 онд нийт төслийн авто замын барилгын ажлын 40%-ийг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд үүнд далан, ухмал, ус зайлуулах хоолой, суурийн доод үеийг бүрэн дуусгахаар төлөвлөсөн.



Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Шижигтийн хавцалд 90МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станцыг БНХАУ-ын 288.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Тус төслийн зорилго нь баруун бүсийн эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг найдвартай эх үүсвэрээр хангах, үүсгүүр хүч чадлын зөв бүтцийг бүрдүүлэх, эрчим хүчний хангамжийн аюулгүй байдлыг баталгаажуулан, найдвартай ажиллагааг хангах, ОХУ-аас импортлож байгаа эрчим хүчийг бууруулж, ББЭХС-д өгөх татаас буурах, УЦС-ыг ашиглах замаар бүс нутгийн эдийн засгийн чадавхийг сайжруулна. 2022 онд төслийн зураг төслийн ажил, ажлын талбар бэлтгэх, түр байгууламж барих, нэвтрэх зам болон гүүр барих зэрэг төслийн барилга угсралтын ажлын бэлтгэл хангана.



Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Дундговь, Хэнтий, Говь-Алтай, Завхан, Баянхонгор аймгийн төвд 10 дулааны станц, 88 дулаан дамжуулах төв,  $\approx 71$  км урттай дулаан дамжуулах шугам сүлжээ барих төслийг БНСУ-ын 148.7 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагатай баримт бичгүүд боловсруулагдан баталгаажуулсан бөгөөд барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.



**Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, усан хангамжийг нэмэгдүүлэх, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих дэмжих** чиглэлээр гадаад


зээлийн хөрөнгөөр 308.8 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 161.8 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 28.0%-ийг эзэлж байна.



Сонгогдсон тусгай хамгаалалтын газар нутаг болон нийлмэл/холбоос нутгуудын тогтвортой, үр дүнтэй менежментийг бэхжүүлэх, нутгийн ард иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих зорилгоор ХБНГУ-ын 27.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд 2022 онд Монгол орны тусгай хамгаалалтай газар нутгийн баруун болон говийн бүст шаардлагатай байгаа барилга барих, тоног төхөөрөмжөөр хангах бөгөөд холбогдох судалгаа, үнэлгээг хийнэ.



Баян-Өлгий, Ховд, Увс аймагт аялал жуулчлалыг дэмжих дэд бүтцийг байгуулах, хог хаягдлын менежментийг сайжруулах, тусгай хамгаалалттай газар болон соёлын өвийг хамгаалах, коронавирусын дараа эргэн сэргэх, тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлэхээр АХБ-ны 30.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 2.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-2” хэрэгжүүлнэ. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2021 онд боловсруулсан бөгөөд аялал жуулчлалын цогцолбор-2, аялал жуулчлалын гудамж-2, нэвтрэх, отоглох цэгүүд, шувуу ажиглах цамхаг зэргийг байгуулж аялал жуулчлалын дэд бүтцийг 2022 онд бий болгоно.



Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах хоногт 250,000м<sup>3</sup> ахуйн болон үйлдвэрийн хаягдал ус цэвэрлэх хүчин чадалтай Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг БНХАУ-ын 249.5 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр шинэчлэн барьж байна. Тус байгууламжийн нарийвчилсан зураг төслийг гаргаж, барилга угсралтын ажлыг эхлүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжийн худалдан авалт 2021 онд хийгдсэн. 2022 онд төслийн хүрээнд баригдах барилга угсралтын ажлыг 95%, шугам сүлжээний ажил 30%, гадан шугам сүлжээний ажил 75%, тоног төхөөрөмжийн угсралт 30% хүргэхээр төлөвлөсөн.



Улаанбаатар хотын унд, ахуйн болон үйлдвэр, аж ахуйн усны эрэлтийг хангахаар АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацийн 350.0 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 111.76 сая ам.доллар буюу нийт 461.76 сая ам.долларын санхүүжилтээр “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хотын баруун хэсэг буюу Биокомбинат, Шувуун фабрик орчимд газрын доорх усны хоёр эх үүсвэр шинээр байгуулах, гүний худаг, насос станц, ус дамжуулах шугам хоолой барих, дэвшилтэт технологи бүхий ус гүн цэвэршүүлэх байгууламж барих, MNS 4943:2015 стандартын шаардлага хангасан усыг шинэ ТЦБ-аас хүлээн авч цэвэршүүлэн ДЦС 3, 4-т өгөх хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр барина. 2021 онд ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төсөл боловсруулах зөвлөх компанитай гэрээ байгуулсан. Төслийн хүрээнд 2022 онд газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах, хаягдал ус дахин боловсруулж, эргүүлэн ашиглах, усны салбарын тогтвортой байдлыг хангах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэнэ.



“Ногоон нуур орчмын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 1008 айлын түр оршин суух орон сууцны хотхон барих төсөл”-ийг БНХАУ-ын 347.4 сая юанийн буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх бөгөөд Монгол талын бэлтгэл ажлын гүйцэтгэл 95%-тай байна. Төслийн хүрээнд 21 давхар 8 блок бүхий 1008 айлын орон сууцны барилга, 294 автомашины дулаан зогсоол, автомашины болон явган хүний зам, хүүхдийн тоглоомын болон спортын талбайн, ногоон байгууламж ажил хийгдэнэ. 2022 онд тус төслийн барилга угсралтын ажил, дотор, гадна шугам сүлжээний ажил хийгдэнэ.



“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл”-ийг 3 үе шаттай хэрэгжүүлэхээр нийт 334.16 сая ам.доллар буюу АХБ-ны 160.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 3.7 сая ам.долларын буцалтгүй тусламж, Европын хөрөнгө оруулалтын банкны 60.3 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, Нийслэлийн хөрөнгө

оруулалтын 120.2 сая ам.долларын эх үүсвэрээр санхүүжинэ. Төслийг Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн мянга, Шархад болон Толгойтын оршин суугчид зориулан цэцэрлэг, эрүүл мэндийн төв, спорт цогцолбор, орон сууц, бизнес инкубатор төв, олон нийтийн хөгжлийн төв зэргийг барьж байгуулж, төвлөрсөн халаалт, ариутгах татуурга, ус, цахилгааны хүртээмжтэй байдлыг



нэмэгдүүлснээр шууд өгөөжийг хүртэх боломжтой болно. 2022 онд 240 хүүхдийн ортой цэцэрлэг 2, спорт комплексийн барилга, олон нийтийн хөгжлийн төвийн барилга 2, эрүүл мэндийн төвийн барилгыг ажлыг эхлүүлнэ.

АХБ-ны 175.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 53.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр “Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбар” төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд гэр хорооллын 100 га талбайд 10,000 өрхийн орлогод нийцсэн ногоон, эко хороолол барихаар төлөвлөж байгаа бөгөөд нийт барилгын 15% буюу 1,500 өрхийн орон сууцыг халамжийн, 55% буюу 5,500 өрхийн орон сууцыг орлогод нийцсэн, 30% буюу 3,000 өрхийн орон сууцыг зах зээлийн өртгөөр борлуулах орон сууц байна. 2022 онд түр нүүлгэн шилжүүлэх барилгууд болон халамжийн орон сууцны барилгын ажил, хотын байгууламж, туслах болон хорооллын доторх замууд, шугам сүлжээ болон ногоон байгууламжууд, Баянхошуу болон Сэлбэ дэд төвд баригдах Эко хорооллуудын орлогод нийцсэн болон зах зээлийн үнэлгээтэй орон сууц, үйлчилгээний талбайн барилгын ажлыг эхлүүлнэ.



**Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** чиглэлээр 2022 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 221.9 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 29.4 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 14.9%-ийг эзэлж байна.



Эдийн засгийн хүндрэлийн үед сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахаар АХБ-ны 50.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр, Монгол Улсын Засгийн газрын 0.7 сая ам.долларын

татварын хөнгөлөлтөөр “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Тус төслийн хүрээнд Улаанбаатар хот, Дархан-Уул, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад ерөнхий боловсролын 2 сургууль, 4 цэцэрлэг шинээр барьж, 8 сургууль, 17 цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, тэдгээрт шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангана. 2021 онд 9 байршилд барилгын ажил үргэлжилж, 2 цэцэрлэгийн барилга бүрэн ашиглалтад оруулсан. 2022 онд нийт 23 сургууль, цэцэрлэгийн барилга угсралтын ажил гүйцэтгэх, 14 сургууль, цэцэрлэгийн тавилга, сургалтын хэрэглэгдэхүүн, лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлнэ. Мөн түүнчлэн, тус төслийн нэмэлт санхүүжилтээр АХБ-ны 10.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 3 сургууль, 5 цэцэрлэгийн барилга болон өргөтгөл барих, и-контентүүд боловсруулах, холбогдох сургалтыг зохион байгуулахад зарцуулна. Төслийн нөхцөлийг тохирох, бэлтгэл ажлыг хангах, төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг эцэслэн тохирч, баримт бичгийг боловсруулах ажлуудыг 2021 онд хийсэн бол 2022 онд төслийн үйл ажиллагааг эхлүүлнэ.



Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон талт хариу арга хэмжээ үзүүлэх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахаар АХБ-ны 3.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийг Улаанбаатар хотын Налайх, Сонгинохайрхан дүүрэг, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймагт хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд нийт 5 түр хамгаалах байрын барилгын засварын ажил, хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байруудын үйл ажиллагааг дэмжинэ. 2021 онд 4 түр хамгаалах байрны тавилга, тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулагдсан. 2022 онд СХД-ийн түр хамгаалах байрны шинэ барилгын ажлыг эхлүүлэх, 107 тусламжийн утасны төв байгуулах, шаардлагатай зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.



Коронавирусээр үүсгэгдсэн амьсгалын замын халдварын өвчлөл, нас баралтыг бууруулахаар АХБ-ны 19.0 сая ам.доллар, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АДБХОБ)-ны 21.0 сая

ам.долларын санхүүжилтээр “КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээ төсөл”-ийг тус тус хэрэгжүүлнэ. АХБ-ны санхүүжилтээр



дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн дагуу хүн амын 30 хувийг вакцинжуулна. Мөн АДБХОБ-ны санхүүжилтээр ДЭМБ-аас

зөвшөөрөгдсөн, хатуу зохицуулалттай улс орноос яаралтай нөхцөлд ашиглах зөвшөөрөл авсан эсхүл КОВАКС хөтөлбөрийн хүрээнд зөвшөөрөгдсөн вакциныг худалдан авах, тээвэрлэх ажлыг 2022 онд санхүүжүүлнэ.

Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах зорилгоор АХБ болон ЯБЯС-гийн 5.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр дүүрэг болон хөдөө орон нутгийн эрүүл мэндийн төвүүдийн бэлэн байдлыг дээшлүүлэн 10 ширхэг молекул биологийн лабораторийг бүрэн ашиглалтад оруулах, эмнэлгийн хэрэгслээр хангах, насанд хүрэгчдэд вакцинжуулалтын дэвтрийг нэвтрүүлнэ.



Дэлхийн банкны 77.6 сая ам.долларын эх үүсвэрээр “КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах төсөл”-ийг санхүүжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд Хан-Уул дүүрэгт 300 ортой төрөх эмнэлэг, АШУҮИС-ийн дэргэдэх сургалтын эмнэлэг, Улсын III төв эмнэлэг болон Нийслэлийн 9 дүүргийн болон 21 аймгийн нэгдсэн эмнэлгүүдийг нийт 1,000 орчим нэр төрлийн 11,500 гаруй эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл болон хувийн хамгаалах хэрэгслээр хангаж, эрчимт эмчилгээний 205 орыг тоноглоно. 2021 онд ХӨСҮТ-д хүчилтөрөгчийн бичил үйлдвэрийг ашиглалтад оруулж, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх нийт 50 гаруй нэр төрлийн 2000 гаруй ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. 2022 онд АШУҮИС-ийн сургалтын эмнэлэгт тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нийт 150 гаруй нэр төрлийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг суурилуулна.



Улаанбаатар хотод 4, хөдөөд 5 сумын өрхийн эрүүл мэндийн төв барьж, түргэн тусламжийн төвийн чадавхыг сайжруулж, Ховд, Увс, Дархан болон Хан-Уул дүүрэгт нэгдсэн эмнэлгийг өргөтгөх, шинээр барих, шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг

сайжруулах ажлыг АХБ-ны 116.23 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газрын 0.42 сая ам.долларын хөрөнгөөр санхүүжүүлнэ. 2022 онд Үндэсний түргэн тусламжийн төв, 4 Өрхийн болон 5 сумын эрүүл мэндийн төвүүд, Увс, Ховд аймгийн эмнэлгийн өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ.



Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах хүрээнд АХБ-ны 21.6 сая зээлжих тусгай эрхийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Архангай, Говь-Алтай, Баян-Өлгий, Завхан, Төв, Говьсүмбэр, Дундговь аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийг шинэчлэх, КОВИД-19 болон амьсгалын замын хүнд, хурц хэлбэрийн халдвартай өвчтөнийг оношилж, эмчлэх лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүдийн чадавхийг сайжруулах, Улаанбаатар хотод онцгой байдлын үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн төвлөрсөн агуулахын байгууламжийг барьж, тоноглоно. 2021 онд 7 аймгийн нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийг шинэчлэх барилгын засварын ажил, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг гүйцэтгэсэн бол Түлэнхийн төв, ЭХЭМҮТ-2-ийн ариутгалын тасгийг засварлах, ариутгалын тасгийн болон бусад нэн шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийг 2022 онд нийлүүлнэ.



Ажил хайгч, бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлаас үүдсэн хямралын үед зохих шалгуур хангасан ажиллагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх зорилгоор ДБ-ны 20.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Онцгой байдлын үеийн хөнгөлөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийг хэрэгжүүлж байна. 2022 онд eJob платформыг Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн систем (LMIS)-тэй холбон өргөжүүлэн хөгжүүлэх, бичил бизнес эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.



“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийг АХБ-ны 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, Ядуурлыг бууруулах Японы сангийн 2.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн эх үүсвэрээр

хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд 2021 онд бага насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх үнэлгээний асуумжийг шинэчлэн боловсруулан туршин сайжруулж, Архангай, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймагт шинээр байгуулах ХБХ-ийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. 2022 онд аймгуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга барьж, Улаанбаатар хотод барих ХЭҮХНТөвийн барилга, эдгээрт шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэнэ.



**Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчныг сайжруулах** чиглэлээр 2022 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 159.0 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 67.9 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 13.5%-ийг эзэлж байна.



БНЭУ-ын 20.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Монгол – Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлснээр мэдээллийн технологийн чиглэлээр нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх сертификат олгох сургалт явуулах боломж бүрдэх бөгөөд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч, захиалагчаас мэдээллийн технологийн чиглэлээр үйлчилгээ авч гүйцэтгэх болон “call center” үйлчилгээ үзүүлэх аутсорсингийн нэгдсэн төв байгуулагдана. 2022 онд уг төслийн багц 1, 2-ын гүйцэтгэлийг 80-85%-г хүргэхээр төлөвлөсөн.



Дэлхийн худалдааны байгууллагын “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах хэлэлцээрт” нийцүүлэн Монгол Улсын ургамал, малын эрүүл ахуйн тогтолцоог сайжруулахаар АХБ-ны 10.7 сая зээлжих тусгай эрхийн санхүүжилтээр Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь аймгуудад шаардлагатай байгууламжийн барилга угсралтын ажил, программ болон техник хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ. 2021 онд МХЕГ, МЭЕГ-ын 5 лабораторийн барилга угсралтын ажил, хорио цээрийн байгууламжийн барилга угсралтын ажил, лабораторийн нарийн тоног төхөөрөмжүүд болон энгийн тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн. 2022 онд МХЕГ-ын 3, МЭЕГ-ын 2, нийт 5 лаборатори, 1 хорио цээрийн байгууламжийн барилга

угсралтын ажлыг дуусгаж, хүлээлгэн өгөх ажил хийгдэнэ.



АХБ-ны 54.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг, Боршоо, Бичигт боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажил хийгдэж байна. 2022 онд Алтанбулаг хилийн боомтын авто зам, барилга байгууламж, дэд бүтцийн барилга угсралтын ажил, Сүхбаатар боомтын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын барилгын ажил, хилийн боомтын тоног төхөөрөмж нийлүүлэх, Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем (КАИС)-ийн өргөтгөл, шинэчлэл үргэлжлэн хийгдэнэ. Түүнчлэн, Бичигт, Боршоо хилийн боомтын авто зам, барилга байгууламж, дэд бүтцийн барилга угсралтын ажил, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт үргэлжлэн хийгдэнэ.



## 9. ИРЭЭДҮЙН ӨВ САН



Ирээдүйн өв сангийн тухай хуульд нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ гэж, “Алсын хараа-2050” болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход шаардагдах тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасан болно.

Түүнчлэн, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргадаг судалгаанаас үзэхэд эдийн засгийн хөгжил, тогтвортой байдлаараа дэлхийд тэргүүлдэг Швейцар, Швед, ХБНГУ зэрэг орнуудын иргэд нь орлогынхоо тодорхой хувийг жил бүр хуримтлуулдаг байна. Эдгээр орнуудын хөгжлийн замналд иргэдийн хуримтлал нэн чухал байсан ба хуримтлалын ач холбогдол, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас бий болгосон байна.

Манай улсын хувьд төрөөс хүүхдэд мөнгөн тэтгэмж олгож хэвшсэн бөгөөд тэтгэмжийн хэмжээ, давтамж зэргийг 2006, 2007, 2009, 2012 онуудад тухай бүр өөрчилсөн бол Коронавируст цар тахлын үед хүүхэд багачуудыг хүнс, тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, теле-хичээл, цахим сургалтад хамрагдах боломжоор хангах зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхэд бүрд сар бүр 100.0 мянган төгрөгийг олгож байна.

Хэдийгээр цар тахлын үед дээрх арга хэмжээ нь цагаа олсон, хүртээмж, үр дүн өндөртэй байгаа боловч урт, дунд хугацаанд бэлэн мөнгө тараах халамжийн бодлогоос үе шаттайгаар татгалзаж, хүүхдийн хуримтлалын тогтолцоонд шилжих шаардлагатай байна.

Энэ хүрээнд байгалийн баялгаас орох орлогын хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол улсын ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач

тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай, мэдлэг боловсролтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тус сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг арилжааны банкна дахь хүүхдийн нэрийн дансанд хуримтлуулахаар төлөвлөлөө.

Ингэснээр Монгол Улсын хүүхэд бүр Ирээдүйн өв сангаар баталгаажсан, Хадгаламжийн даатгалын сангаар даатгуулсан, хамгийн эрсдэл багатай системийн нөлөө бүхий банкуудад нэрийн дансны хуримтлалтай болж, хадгалах, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас суралцахаас гадна 18 нас хүрээд нэрийн дансны хуримтлалаар өөрийн боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Ковид-19 цар тахлын нөлөө бүрэн арилаагүй шилжилтийн хугацаанд бага дунд орлоготой өрхүүд орлогын эрсдэлд орж болзошгүй тул хуримтлалд бүрэн шилжих бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хадгаламж нээлгэсэн хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч хэрвээ хүсвэл хүүхдийн нэрийн дансанд сар бүр төвлөрөх мөнгөн хадгаламжийн тодорхой хувийг бэлнээр авах боломж олгож байна. Тодруулбал, 2022 оны төсвийн жилд, 1 дүгээр сарын 1-ээс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд сар бүрийн хуримтлалыг 100,000 төгрөг хүртэл сонголтоор, харин 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 50,000 төгрөгөөс доошгүй хэсгийг хуримтлуулж үлдсэн 50,000 төгрөгийг бэлнээр буюу хүүхэд бүрд нийт 100,000 төгрөг гэсэн зарчмыг хадгална.



Ирэх 2022 онд Ирээдүйн өв сангийн орлогын гол эх үүсвэр болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 1,057.2 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит компаниудын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаар 404.5 тэрбум төгрөг нийтдээ 1,461.7 тэрбум төгрөгийг 2022 онд тус санд төвлөрүүлж хүүхдийн мөнгөн хадгаламж бий болгохоор тусгалаа.

*Хүснэгт № 18. Ирээдүйн өв сангийн орлого, тэрбум төгрөг*

	2020 гүйц	2021 бат	2022 төс
ИӨС-ийн орлого	914.1	1,062.4	1,461.7
ИӨС-ийн зарлага	-	-	1,461.7

## 10. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР



### 10.1. Засгийн газрын өр

*Засгийн газрын өр 2021 онд өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 61.2 хувьд хүрнэ.*

Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу Сангийн яам нь “Засгийн газрын өр”-ийн үлдэгдлийг улирал тутам тоохон бэлтгэж, олон нийтэд мэдээлж байна. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2020 оны жилийн эцсийн байдлаар нэрлэсэн дүнгээр 27.9 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 62.3 хувьд хүрээд байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 31.1 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний 61.2 хувьд хүрэхээр төсөөлөгдөж байна.

Засгийн газрын өрийн бүтцийн хувьд 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дотоод өр 12.1 хувь, гадаад өр 81.8 хувь, Засгийн газрын өрийн баталгаа болон барих-шилжүүлэх төрлийн концесс 6.1 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт № 19. Засгийн газрын өрийн бүтэц, тэрбум төгрөг*

ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2020.12.31	2021 ХБГ
<b>I. Засгийн газрын дотоод өр</b>		1,136.6	3,773.0
1.1	Үнэт цаас	1,136.6	3,773.0
<b>II. Засгийн газрын гадаад өр</b>		24,851.4	25,422.6
2.1	Үнэт цаас	8,354.0	8,179.1
2.2	Зээл	16,497.4	17,243.5
<b>III. Засгийн газрын бусад өр</b>		1,910.6	1,893.4
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	1,060.4	960.1
3.2	"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	850.2	933.4
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)</b>		<b>27,898.6</b>	<b>31,089.0</b>
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)</b>		<b>23,024.3</b>	<b>25,994.2</b>
<b>Хуулиар тогтоосон өрийн хязгаар</b>		<b>70.0%</b>	<b>70.0%</b>
<b>Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ</b>		<b>62.3%</b>	<b>61.2%</b>

Засгийн газрын өрийн хэрэгсэл тус бүрээр авч үзвэл 2020-2021 оны хооронд Засгийн газрын өрийн баталгаа 9.5 хувиар, Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2.1 хувиар тус тус буурч, гадаад зээлийн үлдэгдэл 4.5 хувиар нэмэгдэхээр байна.


Сүүлийн жилүүдэд Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт

бичигт туссан зорилтуудыг хангах арга хэмжээний хүрээнд арилжааны нөхцөлтэй гадаад болон дотоод зээллэг хийхээс татгалзах бодлогыг баримталсан хэдий ч төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар авч ашигласан хөнгөлөлттэй нөхцөлтэй гадаад зээлийн үлдэгдэл өсөж, олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас төсвийн дэмжлэгийн зориулалтаар гадаад зээлийг түлхүү авч ашигласан нь Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл өсөхөд голлох нөлөөг үзүүлж байна. Мөн Засгийн газрын өрийн баталгааны хувьд 2017 оноос хойш шинээр баталгаа гаргаагүй байна.

#### 10.1.1. Засгийн газрын дотоод үнэт цаас


Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд Засгийн газрын үнэт цаас арилжаалаагүй тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 3 дахин буурч 2021 оны эхний хагас жилийн байдлаар 1,046.1 тэрбум төгрөгт хүрсэн. Төсвийн алдагдал 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр дотоодын нийт бүтээгдэхүүний 8.8 хувьтай тэнцэх алдагдалтай байхаар батлагдсан тул төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төвлөрүүлэх зорилгоор 2,852.4 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаас гаргахаар төлөвлөж байна. Харин 2022 онд төсвийн алдагдал ДНБ-ий 5.1 хувьд хүрэхээр тооцоологдож, өрийн үндсэн төлбөрт 3,099.6 тэрбум төгрөг төлөхөөр байгаа тул 3,666.3 тэрбум төгрөг хүртэлх дотоод үнэт цаас арилжаалахаар төлөвлөж байна.

*График № 46. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл ба*



## 10.1.2. Засгийн газрын гадаад үнэт цаас


График № 47. Century өрийн зохицуулалтын хүүгийн хэмжээ



Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2021 онд “Сенчюри” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан 2012 онд гаргасан “Чингис” бонд болон 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын өр төлбөрийн тодорхой хувийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй, 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өр төлбөрийг шийдвэрлэсэн.

## 10.1.3. Засгийн газрын гадаад зээл


Засгийн газрын 1990 оноос 2021 оны эхний хагас жилийн байдлаар түнш орнууд болон олон улсын байгууллагаас авч ашигласан гадаад зээлийн үлдэгдэл 5,753.6 сая ам.доллартой тэнцэж байгаа бөгөөд байгуулагдсан гадаад зээлийн гэрээ, хэлэлцээрийн хүрээнд 300 гаруй төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдаг. Үүнээс зам, тээвэр, уул уурхай, эрчим хүч болон эрүүл мэндийн салбарт 50 гаруй хувийг олгосон байна.



Түүнчлэн Засгийн газар 2021 онд 1,205.1 тэрбум төгрөгийн гадаад зээлийн эх үүсвэрийг түнш орнууд болон олон улсын байгууллагуудаас төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх зориулалтаар авч ашиглахаар батлагдсан.

Үүнд Азийн хөгжлийн банк (584.7 тэрбум төгрөг), Дэлхийн банк (223.9 тэрбум төгрөг), БНХАУ (123.8 тэрбум төгрөг) болон бусад (272.7 тэрбум төгрөг) байна. Харин 2022 онд нийт 1,384.0 тэрбум төгрөгтэй тэнцэх гадаад зээл авч ашиглахаар тооцоолсноос 491.4 тэрбум төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас, БНХАУ-аас 249.3 тэрбум төгрөг, Бүгд найрамдах Энэтхэг улсаас 154.6 тэрбум төгрөгтэй тэнцэх гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглаж 121 төслийг санхүүжүүлэхээр байна.

График № 48. Гадаад зээлийн жилийн дундаж хүү, хувь



Засгийн газрын гадаад зээлийн жилийн дундаж хүү 2018 оноос 2022 оныг хүртэл 0.12 хувиар буурсан байна. Энэ нь 2016 оноос хойш арилжааны нөхцөлтэй зээллэг хийгээгүйтэй холбоотой ба цаашид тус бодлогыг хэрэгжүүлэхээр ажиллах төлөвлөгөөтэй байна.


Түүнчлэн дээрх гадаад зээлийн ашиглалтын хүрээнд нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”, “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төсөл”, “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”, “Улаанбаатар-Дарханы чиглэлд нэмэлт дөрвөн эгнээ зам барих төсөл” болон “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж шинээр барих” зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна.

## 10.1.4. Барих-шилжүүлэх концесс

Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 10 концессын гэрээний үлдэгдэл 2020 оны жилийн эцэст 849.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бол орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй 6 концессын гэрээний хүрээнд 0.7 тэрбум төгрөгийг 2021 онд төлж барагдуулах хуваарьтай байна. Засгийн газар 2017 оноос хойш шинээр “Барих-шилжүүлэх” төрлийн

концессын гэрээ байгуулаагүй бөгөөд өмнөх жилүүдэд байгуулагдсан гэрээний ашиглалтын хүрээнд өрийн үлдэгдэл нэмэгдэж ирсэн.


График № 49. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл



### 10.1.5. Засгийн газрын өрийн тусгай шаардлага

Засгийн газрын зүгээс төсөвт дарамт нөлөө учруулахгүйгээр хөгжлийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих тохиолдолд Засгийн газрын өрийн үлдэгдэл (ӨҮЦ)-ийн ДНБ-д эзлэх харьцаа суурь төсөөллөөс мэдэгдэхүйц өсөж 2022 онд 67.2 хувь, 2023 онд 62.9 хувь, 2024 онд 59.4 хувьд тус тус хүрэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

График № 50. Засгийн газрын өрийн тусгай шаардлагын хэрэгжилт



Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагын тооцоолол нь ирэх онуудад бий болох эдийн засгийн өсөлт, Засгийн газрын өрийн баталгаа гаргах хэмжээ, валютын ханшийн тооцоолол болон төсвийн алдагдал зэрэг макро эдийн засгийн суурь хүчин зүйлсээс шалтгаална.

### 10.1.6. Болзошгүй өр төлбөр

“Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна. Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн төлбөрийг Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ), “МИАТ” ТӨХК, “Эрдэнэс Монгол” ХХК зэрэг зээл авсан байгууллагууд эргэн төлөлтийн хуваарийн дагуу хэвийн гүйцэтгэж байна.

#### МИАТ ТӨХК-д гаргасан Засгийн газрын баталгаа.

**1. Бойнг агаарын хөлөг худалдан авсан зээл** - Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолын дагуу МИАТ /ТӨХК/-ийн Бойнг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авахад зориулан 121.4 сая ам.долларын 3 дэд хэсгээс бүрдэх зээллэгт баталгаа гаргасан. Үүнээс 2 дэд зээллэгийн төлбөр бүрэн төлөгдөж дууссан бөгөөд 1 дэд зээлийн үлдэгдэл 2021 оны хагас жилийн байдлаар 14.3 сая ам.доллар байна. МИАТ ТӨХК энэхүү зээлийг хуваарийн дагуу 2021 оны сүүлийн хагас жилд 2.0 сая ам.доллар, 2022 онд 8.15 сая ам.доллар, 2023 онд 2.0 сая ам.долларын үндсэн төлбөрийг төлнө.

#### МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа.

**2. “Самурай” үнэт цаас** - МУХБ 2014 оны 01 сарын 06-ны өдөр Японы зах зээл дээр 30.0 тэрбум иений “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ гэрээний дагуу “Самурай” үнэт цаасны үндсэн төлбөрийг 2023 онд төлөх хуваарьтай байна.

**3. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл** - МУХБ 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 162.0 сая ам.долларын 8 жилийн хугацаатай, 6.0 хувийн хүүтэй, зээл авсан бөгөөд Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу Засгийн газар баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2021 оны хагас жилийн байдлаар 40.5 сая ам.доллар байна. МУХБ-ны зүгээс хуваарийн дагуу 2022 онд 27.0 сая ам.долларын үндсэн төлбөрийг төлнө.



## “Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа.

**4. Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл** “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Зээлийн үлдэгдэл 2021 оны хагас жилийн байдлаар 9.3 сая ам.доллар байгаа бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна.

**5. Засгийн газрын тусгай сангийн авлага.** Засгийн газраас Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан /ЖДҮДС/, Хөдөө аж ахуйг дэмжих сан /ХААДС/-д зээлийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор 2008-2010 онуудад дотоод эх үүсвэрээс буюу Засгийн газрын бондын эх үүсвэр болон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр эх үүсвэр олгосон.

Энэ оны эхний хагас жилийн байдлаар хоёр сангийн улсын төсөвт эргэн төлөх зээлийн нийт үлдэгдэл 48.3 тэрбум төгрөг /үүнээс ЖДҮДС-д олгосон зээлийн үлдэгдэл 31.6 тэрбум төгрөг, ХААДС-д олгосон зээлийн үлдэгдэл 16.7 тэрбум төгрөг/ байна.

*Хүснэгт № 20. Засгийн газраас ЖДҮДС, ХААДС-д зээлийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн мэдээлэл (2021.06.30-ны байдлаар), тэрбум төгрөг*

Өглөг	Сан	Олгосон эх үүсвэр	Эх үүсвэрийн үлдэгдэл	
			2020	2021.06
МУХС /улаан буудай/	ХААДС	21.0	8.6	5.8
МХС-ийн төсвийн зээл /өвс, тэжээл бэлтгэх/	ХААДС	40.0	11.9	10.9
Засгийн газрын бонд	ЖДҮДС	290.1	43.6	31.6
<b>НИЙТ</b>		<b>351.1</b>	<b>64.1</b>	<b>48.3</b>

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд тусгасны дагуу энэ оны эцэст ЖДҮДС-аас улсын төсөвт 25.6 тэрбум төгрөг төвлөрүүлэх бөгөөд үлдэх 18.0 тэрбум төгрөгийг 2022 оны төсвийн жилд бүрэн төлж барагдуулахаар тусгасан.


ХААДС-ийн хувьд ирэх 2022 онд улсын төсөвт 16.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тусгасан бөгөөд ингэснээр 2022 онд ЖДҮДС, ХААДС-д дотоод эх үүсвэрээс олгосон зээлийг бүрэн барагдуулж дуусгахаар ажиллаж байна.

## 10.2. Дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, хүрэх үр дүн

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т заасан үндсэн 5 зорилтын хүрээнд дунд хугацааны өрийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

**1 Өрийн зохицуулалтын арга хэмжээ.** Засгийн газрын зүгээс арилжааны нөхцөлтэй 2022-2024 онуудад төлөгдөх 1.3 тэрбум ам.долларын гадаад үнэт цаасыг зах зээлийн тохиромжтой нөхцөлд төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр хугацаанаас нь өмнө төлж барагдуулах, өрийн зохицуулалт хийх бодлогыг үргэлжлүүлнэ. Мөн олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудад төлөх өр төлбөрийн хүрээнд коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотойгоор хөгжингүй улс орнууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын гаргаж байгаа санал санаачилгыг судалж, эдийн засаг, гадаад зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2021 онд “Сенчюри” бондыг арилжаалж 2022 онд төлөгдөх хуваарьтай байсан “Чингис” бонд, 2023 онд төлөгдөх хуваарьтай “Гэрэгэ” бондыг дахин санхүүжүүлсэн.

*График № 51. Гадаад үнэт цаасны үндсэн төлбөр, өрийн зохицуулалт, сая ам.доллар*



Цаашилбал 2022 онд ирэх онуудад төлөгдөх гадаад бондуудын төлбөрийн хүрээнд өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

**2 Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн үр ашгийг нэмэгдүүлнэ.** Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж,

тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2006 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 185 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх журам”-ыг 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 210 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Дээрх шинэчлэн батлуулсан журмаар гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг үнэлэх, төслийн хэрэгжилтэд хяналт тавих болон өр төлбөрийг бүртгэх механизмуудыг сайжруулан тусгасан байна. Үүний үр дүнд төслийн эрсдэлийг үнэлж, илүү нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төслийг санхүүжүүлж, эргэн төлөлтийг сайжруулах боломж бүрдсэн байна.

3

***Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг боловсронгуй болгоно.***

Засгийн газрын зүгээс 2021 оноос эхлэн блокчейн технологи ашигласан цахим арилжааны системээр дотоод үнэт цаасыг олон нийтэд нээлттэйгээр арилжаалахаар төлөвлөж байгаа бөгөөд тус цахим систем нь иргэд, аж ахуйн нэгж нээлттэй, өрсөлдөөнт байдлаар хөрөнгийн зах зээлийн хамгийн найдвартай, эрсдэлгүй санхүүгийн хэрэгслийг худалдан авах боломжийг олгох ач холбогдолтой.

4

***Болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулна.***

Засгийн газрын зүгээс баталгаанаас үүсэх болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэн, Засгийн

газрын өрийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг бууруулах зорилгын хүрээнд өрийн баталгаа нэмж гаргахгүй байх бодлогыг хэрэгжүүлсээр байна. Түүнчлэн Засгийн газрын өрийн баталгаатай холбоотой харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 146 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 94 дүгээр тушаалаар баталсан журмаар зохицуулж байсныг нэгтгэн, нэг эрх зүйн актаар зохицуулахаар “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам”-ыг 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор шинэчлэн батлуулсан. Ингэснээр Засгийн газрын баталгаа бүхий төсөл, арга хэмжээнд жил бүр эрсдэлийн үнэлгээ хийх, баталгаа гаргуулагчийн хувьд үүсэж болох байгууллагын эрсдэлээс сэргийлэх зэрэг өөрчлөлтийг хийсэн байна.

5


***Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлнэ.***

Олон улсын санхүүгийн байгууллагууд хамтран Засгийн газрын өрийн удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг бөгөөд Монгол Улсын зүгээс 2008-2016 онд хангалтгүй үнэлэгдэж ирсэн. Сангийн яамны зүгээс өрийн удирдлагын тогтолцооны болон үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөөний дагуу шат дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэн, өрийн удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулах бодлогыг баримталж байна.

## Өрийн тогтвортой байдлын шинжилгээ


Өрийн тогтвортой байдлын шинжилгээнд аливаа улсын Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 50 хувиас давсан тохиолдолд тухайн улсыг “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд багтаан илүү нарийвчилсан шинжилгээг хийдэг. Монгол Улсын Засгийн газрын нэрлэсэн өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх харьцаа 2020 онд 75.5 хувь байгаа ба 2023 он хүртэл Засгийн газрын өрийн баталгаа гаргаагүй тохиолдолд тус харьцаа 70 хувиас их байхаар төсөөлөгдөж байгаа тул “Сайтар шинжлэх” шаардлагатай орны ангилалд орж байна.

Сүүлийн 10-н жил болон ирэх 3-н жилийн Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа хэрхэн өсөж, буурахаар байгааг Графикт харууллаа. Засгийн газрын өрийн хэмжээ 2012-2016 онд ихээхэн хэмжээгээр өссөн байна. Үүнд Засгийн газар баталгаа гаргаж эхэлсэн, төсөв алдагдалтай батлагдсан, валютын ханш суларч байсан зэрэг үзүүлэлтүүд ихээхэн нөлөө үзүүлжээ. Харин Засгийн газрын өр, ДНБ-ний харьцаа 2017-2019 онуудад буурсан нь ДНБ-ний өсөлт болон бодит хүүгийн түвшний бууралт зэргээс хамаарсан байна. Цаашид ч бодит ДНБ-ний өсөлтийг дэмжиж, төсвийн үндсэн тэнцлийг бууруулах нь өрийн тогтвортой байдлыг хангах суурь үндэс болохоор байна. 2022-2023 онуудын хувьд валютын ханш 2.8 болон 4.1 хувиар суларч, төсвийн үндсэн тэнцэл алдагдалтай байхаар төсөөлөгдсөн ба тус онуудад бодит ДНБ-ний өсөлт өндөр байхаар төсөөлөгдөж байгаа нь өрийн ДНБ-д эзлэх харьцааг бууруулах гол хүчин зүйл болохоор байна.



## Өрийн эмзэг байдлын шинжилгээ

Монгол Улсын өрийн эмзэг байдлыг одоогийн тоон мэдээлэлд үндэслэн үнэлбэл бондын өгөөжийн зөрүү, гадаад санхүүжилтийн хэрэгцээ, Засгийн газрын богино хугацаат өрийн жилийн өөрчлөлт, Засгийн газрын гадаад өр болон Засгийн газрын гадаад валютаарх өр зэрэг 5 үзүүлэлтийн 3 нь анхааруулах дээд түвшнээсээ давсан байна.



- 1. Бондын өгөөжийн зөрүү:** МУЗГ-ын олон улсын зах зээлд гаргасан бондын 3 сарын дундаж өгөөж АНУ-ын ижил хугацаатай ЗГ-ын бондтой харьцуулахад 3.39%-иар өндөр буюу үүнтэй дүйцэхүйц эрсдэлийн нэмэгдэлтэй хэмээн зах зээлд үнэлэгдэж байна. Энэ нь нь дээд анхааруулах түвшин 6%-иас бага үзүүлэлт юм.
- 2. Гадаад санхүүжилтийн хэрэгцээ:** 2020 оны урсгал тэнцэл, улсын болон хувийн секторын гадаад өрийн үйлчилгээний төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдох ДНБ-д эзлэх уг үзүүлэлт 19.0% байгаа нь дээд анхааруулах түвшин 15%-аас давж, гадаад санхүүжилтийн хэрэгцээний хувьд өндөр эрсдэлтэй гэсэн үр дүнг үзүүлж байна.
- 3. Засгийн газрын богино хугацаат өрийн жилийн өөрчлөлт:** 2020 оны гүйцэтгэлээр нийт өрд эзлэх ЗГ-ын богино хугацаат өрийн үлдэгдэл 0.9 хувиар өссөн байгаа нь дээд анхааруулах түвшин 1%-иас бага үзүүлэлтээс бага, доод шалгуур үзүүлэлт буюу 0.5%-аас их байгаа нь дундаж эрсдэлтэй гэсэн үр дүнг харуулж байна.
- 4. Засгийн газрын гадаад өр:** Уг үзүүлэлтийн анхааруулах дээд түвшин 45% бөгөөд манай улсын хувьд 93% байгаа нь гадаад өрийн дарамт өндөр, гадаад санхүүжилтээс хэт их хамааралтайг харуулж байна.
- 5. Засгийн газрын гадаад валютаарх өр:** Уг үзүүлэлтийн анхааруулах дээд түвшин 60% бөгөөд манай улсын хувьд 93% байгаа нь гадаад өрийн дарамт өндөр, гадаад валютын ханшийн эрсдэлд эмзэг байгааг илтгэнэ.



# 11. АРВАН ИХ НАЯДЫН ЦОГЦ ТӨЛӨВЛӨГӨӨ



## 11.1. Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө



“Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 их наядын цогц төлөвлөгөө”-г баталсан.

Энэхүү цогц төлөвлөгөөний хүрээнд эдийн засгаа сэргээх чиглэлээр 1) ажлын байрыг дэмжих зээл, 2) репо санхүүжилтийн зээл, 3) ипотекийн зээл, 4) хөдөө аж ахуйн зээл зэрэг үндсэн дөрвөн сувгаар зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж, ингэснээр банкны секторын зээл 10.5 хувиар агших байсныг 6.5 хувийн өсөлттэй хадгаллаа. Улмаар энэ оны эхний хагас жилийн байдлаар банкны нийт зээлийн хэмжээ 18.1 их наяд төгрөгт хүрч, зээл олголт цар тахлын өмнөх үе буюу 2019 оны түвшинд хүрсэн байна.

График № 52. Банкны зээл олголт (2021 оны хагас жилийн байдлаар), их наяд төгрөг



И	II	III	IV	И	II	III	IV	И	II
2018	2019	2020	2021						

Төлөвлөгөөнд тусгагдсан зээлийн хөтөлбөрийг 2021-2024 оны хооронд хэрэгжүүлэх бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 28-ны байдлаар нийт 58,122 зээлдэгчид (50,443 иргэн, 7,679 ААН) 3,771.2 тэрбум төгрөгийн зээлийг банкуудын эх үүсвэрээр олгож, 10,401 иргэнийг орон сууцжуулж, 267,743 ажлын байрыг хадгалсан үзүүлэлтэй байна.

Улмаар, цар тахлын улмаас удаашралд ороод байсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлсөн байна.

График № 53. 10 их наядын цогц төлөвлөгөөний зээлийн хэрэгжилт, тэрбум төгрөг (2021.09.28-ны байдлаар)




График № 54. 10 их наядын төлөвлөгөөний эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө



### 11.1.1. Ажлын байрыг дэмжих зээл.

Бизнес эрхлэгчдийн санхүүгийн үйл ажиллагааг дэмжиж, ажлын байрыг хадгалах зорилгоор Сангийн яам, Монголбанк, арилжааны банк, Зээлийн батлан даалтын сан хооронд Ажлын байрыг дэмжих зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээ байгуулагдаж, уг гэрээний дагуу жилийн 3 хувийн хүүтэй Ажлын байрыг дэмжих зээлийг банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгож байна.

Тус зээлийн хэрэгжилт 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар 93.6 хувьтай байгаа ба нийт 24,575 иргэн, аж ахуйн нэгж (19,161 иргэн, 5,414 ААН)-д 1,872.3 тэрбум төгрөгийн зээлийг банкуудын эх үүсвэрээр олгоод байна. Улмаар, 103.6 мянган ажлын байрыг хадгалж, үүнээс 51 мянган ажлын байр шинээр бий болгосон байна.


Зээл авсан аж ахуйн нэгжийн 6 нэгж хувь, иргэний 7 нэгж хувийг төрөөс хариуцан төлж байхаар зохицуулсан бөгөөд зээлийн хүүгийн татаасанд шаардагдах зардлын эх үүсвэрийг тухайн жил бүрийн улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан.

График № 55. Ажлын байрыг дэмжих зээлийн авсан иргэн, ААН болон хадгалагдсан ажлын байрны тоо, мянган хүн (2021 оны 9 дүгээр сарын 28-ны байдлаар)




Энэ онд ажлын байрыг дэмжих зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 98.9 тэрбум төгрөгийг төсөвт тусгаад байгаа бол зээлийн хэмжээг дахин 1.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж байгаатай холбогдуулан 2022 оны төсвийн төсөлд 210.1 тэрбум төгрөг тусгалаа.

### 11.1.2. Репо санхүүжилтийн зээл.


 Коронавируст цар тахлын үед уул уурхайн бус салбарын бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдгээрийн зээлийн хүүгийн ачааллыг бууруулах зорилгоор репо санхүүжилтийн зээлийг Монголбанкны санхүүжилтийн арга хэмжээний хүрээнд олгож байгаа бөгөөд 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 3,084 зээлдэгчид (1,396 иргэн, 1,688 ААН)-д 725.3 тэрбум төгрөгийн зээлийг олгосон үзүүлэлттэй байгаа ба үүний

61.6 хувь буюу 447.1 тэрбум төгрөгийн зээлээр ижил төрлийн зээлийг дахин санхүүжүүлж, зээлийн нөхцөлийг сайжруулсан бол энэхүү зээлийн хүрээнд нийт 32,044 мянган ажлын байр хадгалсан үр дүнтэй байна.

### 11.1.3. Ипотекийн зээл.

 Иргэдийн амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах үүднээс орон сууц худалдан авахад зориулж ипотекийн 6 хувийн зээлийг олгож эхэлсэн бөгөөд оны эхнээс нийт 10,401 иргэнд 782.3 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Үүнээс 2,500 иргэн буюу нийт зээлд хамрагдсан иргэдийн 24.0 хувь нь орон нутагт орон сууц худалдан авсан байна.

### 11.1.4. Хөдөө аж ахуйн зээл.

 Малчдын малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр болон ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрлэл, газар тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөө аж ахуйн зээлийг банкуудын эх үүсвэрт тулгуурлан олгож, зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн хүүгийн 7.65 хүртэлх хувийг Засгийн газраас хариуцан төлөхөөр банкуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд нийт 20,062 зээлдэгчид 324.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд үүнээс 194.3 тэрбум төгрөгийн зээлийг 19,480 малчин өрхөд олгосон үзүүлэлттэй байна.

## 12. МАКРО ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ




### 12.1. Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл

**1** *Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн уналт удаан үргэлжлэх.* Одоогоор коронавируст халдвар (КОВИД-19)-ын тархалтын үргэлжлэх хугацаа тодорхойгүй байна. Дэлхийн эдийн засагт сэргэлт бий болж байгаа ч цар тахлын үргэлжлэх хугацаа, дэлхийн 2022 оны эдийн засагт үзүүлэх хор уршгийн хэмжээ тодорхойгүй, цаашид халдварын давлагаа дахин гарч болзошгүй эрсдэл хэвээр байна. Энэ нь эдийн засгийн өсөлт төсөөлснөөс бага гарах эрсдэлийг дагуулж байна.

**2** *Цаг агаарын хүчин зүйлсээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарах.* Хур тунадасны хэмжээ 2022 онд олон жилийн дунджаас өндөр байх, өвөлжилт хүндрэх тохиолдолд хөдөө аж ахуйн салбарын өсөлт, бүтээмж төсөөлсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэлтэй байна. Мөн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурах нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж, хүнсний бүлгийн үнийг хөөрөгдөх хор уршигтай байна.

### 12.2. Төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл

 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын дэгдэлтийн нөлөөгөөр олон улсын нийгэм, эдийн засагт үүсээд байгаа тодорхой бус байдал нь ирэх оны төсвийн орлогын голлох эрсдэл байхаар байна.

БНХАУ болон бусад улсын эдийн засгийн сэргэлт холбоотойгоор энэ онд олон улсын зах

зээл дээрх зэсийн үнэ харьцангуй өндөр болж, эхний 8 сарын байдлаар 9,169.8 ам.долларт хэлбэлзэж, цаашид энэ түвшинд хадгалагдах төлөвтэй байна.



Гэвч дэлхий даяар вакцинжуулалтын түвшин хангалттай бус, мөн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын мутацид орсон хувилбар шинээр бий болж байгаа нь улс орнуудыг дахин хөл хорио тогтоох болзошгүй эрсдэлийг дагуулж байна. Улмаар дэлхийн эдийн засгийн идэвхжил суларч, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах, дотоод болон гадаад хөл хорио тогтоосны улмаас гадаад худалдааны эргэлт саарах, эрдэс бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ төлөвлөснөөс буурах зэрэг эрсдэлтэй байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг дагаж Төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд аж ахуйн нэгжийн орлогын 40 хувийг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилна.

Энэ хүрээнд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн 2022 оны үйл ажиллагааны орлогыг нэг бүрчлэн тооцож холбогдох аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах шаардлага үүсэж байна. Ийнхүү орлогыг хуваарилах явцад Өмнөговь, Орхон, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Завхан, Хэнтий, Дорноговь, Дархан-Уул зэрэг аймгуудын орлогын дийлэнх хэсэг нь цөөн тооны аж ахуйн нэгжээс хамаарч байгаа бөгөөд урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас тэдгээрийн үйл ажиллагаа доголдох, санхүүгийн үзүүлэлтүүд муудах тохиолдолд тухайн аймгийн төсвийн орлого буурах эрсдэлтэй байна.

## Графикууд

График № 1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувь.....	3
График № 2. Улсуудын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувь .....	3
График № 3. Зэсийн үнийн төсөөлөл, ам.доллар/тонн .....	2
График № 4. Алтны үнийн төсөөлөл, ам.доллар/трой унц .....	2
График № 5. Төмрийн хүдрийн үнийн төсөөлөл, ам.доллар/тонн .....	3
График № 6. Нүүрсний үнийн төсөөлөл, ам.доллар/тонн .....	3
График № 7. Газрын тосны үнийн төсөөлөл, ам.доллар/баррель .....	3
График № 8. ДНБ-ий өсөлтийн бүтэц, хувь, улирлаар .....	4
График № 9. Гадаад худалдааны гүйцэтгэл, тэрбум ам.доллар .....	4
График № 10. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар .....	5
График № 11. Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг .....	5
График № 12. Жилийн инфляц ба суурь инфляц, хувь .....	5
График № 13. Инфляцын бүтэц, хувь .....	5
График № 14. Эдийн засгийн өсөлт, хувь .....	6
График № 15. Эдийн засгийн өсөлт, салбараар, хувь .....	6
График № 16. Барилгын салбарын өсөлт, хувь .....	6
График № 17. Гадаад худалдаа, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум ам.доллар .....	7
График № 18. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар .....	7
График № 19. Төрийн өмчийн хуулийн этгээдийн S-Score тооцоолол .....	12
График № 20. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /2018-2022 он/, их наяд төгрөгөөр .....	23
График № 21. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /2021-2014 он/, ДНБ-д эзлэх хувь .....	23
График № 22. Засгийн газрын өр /2021-2024 он/ .....	23
График № 23. Нийт орлого ба тусламжийн дүн, их наяд төгрөг.....	24
График № 24. Уул уурхайн болон бусад салбараас төвлөрүүлэх орлого, их наяд төгрөг .....	25
График № 25. Татварын хувь хэмжээ /улсуудаар/, хувь.....	25
График № 26. Татварын орлогын бүтэц, хувь .....	26
График № 27. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого /уул уурхай, уул уурхайн бус салбараар/, тэрбум төгрөг.....	26
График № 28. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах бүтэц, хувь .....	26
График № 29. Хувь хүний орлогын албан татварын орлого, тэрбум төгрөг .....	27
График № 30. НӨАТ-ын татвар төлөгч болон орлого.....	27
График № 31. Автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлого, тэрбум төгрөг .....	28
График № 32. Суудлын автомашины импортын тоо .....	28
График № 33. Импортын гаалийн болон НӨАТ, тэрбум төгрөг .....	28
График № 34. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого, тэрбум төгрөг .....	29
График № 35. Газрын төлбөрийн орлого, тэрбум төгрөг .....	29
График № 36. Газрын тосны экспортын хэмжээ, үнэ.....	30
График № 37. Урсгал зардлын өсөлт /их наяд төг, хувиар/.....	32
График № 38. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар/ .....	32
График № 39. Нэг хүүхдэд ногдох урсгал зардал, сургуулийн хэв шинжээр /сая төгрөг/.....	34
График № 40. ЕБС-н бүлэг дүүргэлт ба нэг сурагчид ногдох зардлын хамаарал /2021 он/.....	35
График № 41. Нийгмийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/ .....	45
График № 42. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь.....	47
График № 43. Улсын төсвийн хөрөнгийн зардал, эдийн засгийн ангиллаар. ....	47
График № 44. 2022 онд санхүүжих дүн, тэрбум төгрөг.....	50
График № 45. Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, тэрбум төгрөг.....	52
График № 46. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл ба .....	60
График № 47. Century өрийн зохицуулалтын хүүгийн хэмжээ .....	61
График № 48. Гадаад зээлийн жилийн дундаж хүү, хувь.....	61
График № 49. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл .....	62
График № 50. Засгийн газрын өрийн тусгай шаардлагын хэрэгжилт .....	62

График № 51. Гадаад үнэт цаасны үндсэн төлбөр, өрийн зохицуулалт, сая ам.доллар .....	63
График № 52. Банкны зээл олголт (2021 оны хагас жилийн байдлаар), их наяд төгрөг.....	67
График № 53. 10 их наядын цогц төлөвлөгөөний зээлийн хэрэгжилт, тэрбум төгрөг (2021.09.28-ны байдлаар) .....	67
График № 54. 10 их наядын төлөвлөгөөний эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө .....	67
График № 55. Ажлын байрыг дэмжих зээлийн авсан иргэн, ААН болон хадгалагдсан ажлын байрны тоо, мянган хүн (2021 оны 9 дүгээр сарын 28-ны байдлаар) .....	68

## **Хүснэгтүүд**

Хүснэгт № 1. Эдийн засгийн өсөлт, хувь, салбаруудаар .....	4
Хүснэгт № 2. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, хувь .....	8
Хүснэгт № 3. Нэгдсэн төсвийн 2021 оны 8 дугаар сарын байдлаарх гүйцэтгэл, тэрбум төгрөг .....	22
Хүснэгт № 4. Нэгдсэн төсвийн үзүүлэлт, тэрбум төгрөг .....	22
Хүснэгт № 5. 2022 оны нэгдсэн төсвийн нийт орлого .....	24
Хүснэгт № 6. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө, тэрбум төгрөг .....	25
Хүснэгт № 7. Олон улсын дундаж татварын хувь хэмжээ.....	26
Хүснэгт № 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ, тэрбум төгрөг.....	31
Хүснэгт № 9. Ковид-19 халдварыг эмчлэх тусламж үйлчилгээний тариф (мянган төгрөг) .....	33
Хүснэгт № 10. Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд дэх жендэрийн харьцуулалт (2020 оноор, хувиар) .....	42
Хүснэгт № 11. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум төгрөг/ .....	43
Хүснэгт № 12. Нийгмийн халамжийн сангийн зарлага /тэрбум төгрөг/ .....	43
Хүснэгт № 13. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/.....	44
Хүснэгт № 14. Улсын төсвийн татаас /тэрбум төгрөг/ .....	45
Хүснэгт № 15. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мянган хүн, тэрбум төгрөг/ .....	45
Хүснэгт № 16. Төсвийн хөрөнгө оруулалт 2017-2021 онуудад, тэрбум төгрөг .....	47
Хүснэгт № 17. Гадаадын зээл, тусламжийн 2022 оны төлөвлөгөө /хөгжлийн түншээр/, тэрбум төгрөг.....	53
Хүснэгт № 18. Ирээдүйн өв сангийн орлого, тэрбум төгрөг.....	59
Хүснэгт № 19. Засгийн газрын өрийн бүтэц, тэрбум төгрөг.....	60
Хүснэгт № 20. Засгийн газраас ЖДҮДС, ХААДС-д зээлийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн мэдээлэл (2021.06.30-ны байдлаар), тэрбум төгрөг .....	63



## ДАГАЛДАХ ХУУЛИУД

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Гаалийн тухай хуулийн 269<sup>1</sup> дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 269<sup>1</sup>.1.11 дэх заалт нэмсүгэй:

“269<sup>1</sup>.1.11.улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх.”

**2 дугаар зүйл.**Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“60.3.4.хуульд заасан бичиг баримт;”

**3 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Гаалийн болон холбогдох бусад хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Засгийн газар ирэх оны төсвийн жилд гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортыг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын гадаад худалдаа эрхлэгчдээс шаарддаг баримт бичиг, биет үзлэг, шалгалтын тоог бууруулах зорилгоор гаалийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Ингэснээр, улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад олгож, холбогдох хуульд заасан хилийн мэргэжлийн хяналтын албаны ажил үүргийг тус байгууллагад шилжүүлэх зохицуулалт хийнэ. Үүнтэй холбогдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ургамал хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Органик хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Эдгээр хуулийн төсөл батлагдсанаар гадаад худалдаа эрхлэгчийн гаалийн болон мэргэжлийн хяналтын байгууллагад бүрдүүлэн өгөх бичиг баримтын тоо буурч, тэдний улсын хилээр нэвтрүүлэх бараа бүтээгдэхүүний үзлэг шалгалтыг нэг дор, түргэн шуурхай хийх боломж бүрдэнэ. Улмаар бараа бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрэхэд шаардагдах цаг, зардал буурч, бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг болно.

Монгол Улсын Засгийн газар



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалтын “байгаль орчин, хилийн” гэснийг “байгаль орчны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>5</sup> дугаар зүйлийн 5<sup>5.8</sup> дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 29.9-29.12 дахь хэсэг нэмсүгэй:

“29.9.Ашигт малтмал, газрын тос, бараа бүтээгдэхүүний экспорт, импорт, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хилийн боомтын хяналт, улс хоорондын тээврийн зохицуулалт, халдвар хамгаалал, аюулгүй байдлын чиглэлээр хууль сахиулах болон хилийн хяналтын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэг бүхий Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааг Засгийн газар байгуулна.

29.10.Энэ хуулийн 29.9-д заасан Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааны бүтэц, зохион байгуулалт, орон тооны дээд хязгаар, үйл ажиллагааны дүрмийг Засгийн газар батална.

29.11.Хилийн боомтын үндэсний зөвлөлийн санал болгосноор Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааны даргыг Засгийн газар томилж, чөлөөлнө.

29.12.Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаанаас хилийн боомтод төлөөлөгч томилон ажиллуулж болно.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсгийн “гааль, мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.16 дахь заалтын “мэргэжлийн хяналт,” гэснийг, 17 дугаар зүйлийн 17.3.1, 17.3.2 дахь заалтын “мэргэжлийн хяналтын,” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН  
ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг “гаалийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 дэх заалтын “импортлох,” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэсний дараа “, гаалийн байгууллага, гаалийн улсын байцаагч” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6, 17 дугаар зүйлийн 17.12 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг “гаалийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийн “хилийн мэргэжлийн хяналтын алба” гэснийг “гаалийн байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОРГАНИК ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Органик хүнсний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “Мэргэжлийн хяналтын байгууллага” гэснийг “Гаалийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН  
ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “байгууллага” гэсний дараа “, гаалийн байгууллага” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хувиргасан амьд организмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “улсын байцаагч” гэснийг “гаалийн байгууллага” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Хувиргасан амьд организмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн гарчгийн “мэргэжлийн” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10, 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэг:

“6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйл, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 5.15, 6.1, 6.2 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.3, 2.4, 2.5 дахь заалт, 3, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 11, 12, 13, 14, 15, 16 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11, 6.12 дугаар зүйл, 6.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 6.19 дүгээр зүйл, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 6.24 дүгээр зүйл, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 8.1, 8.2, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 9.12, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.12, 10.13, 10.14, 10.15, 10.16, 10.17, 10.19, 10.22, 10.24, 10.25, 10.27, 11.2 дугаар зүйл, 11.25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.11, 12.12, 13.1, 13.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 13.5, 13.7, 13.9, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;”

2/ 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэг:

“6.11.гаалийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 7, 9, 10 дахь хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 5.12 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, 4 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 27 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалт, 6.4 дүгээр зүйлийн 1.1, 2.8 дахь заалт, 6.5 дугаар зүйлийн 9,10 дахь хэсэг, 6.6

дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.2 дахь заалт, 6.7 дугаар зүйлийн 9.3 дахь заалт, 6.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 1, 6 дахь хэсэг, 6.15 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 6.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6.17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.23 дугаар зүйл, 6.25 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 7.3 дугаар зүйл, 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9.7 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, 10.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 10.24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 11.21 дүгээр зүйл, 11.22 дугаар зүйл, 11.24 дүгээр зүйлийн 1.1, 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 11.29 дүгээр зүйлийн 22 дахь хэсэг, 13.2 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 13.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 15.2 дугаар зүйл, 16.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчил;”

**2 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг:

“2.1. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гаалийн тухай хууль, Малын генетик нөөцийн тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

2/6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг:

“6.2. Энэ хуулийн 6.1-д заасан хорио цээрийн хяналт, шалгалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хорио цээрийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.”

3/27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг:

“27.1. Эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг гаалийн байгууллага олон улсын стандарт, удирдамж, зөвлөмжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “хилийн боомт, гүний гаалийн дэргэдэх мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн гарчиг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, 12.2, 12.4 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, 23.3 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.5 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын” гэснийг “гаалийн” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “улсын мэргэжлийн хяналтын төв”

гэснийг “гаалийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.3.1 дэх заалтын “мэргэжлийн хяналтын” гэснийг “улсын” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна” гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 14.2 дахь хэсэг нэмсүгэй:

“14.2.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлэх цөмийн материал, цацрагийн үүсгүүр бүхий багаж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлд холбогдох байгууллагатай хамтран хяналт тавьж, хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авна.”

**2 дугаар зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 11<sup>1</sup> дүгээр зүйлийн 11<sup>1</sup>.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай 7.1.8 дахь заалт нэмсүгэй:

“7.1.8.Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өөрийн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан импортолсон энэ хуулийн 4.1.5-д заасан бараа.”

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТЫГ  
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.12 дахь хэсэг, 13.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Нийгмийн халамжийн тухай хуулийн  
зарим хэсэг, заалтыг хүчингүй  
болсонд тооцох тухай*

Монгол Улс “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд мөнгөн тэтгэмжийг Нийгмийн халамжийн хуульд заасны дагуу олгож байна. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ, давтамжийг 2006, 2007, 2009, 2012 онуудад тухай бүр өөрчилсөн бол Коронавируст цар тахлын үед хүүхэд багачуудыг хүнс, тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, теле-хичээл, цахим сургалтад хамрагдах боломжоор хангах зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхэд бүрд сар бүр 100.0 мянган төгрөгийг олгож байна.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд “нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ” гэж, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “АЛСЫН ХАРАА-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасны дагуу улс орны ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлал үүсгэж, хуримтлалын ач тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай, мэдлэгтэй иргэн болж төлөвшүүлэх асуудлыг төрийн бодлогоор дэмжих нь чухал юм.

Иймд хүүхдийн мөнгөн тэтгэмжийг “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөрт шилжүүлж халамжийн тогтолцооноос тусгаарлах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.12 дахь хэсэг, 13.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулав.

Монгол Улсын Засгийн газар

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурсан агуулгатай 10.5 дахь хэсэг нэмсүгэй:

“10.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, үйлчилгээний зардлын норматив, санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран тус тус батална.”

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Хүүхэд хамгааллын тухай  
хуульд нэмэлт оруулах тухай*

Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр зарцуулсан хөрөнгө 2017 онд 900.1 сая төгрөг байсан бол 2018 онд 6.4 тэрбум төгрөг, 2019 онд 7.6 тэрбум төгрөг, 2020 онд 8.0 тэрбум төгрөгт хүрч даруй 8.8 дахин нэмэгдсэн байна.

Хэдийгээр хүүхэд хамгааллын төсөв нэмэгдсэн боловч хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээг иж бүрэн, тасралтгүй, тогтвортой хүргэх, хамгааллын үйлчилгээний үе шат, кейс менежментийг бүтэн зургаар нь төлөвлөж, хэрэгжүүлэх, хянах, санхүүжүүлэх асуудлыг хэрхэн зохицуулахыг хуульчилж өгөөгүйгээс хуваарилсан санхүүжилт үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулагдаж байна.

Иймд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх зураглал, жишиг тарифыг нарийвчлан тооцож санхүүжилтийг 2022 оноос оновчтой хуваарилах зорилгоор холбогдох зохицуулалтыг багтаасан журмуудыг хүүхэд хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлах шаардлагатай байгаа тул Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулав. Хуулийн төсөл батлагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч санхүүжилтийн үр ашиг, үр дүн дээшлэх болно.

Монгол Улсын Засгийн газар

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 57.14 дэх хэсэг нэмсүгэй:

“57.14.Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

**2 дугаар зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5.6 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Төрийн албаны тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг 2021 онд эхлүүлсэн бол 2022 оноос боловсрол, соёл урлаг, нийтийн биеийн тамирын байгууллагыг санхүүгийн хувьд хагас бие даалгаж, үр дүн, чанар, бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

Эдгээр салбарт хийгдэх санхүүжилтийн шинэчлэлийн онцлог нь нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг байгууллагад хуваарилагдсан төсвийг үр ашигтай зарцуулах удирдлагын бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрснөөр эдэлж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах асуудлыг шийдвэрлэх үүргийг хүлээдэг явдал юм.

Төрийн албаны тухай хуулийн 57.5-д төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн хэмжээ, сүлжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно гэж заасан. Хуулийн энэхүү заалтын дагуу Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор бүх салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалинг хатуу тогтоож өгсөн.

Ийнхүү төрийн үйлчилгээний албан хаагчийн цалинг хатуу тогтоосноор тэдэнд гүйцэтгэлийн үр дүнгээр нь тооцож үндсэн цалинг нь нэмэгдүүлэх асуудал хязгаарлагдаж байгаа тул Төрийн албаны хуулиар эдгээр албан хаагчдын цалингийн доод хэмжээ, сүлжээг батлах эрхийг Засгийн газарт өгөх зохицуулалт хийх замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн хувьд хагас бие даасан зарчмаар ажиллах төрийн үйлчилгээний байгууллагын ажилтнууд болон төрийн үйлчилгээний бусад салбарын ажилтнууд хийсэн ажлынхаа үр дүнгээр үндсэн цалингаа нэмэгдүүлэх боломжтой болно.

Монгол Улсын Засгийн газар

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “тухайн” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Газрын тосны тухай хуульд  
өөрчлөлт оруулах тухай*

Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 хэсэгт заасан “тухайн орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэсэн тодорхойлолт нь Төсвийн тухай хуульд байхгүй бөгөөд Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28 дахь заалтад “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг” ойлгоно гэж тодорхойлсон.

Харин Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-т “Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна.” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”, “орон нутгийн хөгжлийн сан” нь хоорондоо ялгаатай тусдаа ойлголтууд юм.

Иймд Газрын тосны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 хэсгийг өөрчлөн “тухайн” гэсэн хэсгийг хасах нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол Улсын Засгийн газар



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:

“9.4.Энэ хуулийн 9.1.3-т заасан төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлого нь Монгол Улсын Засгийн газраас батлагдсан хөтөлбөр арга хэмжээ байна.”

2/9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт:

“9.1.3.Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд банк санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах.”

**2 дугаар зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “дутагдалтай” гэсний дараа “иргэн, хуулийн этгээд,” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.1.Энэ хуулийн зорилт нь иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”

**4 дүгээр зүйл.**Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “9.1.1-д” гэснийг “9.1-д” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Зээлийн батлан даалтын сангийн тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.3-т “Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ” гэж заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10.0 (арван) их наядын цогц төлөвлөгөө”-ний 2.3 дахь хэсэгт иргэдийг орон сууцжуулах арга хэмжээний хүрээнд ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийн эх үүсвэрийг мөнгөний бодлогын зорилтод нийцүүлэн нэмэгдүүлж, барилгын салбар, түүний дагалдах салбарыг идэвхжүүлэхэд чиглүүлэх талаар Төв банктэй хамтран ажиллах, 2.1 дэх хэсэгт “Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 2.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкнуудын чөлөөт эх үүсвэрээр олгох”-оор тус тус заасан.

Дээрх төлөвлөгөө батлахтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн санхүүгийн чадавхыг сайжруулж, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн байх тул Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлж зорилгоор Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Засгийн газар.” гэснийг “энэ хуулийн 18.1-д заасан давхар даатгалын компани.” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.7 дахь заалтын “эсэх асуудлаар” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 онд батлагдаж, Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоолоор байгалийн болзошгүй болон гэнэтийн эрсдэлээс малчид, тариаланчдыг хамгаалах зорилгоор олон улсын жишигт нийцсэн давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, дотоодын даатгалын компаниудыг давхар даатган ажиллах зорилго бүхий “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг байгуулсан.

Улмаар, гадаад валютын гадагшлах урсгалыг бууруулах, давхар даатгалын зардлыг багасгах зорилгоор Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 303 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг “Үндэсний давхар даатгал” ХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөсөн болно.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газар давхар даатгалын компанийг үүсгэн байгуулагчийнхаа хувьд төрөөс оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө болон даатгалын хохирлыг нөхөн төлөхөд зориулсан Алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн, уг хуульд Даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор тогтоосон эрсдэлийн дунд түвшин буюу даатгагчийн эрсдэл хүлээх түвшнээс давсан, эрсдэлийн дээд түвшин дэх давхар даатгалын хураамжийг мөн Засгийн газар хариуцахаар зохицуулсан байна. Энэ дагуу Засгийн газраас 2016-2020 онуудад 1.9 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд 2021 оны төсөвт 415.8 сая төгрөг батлагдсан байна.

Энэхүү зохицуулалт нь шинээр байгуулагдсан компанийг санхүүгийн хувьд тогтворжих хүртэл Засгийн газраас үзүүлж байсан дэмжлэг бөгөөд тус компанийн санхүүгийн тайлангаас харахад сүүлийн 4 жилд нийт 16.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Иймд даатгагчийн эрсдэл хүлээх түвшнээс давсан эрсдэлийн дээд түвшин дэх давхар даатгалын хураамжийг Давхар даатгалын компанид өөрт нь хариуцуулах зорилгоор Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын Засгийн газар

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны .... дугаар  
сарын ...- ны өдөр

Улаанбаатар  
хот

**ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Өрийн удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.9 дэх хэсэг нэмсүгэй:

“25.9.Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.”.

**2 дугаар зүйл.**2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Өрийн удирдлагын тухай хуульд  
нэмэлт оруулах тухай*

Монгол Улсын Засгийн газар 1991 оноос 2021 оны эхний хагас жилийн байдлаар олон улсын байгууллага, хөгжлийн түнш орнуудаас авч ашигласан гадаад зээлийн үлдэгдэл 5,738.6 сая ам.доллар буюу 16,394.8 тэрбум төгрөг байгаагаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар авч ашигласан гадаад зээлийн үлдэгдэл 62.3 хувь, хөтөлбөрийн зориулалтаар авч ашигласан гадаад зээлийн үлдэгдэл 37.7 хувийг тус тус эзэлж байна.

Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламж авахтай холбоотой харилцааг Хууль тогтоомжийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулдаг бөгөөд уг хуульд нийцүүлэн Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг батлан гадаад зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад мөрдлөг болгож байна.

Тус журмаар Монгол Улсын Засгийн газар улс орны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын хүрээнд Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зээлийн эх үүсвэр авах, тэдгээрийг төлөвлөх, хэрэгжүүлэн зохион байгуулах, санхүүжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх харилцааг зохицуулж байгаа боловч түнш орон, олон улсын байгууллагаас бусад эх үүсвэрээс Засгийн газрын гадаад зээл авах, хэлэлцээр байгуулахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын зүгээс гадаад улс, олон улсын байгууллагаас авах өрийн хэрэгсэл болон зээл тусламжийн хөрөнгийг авч ашиглах зориулалт нэмэгдээд байгаа бөгөөд дээр дурдсан хуулиудаар зохицуулсан харилцааг хэрхэн даган мөрдөх талаар процедурыг нарийвчлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй байгаагийн улмаас Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг сонгох шалгаруулахаас гэрээ, хэлэлцээр байгуулагдах хүртэл шатанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсөв болон өрийн хязгаарт нийцүүлэн төсөл, хөтөлбөрийг эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг харгалзан, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг тодорхойлох, тэдгээрийг дамжуулан зээлдүүлэх эсэх шийдвэр гаргах, тухайн төслийг хэрэгжүүлэх цаглабарыг Засгийн газраас батлагдсан өрийн удирдлагын стратегийн баримт бичигтэй нийцүүлэх замаар зээлийн хэмжээ, нөхцөлийг тодорхой болгох зэрэг асуудлууд практикт орхигдож байна.

Иймд энэ талаарх нарийвчилсан зохицуулалтуудыг одоогийн батлагдсан хууль эрх зүйн орчинд нийцүүлэн “Засгийн газрын гадаад зээл авах бэлтгэл ажлыг хангахад мөрдөх журам”-д тусгахаар Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг бэлтгэлээ.

Монгол Улсын Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 6 дахь заалтын “худалдан авах бодлого” гэсний дараа “концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 1 дэх заалтын “-төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа, концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



## ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны бодлогын асуудал нь Сангийн сайдын эрхлэх асуудалд хамаардаг боловч мөн зүйлийн 1 дэх заалтад төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны асуудлыг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудалд мөн адил хамааруулсан байдаг. Мөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт нь төсвийн хөрөнгийн гүйцэтгэлийн бүрэлдэхүүн хэсэг болох үүднээс худалдан авах ажиллагааны нэгдсэн бодлогыг цогц байдлаар хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байхаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Монгол Улсын Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар  
хот

### Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай

Өрийн удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2022 онд гадаад, дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Монгол Улсын Засгийн газар / Л.Оюун-Эрдэнэ/-т олгосугай.

2. Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

**ТАНИЛЦУУЛГА**

*Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

Өрийн удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12-т “Энэ хуулийн 7.1.2-т заасныг үндэслэн Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах, Засгийн газрын үнэт цаас гаргагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх” гэж, 26 дугаар зүйлийн 26.3-т “Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргахтай холбогдсон аливаа шийдвэрийн төслийг энэ хуулийн 8.2.4-т заасныг үндэслэн Засгийн газарт санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд Засгийн газар оруулна” гэж, 26 дугаар зүйлийн 26.5-д “Засгийн газрын тухайн төсвийн жилд арилжаалах дотоод үнэт цаасны хуваарийг зээллэгийн төлөвлөгөө болон стратегийн баримт бичигт нийцүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж тус тус заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг /Цаашид “стратегийн баримт бичиг” гэх/-ийн зорилтуудыг үндэслэн Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай УИХ-ын тогтоолын төслийг танилцуулгын хамт боловсрууллаа.

Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон стратегийн баримт бичгийн зорилтуудыг хангах хүрээнд Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргах аливаа шийдвэрийг Засгийн газрын 2022 оны Зээллэгийн төлөвлөгөөний дагуу арилжихаар тусгагдсан болно.

Өрийн удирдлагын тухай хуулийн 25.4-т заасан шаардлага болон 26.5-д заасан зохицуулалтын хүрээнд Засгийн газрын тухайн онд шинээр авах гадаад төсөл, хөтөлбөрийн зээл, шинээр гаргах гадаад, дотоод үнэт цаас зэрэг аливаа шинээр хийх зээллэг нь зээллэгийн төлөвлөгөөнд нийцсэн байхаар заасан. Засгийн газрын зээллэгийн төлөвлөгөө нь стратегийн баримт бичиг, тухайн жилийн Засгийн газрын нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээнд үндэслэн шинээр үүсгэх зээллэгийг өрийн хэрэгсэл тус бүрээр тодорхойлох баримт бичиг бөгөөд зээллэгийн төлөвлөгөөг Засгийн газраас батлан хэрэгжүүлдэг.

Ингэснээр Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд “Засгийн газрын нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээ 2022 оны төсвийн жилд 5,820,747.3 сая төгрөг байна” гэж, “Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон “Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т нийцүүлэн өрийн зохицуулалтын үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ” гэж тус тус заасантай Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас гаргах аливаа шийдвэр нийцсэн байна.

Монгол Улсын Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар  
хот

Төсөв батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээдүүд жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан цэвэр ашгийн 50 хувь болон төрийн эзэмшилд хамаарах эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг тооцон хуваарилж төсөвт төвлөрүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т чиглэл болгосугай.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

*Төсөв батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл*

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 74 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлд “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн засаглал, ногдол ашиг төвлөрүүлэх бодлогыг боловсронгуй болгож төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн талаарх эрх зүйн орчныг шинэчлэх хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаас өмнө өргөн мэдүүлэх”, 5.2.19-т “Төрийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэн, өмч хувьчлалыг үе шаттай, үр дүнтэй явуулна.” гэж тус тус заасныг үндэслэн Төсөв батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Төрийн өмчийн үр өгөөжийг дээшлүүлж төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, төрийн болон төрийн өмчийн оролцоотой дийлэнх хуулийн этгээдийн үйл ажиллагааны зорилго, чиглэл нь тодорхойгүй, тэдгээрийн үйл ажиллагааг хувийн хэвшил хийх боломжтой, холбогдох салбарын бодлогод ач холбогдолгүй бөгөөд санхүүгийн хувьд үр ашиггүй ажиллаж байна.

ЭЗХАХБ-ын “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн компанийн засаглалын зарчим”, Монголын компанийн засаглалын жишиг баримт бичигт төрийн өмчит хуулийн этгээд нь капиталын бүтцийн зохистой харьцаа, ногдол ашиг, хөрөнгийн өгөөжийн урт хугацааны бодлогыг тодорхойлж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг зөвлөдөг.

Иймд ногдол ашгийн бодлогын шинэчлэлийн хүрээнд олон улсын гэрээ болон тусгайлсан хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг, ашигтай ажиллах боломжгүй, үнэ тарифыг төрөөс зохицуулдаг төрийн өмчит хуулийн этгээдээс бусад этгээд нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу нэгдсэн зарчмаар ногдол ашиг хуваарилна.

Ингэхдээ төрийн өмчит хуулийн этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр ногдол ашиг хуваарилж төрд эзэмшлийн хувьцаанд хамаарах дүнгээр төсөвт ногдол ашиг төвлөрүүлнэ. Олон улсын жишигт нийцсэн ногдол ашгийн бодлого хэрэгжүүлснээр төрийн өмчит хуулийн этгээд зардлаа хэмнэх, санхүүгийн үр ашгаа нэмэгдүүлэх, оновчтой хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргах хөшүүрэг болж санхүүгийн сахилга бат сайжирна.

Монгол Улсын Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар ..

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд “4.Ойн судалгаа, хөгжлийн газар” гэж, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд “7.Төрийн худалдан авах ажиллагааны газар” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд “18.Боловсролын ерөнхий газар” гэж тус тус нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “2.Төрийн худалдан авах ажиллагааны газар” гэснийг хассугай.

3.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн 3, 4, гэсэн дугаарыг 2, 3 гэж, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24 гэсэн дугаарыг “8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26 гэж тус тус өөрчилсүгэй.

4.Энэ тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг



## ТАНИЛЦУУЛГА

*Тогтоолын хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл*

Боловсролын шинэчлэлийг ирэх онд хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Боловсролын ерөнхий газар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг, цөлжилтөөс сэргийлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг зохицуулалтаар хангах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын харьяа Ойн судалгаа, хөгжлийн төвийг өөрчлөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн судалгаа, хөгжлийн газар болгон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тус тус байгуулахаар тооцлоо.

Мөн төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн бодлогыг цогц байдлаар хэрэгжүүлж зохицуулалтыг сайжруулах зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны газар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийг Сангийн сайдын эрхлэх асуудлын харьяанд шилжүүлэхээр тогтоолын төсөлд тусгав.

Монгол Улсын Засгийн газар



### **3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**





## **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Засгийн газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2022 төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.  
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид зарцуулах төсвийн эрх хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацаа.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2022 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож

хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

--- оОо ---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

#### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>2,839,318.8</b>
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	1,100,468.4
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	1,027,678.7
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	107,036.7
	1.4 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	8,095.8
	1.5 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	130.4
	1.6 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	124,404.1
	1.7 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	2,794.9
	1.8 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	1,787.6

	1.9 Бусад орлого	7,069.7
	1.10 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	459,852.6
<b>2</b>	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>1,100.0</b>
	2.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	1,100.0
<b>Нийт орлого</b>		<b>2,840,418.8</b>

**4 дүгээр зүйл.** Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө:

<b>Д/д</b>	<b>Төсвийн ерөнхийлөн захирагч</b>	<b>Дүн</b> /сая төгрөгөөр/
1	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>98,100.0</b>

**5 дугаар зүйл.** 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсөв зарцуулна:

<b>Д/д</b>	<b>Зарлагын төрөл</b>	<b>Дүн</b> /сая төгрөгөөр/
1	<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд</b>	<b>2,750,964.7</b>
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	2,449,792.7
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	171,464.2
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	33,617.5
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	63,727.6
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	32,362.7
<b>Нийт зарлага</b>		<b>2,750,964.7</b>

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА



Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсөвт нийт орлогын хэмжээг 2,379.5 тэрбум төгрөг, нийт зарлагын хэмжээг 2,750.9 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Энэ нь 2021 онтой харьцуулахад орлого 575.7 тэрбум төгрөгөөр, зарлага 156.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

*Хүснэгт № 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/*

Үзүүлэлт	2021	2022 Төсөл
<b>ОРЛОГО</b>	<b>1,803.7</b>	<b>2,379.5</b>
1 Шимтгэлийн	1,800.2	2,372.4
2 Бусад орлого	3.5	7.1
<b>ЗАРЛАГА</b>	<b>2,594.3</b>	<b>2,750.9</b>
1. Тэтгэврийн	2,313.4	2,449.8
2. Тэтгэмжийн	160.2	171.5
3. ҮОМШӨ-ний	34.6	33.6
4. Ажилгүйдлийн	58.9	63.7
5. Бусад зарлага	-	-
6. Ажиллагааны зардал	27.1	32.4
<b>Капитал банкнаас авах авлага</b>	<b>-103.7</b>	<b>-98.1</b>
<b>Улсын төсвөөс олгох татаас</b>	<b>593.9</b>	<b>459.9</b>

### Нийгмийн даатгалын сангийн орлого



Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 2,379.5 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2021 онтой харьцуулахад 575.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Ирэх онд эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэх, дундаж цалин хөлс өсөх, орлогын боломжит бусад эх үүсвэр нэмэгдэх зэрэг төсөөлөлд үндэслэн тооцлоо.

Нийгмийн даатгалын санд 2021 оны эхний 6 сарын байдлаар 48.7 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 826.2 мянган даатгуулагч албан журмын даатгалд, 136.1 мянган даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдаад байна.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдлыг даван туулах, аж ахуйн нэгж, байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хугацааг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгасантай холбогдуулан 2021 оны эхний 5 сарын байдлаар 37.2 мянган ажил олгогч, 396.2 мянган албан журмын даатгуулагч 114.1 тэрбум төгрөгийн, 109.1 мянган сайн дурын даатгуулагч 10.9 тэрбум төгрөгийн, нийтдээ 125.0 тэрбум төгрөгийг шимтгэлээс чөлөөлөгдсөн байна.

Түүнчлэн Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагаж мөрдөх хугацааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл сунгасан бөгөөд хуулийг хэрэгжүүлэх хугацаанд нийт 18.5 мянган иргэн хамрагдан тэтгэврийн даатгалын санд 36.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс 8.3 мянган хүн тэтгэвэр тогтоолгон, тэтгэвэрт нь 15.9 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэрийг ангилж үзвэл:

1/ Нийгмийн даатгалын санд 2022 онд төвлөрөх шимтгэлийн орлогыг 2,372.4 тэрбум төгрөг, бусад орлого 7.1 тэрбум байхаар тооцлоо.

2/ Цэргийн алба хаасны тэтгэвэр, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийн зардлыг хуульд заасны дагуу улсын төсвөөс олгох татааст нийт 459.9 тэрбум төгрөгөөр тооцлоо.

### Нийгмийн даатгалын сангийн зарлага


Нийгмийн даатгалын сангийн нийт зардал 2,750.9 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн 2021 онтой харьцуулахад 156.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

### Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 2,474.7 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,960.2 тэрбум төгрөгөөр тооцлоо. Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 76.0 хувийг өндөр насны тэтгэвэр, 12.0 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 8.0 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2022 онд нийт 472.6 мянган хүний тэтгэвэрт 2,448.7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2021 онтой харьцуулахад 136.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

График № 1. Нийгмийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2022 онд тэтгэврийн насанд хүрч шинээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрэгтэй 13.1 мянга, эмэгтэй 50/55 насны 20.9/18.0 мянга, нийтдээ 52.2 мянган хүн байгаа бол тэтгэвэр нь зогсох 27.0 мянга хүн байна. Тэтгэвэр

авагчдын тооны цэвэр өсөлтийг 20.9 мянган хүн байхаар тооцлоо.

Ирэх онд нийт өндөр насны тэтгэвэр авах хүний тоо 359.9 мянган хүн, зарцуулах хөрөнгө 1,879.6 тэрбум төгрөг, тахир дутуугийн тэтгэвэрт нийт 74.5 мянган хүн зарцуулах хөрөнгө 297.9 тэрбум төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт нийт 18.1 мянган хүн зарцуулах хөрөнгө 82.9 тэрбум төгрөг, улсын төсвөөс тэтгэврийн зардлыг нь хариуцдаг 1/ цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах хүний тоо 2022 онд нийт 20.1 мянга; 2/ 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нийт 48.1 мянган иргэн тус тус тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаар байна. Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаас 459.9 тэрбум төгрөг байна. Үүнээс: цэргийн тэтгэвэрт 188.4 тэрбум төгрөг, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 246.4 тэрбум төгрөг тус тус олгохоор төсөвлөлөө.

Хүснэгт № 2. Улсын төсвийн татаас /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2019	2020	2021	2022
Улсын төсвийн татаас	601.6	399.4	593.9	459.9
Үүнээс:				
Цэргийн тэтгэвэр	130.5	155.9	173.3	188.4
1995 оноос өмнөх	235.6	211.7	253.9	246.4
НДС-н алдагдал	235.5	31.8	166.7	25.1

### Тэтгэмжийн даатгалын сан



Тэтгэмжийн даатгалын сангийн орлого 2022 онд 198.9 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 174.8 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар тооцлоо

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний

зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

*Хүснэгт № 3. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мянган хүн, тэрбум төгрөг/*

Тэтгэмж	2021		2022		Өөрчлөлт	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
ХЧТА	116.0	26.4	118.3	28.3	2.3	1.9
Ж.А	64.6	109.9	67.2	117.8	2.6	7.9
Оршуул-гын	16.4	16.4	17.2	17.2	0.8	0.8
<b>Нийт</b>	<b>197.0</b>	<b>152.7</b>	<b>202.7</b>	<b>163.3</b>	<b>5.7</b>	<b>10.6</b>

### ҮОМШӨ-ий даатгалын сан



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд 2022 онд 178.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал, ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд нийт 37.0 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас тахир дутуу болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 5.0 мянган иргэнд нийт 29.9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.1 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 1.6 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

### Ажилгүйдлийн даатгалын сан



Ажилгүйдлийн даатгалын санд 2022 онд 42.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлагдаж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил

олгох давтан сургалтын зардалд 64.4 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо

Тус сангаас 2022 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 25.6 мянган иргэнд 63.6 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

### Нийгмийн даатгалын сангийн авлага

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкнаас авах 98.1 тэрбум төгрөгийн авлагыг тусгав.



## **4. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**





## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

#### Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.51 дэх заалтад “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв гэж Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтад “Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө” гэж тус тус заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

#### Практик шаардлага

Монгол Улсын Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, мөн оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна гэж заасан.

Энэхүү зорилтын хүрээнд эмнэлгийн хагас бие даасан байдлыг хангах, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжих, гүйцэтгэлд суурилсан санхүүжилт олгох эрүүл мэндийн даатгалын санд улсын төсвөөс хариуцах тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг тусгах асуудлыг 2021 оноос эхлэн хэрэгжүүлж эхлээд байна. Цаашид салбарын шинэчлэлийг үргэлжлүүлэн нэг худалдан авагчийн тогтолцоог

бэжжүүлэх, эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар, үр дүн, гүйцэтгэлээр санхүүжүүлэх шаардлага бий болоод байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.  
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт эрүүл мэндийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрх, хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2022 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт биелж, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр хууль, тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ**  
**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хууль тогтоомж**

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН**  
**ОРЛОГО, ЗАРЛАГА**

**3 дугаар зүйл.** Эрүүл мэндийн даатгалын санд 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ.

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>1,450,723.5</b>
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	1,450,723.5
	<b>Нийт орлого</b>	<b>1,450,723.5</b>

**4 дүгээр зүйл.** Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөр төлнө.

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>136,400.0</b>

**5 дугаар зүйл.** 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна.

<b>Д/д</b>	<b>Зарлагын төрөл</b>	<b>Дүн</b> /сая төгрөгөөр/
1	<b>Эрүүл мэндийн сайд</b>	<b>1,481,369.2</b>
	1.1 Эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилт	1,358,353.9
	1.2 Эмийн санд олгох	67,306.2
	1.3 Үйл ажиллагааны урсгал зардал	14,129.1
	1.4 Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.0
	1.5 Бусад	480.0
	1.6 Эрсдлийн сан	40,000.0
	<b>Нийт зарлага</b>	<b>1,481,369.2</b>

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТАНИЛЦУУЛГА

### Сангийн орлого



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн орлогыг нийт 1,450.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд 2021 оноос нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж улсын төсвөөс эрүүл мэндийн даатгалын санд тусламж, үйлчилгээний санхүүжилтийг шилжүүлж байна. Үүний дагуу эрүүл мэндийн даатгалын сангийн орлогод улсын төсвийн шилжүүлэг, эрүүл мэндийн даатгалын сангийн шимтгэлийн орлого аж, ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллага болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогыг тус тус тусгав.

### Сангийн зарлага




Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг 2020 оноос эхлүүлж эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлж байна.

Шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилт, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нэг иргэний тарифаар тооцох зардлыг тусгав. Бүх шатны эмнэлгийн иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, гүйцэтгэлээр олгох санхүүжилтэд нийт 1,358.4 тэрбум төгрөг төсөвлөв.


Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.9, 15.1.11, 15.1.13-д тус тус заасан эрүүл мэндийн байгууллагын эмчийн бичсэн жороор хөнгөлөлттэй олгох эмийн нэр төрөл, жагсаалтын дагуу олгох эмийн үнийн хөнгөлөлтийн зардалд 67.3 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн сангийн хөрөнгийг 40.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов.

### Эрүүл мэндийн даатгалын сангийн авлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн Капитал банкнаас авах авлагыг барагдуулахаар тооцож тусгав.



**5.ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**



## ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

#### Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.3.7 дахь заалтад “Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.12 дахь заалтад “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн мөнгийг тэдний хүнс, тэжээлийн хэрэгцээ, бие бялдар, хувь хүний хөгжил, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдийн хуримтлал бий болгоход зарцуулах тогтолцоог бүрдүүлнэ” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5 дахь заалтад “хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг тодорхойлох” гэж тус тус заасан нь Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

#### Практик шаардлага

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргадаг “Өрхийн хадгаламжийн судалгаа”-аас үзэхэд эдийн засгийн хөгжил, тогтвортой байдлаараа дэлхийд тэргүүлдэг Швейцар, Швед, Герман зэрэг орнуудын иргэд нь орлогынхоо тодорхой хувийг жил бүр хуримтлуулдаг байна. Эдгээр орнуудын хөгжлийн замналд иргэдийн хуримтлал нэн чухал байсан ба хуримтлалын ач холбогдол, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас бий болгожээ.

Манай улсын хувьд “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг 1995 оноос зөвхөн амьжиргааны түвшнээс доогуур, зорилтот бүлэгт чиглүүлж хүүхдийн тэтгэмж олгож байсан бол 2006 оноос 0-18 хүртэлх насны бүх хүүхдэд сар бүр 3.0 мянган төгрөгийн халамжийг олгож эхэлсэн. Тэтгэмжийн хэмжээг 2007 оноос жилд нэг удаа 100.0

мянган төгрөг, 2009 оноос сар бүр 21.0 мянган төгрөг, 2012 оноос сар бүр 20.0 мянган төгрөг болгон шинэчлэн тогтоож байсан.

Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед Засгийн газраас иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, амьжиргаа, орлогыг дэмжих чиглэлээр холбогдох арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Тухайлбал, цар тахлын үед хүүхэд багачуудыг хүнс, тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, теле-хичээл, цахим сургалтад хамрагдах боломжоор хангах зорилгоор мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж, 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт сар бүр 100.0 мянган төгрөгийг олгож байна.

Хэдийгээр цар тахлын үед дээрх арга хэмжээ нь цагаа олсон, хүртээмж, үр дүн өндөртэй байгаа боловч урт, дунд хугацаанд бэлэн мөнгө тараах халамжийн бодлогоос үе шаттайгаар татгалзаж, хүүхдийн хуримтлалын тогтолцоонд шилжих шаардлагатай байна. Ингэснээр, ирээдүй хойч үедээ хуримтлал үүсгэх, хүүхэд бүр санхүүгийн мэдлэгт суралцаж, зөв төлөвших, 18 нас хүрээд өөрийн хуримтлалаар боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой.

Иймд улс орны ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач тусыг ойлгуулах, хуримтлалтай, санхүүгийн баталгаатай, мэдлэгтэй иргэн болж төлөвшүүлэх төрийн бодлогын хүрээнд нийгмийн халамжийн тогтолцооноос татгалзаж байгалийн баялгийн өгөөжид суурилсан хуримтлалын тогтолцоо буюу “Хуримтлалтай монгол хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төсөл нь 2 бүлэг, 5 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Ирээдүйн өв сангийн төсөвт 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлогын хэмжээ, Ирээдүйн өв сангийн төсвөөс 2022 оны төсвийн жилд хүүхдийн хуримтлалд зориулан зарцуулах зарлагын хэмжээ, хуулийг дагаж мөрдөх хугацаа.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэрэгжиж, хүүхэд бүрт зориулсан хадгаламжийн нэрийн дансыг банкны системд нөлөө бүхий арилжааны банкуудад нээж хүүхдийн хуримтлал үүсэх эрх зүйн орчин бүрэлдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг**



**хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

--- оОо ---

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

**ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ****НЭГДҮГЭЭР БҮЛЭГ****НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь Ирээдүйн өв санд 2022 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн хууль тогтоомж**

2.1. Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ****ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

**3 дугаар зүйл.** Ирээдүйн өв санд 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлого төвлөрүүлнэ.

<b>Д/д</b>	<b>Орлогын төрөл</b>	<b>Дүн /сая төгрөгөөр/</b>
<b>1</b>	<b>Монгол Улсын Ерөнхий сайд</b>	<b>404,530.8</b>
	1.1 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	<b>404,530.8</b>
	1.1.1 Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг	404,530.8
<b>2</b>	<b>Сангийн сайд</b>	<b>1,057,206.9</b>
	2.1 Татварын ерөнхий газар	<b>1,057,206.9</b>

2.1.1 Ашигт малтмалын тухай хуульд заасан үүсмэл ордоос бусад орд ашигласнаас төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь	1,057,206.9
<b>Нийт орлого</b>	<b>1,461,737.7</b>

**4 дүгээр зүйл.** 2022 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	<b>Сангийн сайд</b>	<b>1,461,737.7</b>
	1.1 Хүүхдийн мөнгөн хуримтлал:	1,461,737.7
	Үүнээс: Хүсэлт гаргасны дагуу мөнгөн хэлбэрээр олгох дээд хэмжээ	1,096,303.3
	Нэрийн дансанд хуримтлуулах доод хэмжээ	365,434.4
	<b>Нийт зарлага</b>	<b>1,461,737.7</b>

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ гэж, “Алсын хараа-2050” болон Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход шаардагдах тогтолцоог бүрдүүлнэ гэж тус тус заасан билээ.

Байгалийн баялгаас орох орлогын хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол улсын ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай, мэдлэг боловсролтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тус сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг арилжааны банкн дахь хүүхдийн нэрийн дансанд хуримтлуулахаар төлөвлөлөө.

Ингэснээр Монгол Улсын хүүхэд бүр Ирээдүйн өв сангаар баталгаажсан, Хадгаламжийн даатгалын сангаар даатгуулсан, хамгийн эрсдэл багатай системийн нөлөө бүхий банкуудад нэрийн дансны хуримтлалтай болж, хадгалах, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас суралцахаас гадна 18 нас хүрээд нэрийн дансны хуримтлалаар өөрийн боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Ковид-19 цар тахлын нөлөө бүрэн арилаагүй шилжилтийн хугацаанд бага дунд орлоготой өрхүүд орлогын эрсдэлд орж болзошгүй тул хуримтлалд бүрэн шилжих бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хадгаламж нээлгэсэн хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч хэрвээ хүсвэл хүүхдийн нэрийн дансанд сар бүр төвлөрөх мөнгөн хадгаламжийн тодорхой хувийг бэлнээр авах боломж олгож байна. Тодруулбал, 2022 оны төсвийн жилд, 1 дүгээр сарын 1-ээс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд сар бүрийн хуримтлалыг 100,000 төгрөг хүртэл сонголтоор, харин 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 50,000 төгрөгөөс доошгүй хэсгийг хуримтлуулж үлдсэн 50,000 төгрөгийг бэлнээр буюу хүүхэд бүрд нийт 100,000 төгрөг гэсэн зарчмыг хадгална.

Ирэх 2022 онд дэлхийн зах зээл дахь экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн таамаглал, экспортын биет хэмжээний төсөөлөл зэрэгтэй уялдуулан Ирээдүйн өв санд нийт 1,461.7 тэрбум төгрөг төвлөрөхөөр байгаа бөгөөд тус сангаас хүүхдийн мөнгөн хадгаламжид зориулан мөн хэмжээний дүнг Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкин дахь хүүхдийн нэрийн дансанд шилжүүлнэ. Үүнээс хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гаргасан хүсэлтийн дагуу мөнгөн хэлбэрээр олгох дээд хэмжээг 1,096.3 тэрбум төгрөг, хүүхдийн нэрийн дансанд хуримтлагдах доод хэмжээг 365.4 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.



## ДАГАЛДАХ ХУУЛИУД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

### ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ирээдүйн өв сангийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 9<sup>1</sup>, 9<sup>2</sup> дугаар зүйл нэмсүгэй:

1/9<sup>1</sup> дүгээр зүйл:

“9<sup>1</sup> дүгээр зүйл. Хүүхдийн мөнгөн хадгаламж

9<sup>1.1</sup>. Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрт мөнгөн хуримтлал үүсгэх зорилгоор шаардагдах хөрөнгийг энэ хуулийн 7.1-д заасан тухайн жилийн эх үүсвэрээс Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкин дахь хүүхдийн нэрийн дансанд шилжүүлнэ.

9<sup>1.2</sup>. Энэ хуулийн 9<sup>1.1</sup>-д заасан сар бүр хүүхдийн мөнгөн хадгаламжид байршуулах хөрөнгийн хэмжээг Ирээдүйн өв сангийн тухайн жилийн төсвийн тухай хуулиар батална.

9<sup>1.3</sup>. Ирээдүйн өв сангийн батлагдсан төсвийн дагуу банканд хүүхдийн мөнгөн хадгаламж байршуулах, санхүүжүүлэх, нэрийн данс нээх, хадгаламжийн нөхцөлтэй холбоотой журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар батална.

9<sup>1.4</sup>. Энэ хуулийн 9<sup>1.1</sup>-д зааснаар хадгаламж байршуулахдаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч холбогдох банктай гэрээ байгуулах ба гэрээнд хүүхдийн хадгаламжийг ашиглан гуравдагч этгээдийн өмнө аливаа санхүүгийн үүрэг хүлээх нөхцөл бүхий гэрээ, хэлцэл хийхгүй байх, хадгаламжаас энэ хуулийн 9<sup>2</sup>-т зааснаас бусад тохиолдолд зарцуулалт хийхийг хориглох асуудлыг тусгана.

2/9<sup>2</sup> дугаар зүйл:

“9<sup>2</sup>. Хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсвэл сард нэг удаа хүсэлт гаргаж энэ хуулийн 9<sup>1.1</sup>-д заасан мөнгөн хадгаламжаас тухайн сард хадгаламжид хуваарилсан дүнг дор дурдсан хугацаанд дараах хувиар тооцож мөнгөн хэлбэрээр авах эрхтэй:

№	Хамрах хугацаа	Мөнгөн хэлбэрээр олгох хувь
1	2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл	100 хувь
2	2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал	50 хувь
3	2023 онд	40 хувь
4	2024 оноос хойш	30 хувь

**2 дугаар зүйл.** Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.3. Сангийн данснаас санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 7.1-д заасан орлогын эх үүсвэрийн тухайн жилийн гүйцэтгэлээс энэ хуулийн 9<sup>1</sup>.1-д заасан мөнгөн хуримтлал үүсгэхэд шаардагдах хөрөнгийг холбогдох банканд, үлдэх хэсгийг Корпорацын Монголбанкин дахь дансанд тус тус шилжүүлнэ.”

**3 дугаар зүйл.** Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “жил бүрийн улсын төсөвт тусгаж” гэснийг “жил бүр” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “энэ хуулийн 9.1-д” гэснийг “энэ хуулийн 9.1, 9<sup>1</sup>-д” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “улсын” гэснийг “нэгдсэн” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар хот

### **ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2022 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1-д заасан эх үүсвэрээс Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрт мөнгөн хуримтлал үүсгэх зорилгоор Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан банкин дахь хүүхдийн нэрийн дансанд сар бүр 100,000 /нэг зуун мянга/ төгрөг байршуулна.

**2 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө арилжааны банканд байршуулсан хүүхдийн нэрийн данс дахь хадгаламжийг захиран зарцуулах эрхэд аливаа хязгаарлалт тогтоохгүй.

**3 дугаар зүйл.** 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



## ТАНИЛЦУУЛГА

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төвлөрүүлсэн орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлнэ гэж заасан болно. Түүнчлэн, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “АЛСЫН ХАРАА-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход шаардагдах тогтолцоог бүрдүүлнэ гэжээ.

Түүнчлэн, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргадаг судалгаанаас үзэхэд эдийн засгийн хөгжил, тогтвортой байдлаараа дэлхийд тэргүүлдэг Швейцар, Швед, Герман зэрэг орнуудын иргэд нь орлогынхоо тодорхой хувийг жил бүр хуримтлуулдаг байна. Эдгээр орнуудын хөгжлийн замналд иргэдийн хуримтлал нэн чухал байсан ба хуримтлалын ач холбогдол, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас бий болгосон байна.

Манай улсын хувьд төрөөс хүүхдэд мөнгөн тэтгэмж олгож хэвшсэн бөгөөд тэтгэмжийн хэмжээ, давтамж зэргийг 2006, 2007, 2009, 2012 онуудад тухай бүр өөрчилсөн бол Коронавируст цар тахлын үед хүүхэд багачуудыг хүнс, тэжээлийн дутагдалд орохоос урьдчилан сэргийлэх, теле-хичээл, цахим сургалтад хамрагдах боломжоор хангах зорилгоор 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүүхэд бүрт сар бүр 100.0 мянган төгрөгийг олгож байна.

Хэдийгээр цар тахлын үед дээрх арга хэмжээ нь цагаа олсон, хүртээмж, үр дүн өндөртэй байгаа боловч урт, дунд хугацаанд бэлэн мөнгө тараах халамжийн бодлогоос үе шаттайгаар татгалзаж, хүүхдийн хуримтлалын тогтолцоонд шилжих шаардлагатай байна.



Энэ хүрээнд Байгалийн баялгаас орох орлогын хүртээмжийг нэмэгдүүлэх, Монгол улсын ирээдүй болсон хүүхдүүддээ хуримтлалын ач тусыг ойлгуулж, санхүүгийн баталгаатай, мэдлэг боловсролтой иргэн болж төлөвшүүлэх зорилгоор Ирээдүйн өв санг Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүнд оруулж тус сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг арилжааны банкна дахь хүүхдийн нэрийн дансанд хуримтлуулахаар төлөвлөлөө. Ингэснээр Монгол Улсын хүүхэд бүр Ирээдүйн өв сангаар баталгаажсан, Хадгаламжийн даатгалын сангаар даатгуулсан, хамгийн эрсдэл багатай системийн нөлөө бүхий банкуудад нэрийн дансны хуримтлалтай болж, хадгалах, хуримтлуулах дадал зуршлыг хүүхэд наснаас суралцахаас гадна 18 нас

хүрээд нэрийн дансны хуримтлалаар өөрийн боловсролдоо хөрөнгө оруулалт хийх боломжтой болно.

Ковид-19 цар тахлын нөлөө бүрэн арилаагүй шилжилтийн хугацаанд бага дунд орлоготой өрхүүд орлогын эрсдэлд орж болзошгүй тул хуримтлалд бүрэн шилжих бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хадгаламж нээлгэсэн хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч хэрвээ хүсвэл хүүхдийн нэрийн дансанд сар бүр төвлөрөх мөнгөн хадгаламжийн тодорхой хувийг бэлнээр авах боломж олгож байна. Тодруулбал, 2022 оны төсвийн жилд, 1 дүгээр сарын 1-ээс 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд сар бүрийн хуримтлалыг 100,000 төгрөг хүртэл сонголтоор, харин 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 50,000 төгрөгөөс доошгүй хэсгийг хуримтлуулж үлдсэн 50,000 төгрөгийг бэлнээр буюу хүүхэд бүрд нийт 100,000 төгрөг гэсэн зарчмыг хадгална.

Харин 2023 онд хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагчийн гаргасан хүсэлтийн дагуу хүүхдийн нэрийн дансанд сар бүр төвлөрөх мөнгөн хадгаламжийн 40 хувийг, 2024 оноос хойш 30 хувийг тус тус олгохоор хуулийн төсөлд тусгалаа.

--- оОо ---



## **6.ТООЦООЛЛЫН ХАВСРАЛТУУД**

/сая төгрөг/

	2022 төсөл							
	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ			Орон нутаг	НДС	ЭМДС	Ирээдүйн өв сан
		НИЙТ	Төсвөөс санхүүжих	Гадаад зээл, тусламжаас санхүүжих				
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>16,415,107.0</b>	<b>10,049,997.7</b>	<b>9,751,478.3</b>	<b>298,519.4</b>	<b>2,968,968.7</b>	<b>2,840,418.8</b>	<b>1,450,723.5</b>	<b>1,461,737.7</b>
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	<b>643,389.3</b>	<b>643,389.3</b>	<b>643,389.3</b>					
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>15,771,717.7</b>	<b>9,406,608.4</b>	<b>9,108,089.0</b>	<b>298,519.4</b>	<b>2,968,968.7</b>	<b>2,840,418.8</b>	<b>1,450,723.5</b>	<b>1,461,737.7</b>
<b>1. Татварын орлого</b>	<b>13,941,329.3</b>	<b>7,612,407.3</b>	<b>7,612,407.3</b>	<b>0.0</b>	<b>2,284,219.4</b>	<b>2,379,466.3</b>	<b>1,450,723.5</b>	<b>1,057,206.9</b>
1.1. Орлогын албан татвар	2,926,019.4	1,188,630.0	1,188,630.0	0.0	1,737,389.4	0.0	0.0	0.0
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	1,149,199.4	0.0	0.0	0.0	1,149,199.4	0.0	0.0	0.0
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	1,776,820.0	1,188,630.0	1,188,630.0	0.0	588,190.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын орлого	2,987,495.7	0.0	0.0	0.0	0.0	2,379,466.3	1,450,723.5	0.0
1.3. Хөрөнгийн албан татвар	213,444.0	0.0	0.0	0.0	213,444.0	0.0	0.0	0.0
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,441,800.0	3,441,800.0	3,441,800.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Онцгой албан татвар	1,132,200.0	1,132,200.0	1,132,200.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.6. Тусгай зориулалтын орлого	17,200.0	17,200.0	17,200.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	1,081,912.0	1,081,912.0	1,081,912.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	2,141,258.2	750,665.3	750,665.3	0.0	333,386.0	0.0	0.0	1,057,206.9
<b>2. Татварын бус орлого</b>	<b>1,830,388.4</b>	<b>1,794,201.2</b>	<b>1,495,681.8</b>	<b>298,519.4</b>	<b>684,749.3</b>	<b>460,952.6</b>	<b>0.0</b>	<b>404,530.8</b>
2.1. Нийтлэг татварын бус орлого	1,531,698.5	979,540.4	979,540.4	0.0	194,449.2	0.0	0.0	404,530.8
2.2. Хөрөнгийн орлого	170.5	0.0	0.0	0.0	170.5	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	298,519.4	298,519.4	0.0	298,519.4	0.0	0.0	0.0	0.0
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	516,141.4	516,141.4	0.0	490,129.6	460,952.6	0.0	0.0
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>18,158,797.2</b>	<b>12,086,996.3</b>	<b>10,404,476.9</b>	<b>1,682,519.4</b>	<b>2,968,968.7</b>	<b>2,652,864.7</b>	<b>1,344,969.2</b>	<b>1,461,737.7</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>13,307,315.0</b>	<b>8,362,173.1</b>	<b>8,125,653.7</b>	<b>236,519.4</b>	<b>1,607,809.8</b>	<b>2,750,964.7</b>	<b>1,481,369.2</b>	<b>1,461,737.7</b>
<b>1. Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>4,065,707.7</b>	<b>2,947,902.4</b>	<b>2,718,382.9</b>	<b>229,519.5</b>	<b>966,600.1</b>	<b>31,552.7</b>	<b>254,471.5</b>	<b>0.0</b>
1.1. Цалин, хөлс	1,467,833.7	1,278,792.2	1,278,792.2	0.0	165,132.6	19,104.3	4,804.6	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.0	110,969.9	110,969.9	0.0	20,866.4	2,318.0	664.8	0.0
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	2,597,874.0	1,558,140.4	1,328,620.9	229,519.5	780,601.1	10,130.5	249,002.1	0.0
<b>2. Зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>959,309.9</b>	<b>959,309.9</b>	<b>959,309.9</b>	<b>0.0</b>	<b>46,821.9</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>3. Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>8,282,297.4</b>	<b>4,454,960.7</b>	<b>4,447,960.8</b>	<b>6,999.9</b>	<b>594,387.7</b>	<b>2,719,411.9</b>	<b>1,226,897.7</b>	<b>1,461,737.7</b>
3.1. Татаас	528,956.2	866,254.3	866,254.3	0.0	55,248.3	0.0	67,306.2	0.0
3.2. Урсгал шилжүүлэг	7,753,341.2	3,588,706.4	3,581,706.5	6,999.9	539,139.4	2,719,411.9	1,159,591.5	1,461,737.7
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,116,082.3</b>	<b>3,754,923.4</b>	<b>2,588,923.4</b>	<b>1,166,000.0</b>	<b>1,361,158.9</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
1. Барилга байгууламж	3,197,409.7	3,163,161.7	2,120,778.4	1,042,383.3	34,248.0	0.0	0.0	0.0
2. Их засвар	153,180.5	113,180.5	100,443.9	12,736.6	40,000.0	0.0	0.0	0.0
3. Тоног төхөөрөмж	322,581.1	322,581.1	219,377.7	103,203.4	0.0	0.0	0.0	0.0
4. Бусад хөрөнгө	1,434,831.3	147,920.3	140,243.6	7,676.7	1,286,910.9	0.0	0.0	0.0
5. Стратегийн нөөц хөрөнгө	8,079.7	8,079.7	8,079.7	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-264,600.1</b>	<b>-30,100.1</b>	<b>-310,100.1</b>	<b>280,000.0</b>	<b>0.0</b>	<b>-98,100.0</b>	<b>-136,400.0</b>	<b>0.0</b>
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-544,600.1	-310,100.1	-310,100.1	0.0	0.0	-98,100.0	-136,400.0	0.0
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	280,000.0	280,000.0	0.0	280,000.0	0.0	0.0	0.0	0.0
<b>ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)</b>	<b>-2,387,079.4</b>	<b>-2,680,387.9</b>	<b>-1,296,387.9</b>	<b>-1,384,000.0</b>	<b>0.0</b>	<b>187,554.2</b>	<b>105,754.3</b>	<b>0.0</b>
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,387,079.4</b>	<b>2,680,387.9</b>	<b>1,296,387.9</b>	<b>1,384,000.0</b>	<b>0.0</b>	<b>-187,554.2</b>	<b>-105,754.3</b>	<b>0.0</b>
<b>1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт</b>	<b>-500,000.0</b>	<b>-206,691.5</b>	<b>-1,119,085.4</b>	<b>912,393.8</b>	<b>0.0</b>	<b>-187,554.2</b>	<b>-105,754.3</b>	<b>0.0</b>
<b>2. ЗГ-ын үнэт цаас</b>	<b>1,371,318.6</b>	<b>1,371,318.6</b>	<b>1,772,084.0</b>	<b>-400,765.4</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
2.1. Урт хугацаат	1,371,318.6	1,371,318.6	1,772,084.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
2.1.1. Дотоод	1,772,084.0	1,772,084.0	1,772,084.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.1.1. Шинээр гаргах	3,666,292.3	3,666,292.3	3,666,292.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.1.2. Үндсэн төлбөр	-1,894,208.3	-1,894,208.3	-1,894,208.3	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2. Гадаад	-400,765.4	-400,765.4	0.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
2.1.2.1. Шинээр гаргах	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.1.2.2. Үндсэн төлбөр	-400,765.4	-400,765.4	0.0	-400,765.4	0.0	0.0	0.0	0.0
<b>3. ЗГ-ын зээл</b>	<b>872,371.6</b>	<b>872,371.6</b>	<b>0.0</b>	<b>872,371.6</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
3.2. Гадаад	872,371.6	872,371.6	0.0	872,371.6	0.0	0.0	0.0	0.0
3.2.1. Төслийн зээл	579,371.6	579,371.6	0.0	579,371.6	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.1. Шинээр авах	1,384,000.0	1,384,000.0	0.0	1,384,000.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.1.2. Үндсэн төлбөр	-804,628.4	-804,628.4	0.0	-804,628.4	0.0	0.0	0.0	0.0
3.2.2. Хөтөлбөрийн зээл	293,000.0	293,000.0	0.0	293,000.0	0.0	0.0	0.0	0.0
3.2.2.1. Шинээр авах	293,000.0	293,000.0	0.0	293,000.0	0.0	0.0	0.0	0.0
<b>4. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл</b>	<b>643,389.3</b>	<b>643,389.3</b>	<b>643,389.3</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>
<b>5. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН</b>	<b>46,805,479.2</b>							

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ЭМДС	ОРОН НУТАГ
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>35.07</b>	<b>21.47</b>	<b>6.07</b>	<b>3.10</b>	<b>6.34</b>
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	<b>1.37</b>	<b>1.37</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>33.70</b>	<b>20.10</b>	<b>6.07</b>	<b>3.10</b>	<b>6.34</b>
<b>1. Татварын орлого</b>	<b>29.79</b>	<b>16.26</b>	<b>5.08</b>	<b>3.10</b>	<b>4.88</b>
1.1. Орлогын албан татвар	6.25	2.54	0.00	0.00	3.71
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	2.46	0.00	0.00	0.00	2.46
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	3.80	2.54	0.00	0.00	1.26
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.00	0.00	0.00	0.00	0.00
1.2. Нийгмийн даатгалын орлого	6.38	0.00	5.08	3.10	0.00
1.3. Хөрөнгийн албан татвар	0.46	0.00	0.00	0.00	0.46
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	7.35	7.35	0.00	0.00	0.00
1.5. Онцгой албан татвар	2.42	2.42	0.00	0.00	0.00
1.6. Тусгай зориулалтын орлого	0.04	0.04	0.00	0.00	0.00
1.7. Гаалийн албан татвар	2.31	2.31	0.00	0.00	0.00
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	4.57	1.60	0.00	0.00	0.71
<b>2. Татварын бус орлого</b>	<b>3.91</b>	<b>3.83</b>	<b>0.98</b>	<b>0.00</b>	<b>1.46</b>
2.1. Нийтлэг татварын бус орлого	3.27	2.09	0.00	0.00	0.42
2.2. Хөрөнгийн орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
2.3. Тусламжийн орлого	0.64	0.64	0.00	0.00	0.00
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	1.10	0.98	0.00	1.05
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>38.80</b>	<b>25.82</b>	<b>5.67</b>	<b>2.87</b>	<b>6.34</b>
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	<b>28.43</b>	<b>17.87</b>	<b>5.88</b>	<b>3.16</b>	<b>3.44</b>
<b>1. Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>8.69</b>	<b>6.30</b>	<b>0.07</b>	<b>0.54</b>	<b>2.07</b>
1.1. Цалин, хөлс	3.14	2.73	0.04	0.01	0.35
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.00	0.24	0.00	0.00	0.04
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	5.55	3.33	0.02	0.53	1.67
<b>2. Зээлийн үйлчилгээний төлбөр</b>	<b>2.05</b>	<b>2.05</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.10</b>
<b>3. Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>17.70</b>	<b>9.52</b>	<b>5.81</b>	<b>2.62</b>	<b>1.27</b>
3.1. Татаас	1.13	1.85	0.00	0.14	0.12
3.2. Урсгал шилжүүлэг	16.57	7.67	5.81	2.48	1.15
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>10.93</b>	<b>8.02</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>2.91</b>
1. Барилга байгууламж	6.83	6.76	0.00	0.00	0.07
2. Их засвар	0.33	0.24	0.00	0.00	0.09
3. Тоног төхөөрөмж	0.69	0.69	0.00	0.00	0.00
4. Бусад хөрөнгө	3.07	0.32	0.00	0.00	2.75
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.02	0.02	0.00	0.00	0.00
<b>В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>-0.57</b>	<b>-0.06</b>	<b>-0.21</b>	<b>-0.29</b>	<b>0.00</b>
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-1.16	-0.66	-0.21	-0.29	0.00
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.60	0.60	0.00	0.00	0.00
<b>ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)</b>	<b>-5.10</b>	<b>-5.73</b>	<b>0.40</b>	<b>0.23</b>	<b>0.00</b>
<b>ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН</b>	<b>46,805,479.2</b>	<b>46,805,479.2</b>	<b>46,805,479.2</b>	<b>46,805,479.2</b>	<b>46,805,479.2</b>

	/сая төгрөг/									/ДНБ-д эзлэх хувь/									
	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Төсөл	Зөрүү	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Төсөл	
	-1.	-2.	-3.	-4.	-5.	-6.	-7.	-8.	-9.	-8.	-1.	-2.	-3.	-4.	-5.	-6.	-7.	-8.	-9.
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	6,316,522.6	5,983,397.7	5,835,043.8	7,958,264.6	10,172,760.3	12,040,327.3	10,444,166.6	13,731,670.0	16,415,107.0	2,683,437.0	28.8	25.8	24.4	29.3	31.6	32.6	28.3	32.6	35.1
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	39,913.8	2,333.7	0.0	325,680.2	206,986.6	94,596.6	66,242.9	612,800.0	643,389.3	30,589.3	0.2	0.0	0.0	1.2	0.6	0.3	0.2	1.5	1.4
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	0.0	0.0	0.0	357,722.8	620,693.6	1,040,219.9	914,085.5	1,062,430.0	0.0	-1,062,430.0	0.0	0.0	0.0	1.3	1.9	2.8	2.5	2.5	0.0
<b>ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	6,276,608.8	5,981,064.0	5,835,043.8	7,274,861.6	9,345,080.1	10,905,510.8	9,463,838.2	12,056,440.0	15,771,717.7	3,715,277.7	28.6	25.8	24.4	26.8	29.1	29.6	25.6	28.6	33.7
<b>1. Татварын орлого</b>	5,157,024.5	5,118,979.4	4,950,950.2	6,315,131.9	8,227,776.1	9,813,195.8	8,511,605.1	10,625,916.3	13,941,329.3	13,941,329.3	23.5	22.1	20.7	23.2	25.6	26.6	23.0	25.2	29.8
1.1. Орлогын албан татвар	1,101,030.2	1,170,831.3	1,043,368.7	1,613,192.8	2,091,089.9	2,555,734.1	2,227,324.1	3,013,309.3	2,926,019.4	-87,289.9	5.0	5.1	4.4	5.9	6.5	6.9	6.0	7.2	6.3
1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	479,793.2	482,334.5	523,410.0	651,047.9	814,158.5	895,161.6	828,851.0	1,002,409.0	1,149,199.4	146,790.4	2.0	2.1	2.2	2.4	2.5	2.4	2.2	2.4	2.5
1.1.2 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	621,237.0	688,496.8	519,958.7	962,144.9	1,276,931.4	1,660,572.5	1,398,473.1	2,010,900.3	1,776,820.0	-234,080.3	2.8	3.0	2.2	3.5	4.0	4.5	3.8	4.8	3.8
1.1.3 Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	917,589.8	1,018,152.9	1,109,757.4	1,321,375.2	1,638,321.1	2,030,515.3	1,586,015.3	1,896,283.0	2,987,495.7	1,091,212.8	4.2	4.4	4.6	4.9	5.1	5.5	4.3	4.5	6.4
1.3. Хөрөнгийн албан татвар	50,109.4	86,610.1	104,659.9	131,129.6	141,225.4	154,369.1	154,878.6	175,714.0	213,444.0	37,730.0	0.2	0.4	0.4	0.5	0.4	0.4	0.4	0.4	0.5
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,371,725.4	1,049,588.7	1,140,721.4	1,618,492.1	2,195,907.2	2,486,268.1	2,208,953.7	2,804,000.0	3,441,800.0	637,800.0	6.3	4.5	4.8	6.0	6.8	6.7	6.0	6.7	7.4
1.5. Онцгой албан татвар	454,390.3	592,323.6	630,124.8	519,721.5	754,440.2	863,406.5	776,886.3	879,200.0	1,132,200.0	253,000.0	2.1	2.6	2.6	1.9	2.3	2.3	2.1	2.1	2.4
1.6. Тусгай зориулалтын орлого	39,862.8	11,791.8	10,767.4	12,386.6	13,063.7	16,355.0	17,071.7	15,000.0	17,200.0	2,200.0	0.2	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.7. Гаалийн албан татвар	355,328.9	320,594.9	328,490.6	512,351.2	682,218.2	790,178.4	740,742.4	935,030.0	1,081,912.0	146,882.0	1.6	1.4	1.4	1.9	2.1	2.1	2.0	2.2	2.3
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	866,987.9	869,086.2	583,060.0	586,482.8	711,510.3	916,369.2	799,733.0	907,380.0	2,141,258.2	1,233,878.2	4.0	3.8	2.4	2.2	2.2	2.5	2.2	2.2	4.6
<b>2. Татварын бус орлого</b>	1,119,584.3	862,084.7	884,093.5	959,729.8	1,117,304.0	1,092,315.9	1,140,523.7	1,430,523.7	1,830,388.4	399,864.7	5.1	3.7	3.7	3.5	3.5	3.0	2.6	3.4	3.9
2.1. Нийтлэг татварын бус орлого	1,094,468.1	753,507.1	805,424.9	896,708.4	1,027,675.0	1,003,117.3	784,979.7	1,279,823.5	1,531,698.5	251,875.0	5.0	3.3	3.4	3.3	3.2	2.7	2.1	3.0	3.3
2.2. Хөрөнгийн орлого	25,116.3	55,137.9	1,487.3	1,187.9	1,123.6	823.3	1,219.1	400.0	170.5	-229.5	0.1	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	0.0	53,439.6	77,181.3	61,833.5	88,505.4	88,374.4	166,034.4	150,300.2	298,519.4	148,219.2	0.0	0.2	0.3	0.2	0.3	0.2	0.4	0.4	0.6
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦӨВЭР ЭЗЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)</b>	7,144,568.0	7,137,973.9	9,495,332.9	9,017,318.6	9,317,220.8	11,661,700.9	13,904,273.0	15,748,277.1	18,158,792.2	2,410,520.1	32.6	30.8	39.8	33.2	29.0	31.6	37.6	37.4	38.8
<b>A. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	5,293,361.6	5,718,373.8	6,613,809.1	7,043,161.7	7,350,338.9	8,228,578.8	10,228,953.7	12,983,669.6	13,307,315.0	323,645.4	24.1	24.7	27.7	25.9	22.9	22.3	29.3	30.8	28.4
<b>1. Бараа, үйлчилгээний зардал</b>	2,652,480.8	2,801,673.1	3,133,289.2	3,141,432.3	3,327,510.9	4,000,463.5	4,851,187.0	4,751,390.6	4,065,707.7	-685,682.9	12.1	12.1	13.1	11.6	10.3	10.8	13.1	11.3	8.7
1.1. Цалин, хөлс	1,586,419.5	1,709,772.9	1,746,794.8	1,800,434.6	1,878,939.8	2,256,967.2	2,648,895.0	2,494,086.7	1,467,833.7	-1,026,253.0	7.2	7.4	7.3	6.6	5.8	6.1	7.2	5.9	3.1
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,066,061.3	1,091,900.2	1,386,494.4	1,340,997.7	1,448,571.1	1,743,496.3	2,202,292.1	2,257,304.0	2,597,874.0	340,570.0	4.9	4.7	5.8	4.9	4.5	4.7	6.0	5.4	5.6
<b>2. Эзэлийн үйлчилгээний төлбөр</b>	500,351.2	731,055.1	986,099.8	1,156,465.1	1,046,419.8	860,980.8	939,200.6	965,523.5	959,309.6	-6,213.6	2.3	3.2	4.1	4.3	3.3	2.3	2.5	2.3	2.0
<b>3. Татаас ба урсгал шилжүүлэг</b>	2,140,529.6	2,185,645.6	2,494,420.0	2,745,264.2	2,976,408.1	3,367,134.0	3,367,134.0	5,038,538.5	8,282,297.4	1,015,541.9	9.8	9.4	10.4	10.1	9.3	9.1	13.6	17.2	17.7
3.1. Татаас	167,195.4	101,482.0	229,325.3	260,619.2	230,028.7	298,900.8	375,070.7	401,504.3	528,956.2	127,451.9	0.8	0.4	1.0	1.0	0.7	0.8	1.0	1.0	1.1
3.2. Урсгал шилжүүлэг	1,973,334.2	2,084,163.5	2,265,094.8	2,484,645.0	2,746,379.4	3,068,233.2	4,663,467.8	8,665,251.1	7,753,341.2	888,090.0	9.0	9.0	9.5	9.1	8.5	8.3	12.6	16.3	16.6
<b>B. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,771,069.2	1,396,704.6	2,360,210.2	1,658,140.7	1,680,430.2	3,036,237.7	3,363,516.2	5,116,082.3	1,752,566.1	8.1	6.0	9.9	6.1	5.2	8.2	8.2	8.0	10.9	
1. Барилга байгууламж	1,505,934.2	614,548.4	1,576,950.9	1,121,662.4	1,094,604.5	2,256,789.2	2,071,989.3	1,857,701.0	3,197,409.7	1,339,708.7	6.9	2.7	6.6	4.1	3.4	6.1	5.6	4.4	6.8
2. Их засвар	91,874.8	110,773.2	129,004.7	66,992.7	89,888.4	161,465.2	144,987.8	100,023.3	153,180.5	53,157.2	0.4	0.5	0.5	0.2	0.3	0.4	0.4	0.2	0.3
3. Тонго төхөөрөмж	142,233.0	73,837.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	452,574.9	322,581.1	-129,993.8	0.6	0.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.1	0.7
4. Бусад хөрөнгө	12,836.1	136,065.3	401,482.3	469,485.7	495,937.3	598,237.8	817,258.8	937,787.3	1,434,831.3	497,044.0	0.1	0.6	1.7	1.7	1.5	1.6	2.2	2.2	3.1
5. Стратегийн нөөц хөрөнгө	18,191.1	27,829.7	0.0	0.0	0.0	0.0	0.0	15,429.7	8,079.7	-7,350.0	0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	433,650.6	252,772.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.9	1.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>B. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦӨВЭР ЭЗЭЛ</b>	80,137.1	22,895.4	521,313.6	316,016.2	286,451.7	416,449.8	411,110.9	-598,908.7	-264,600.1	334,308.5	0.4	0.1	2.2	1.2	0.9	1.1	-1.4	-0.6	-0.6
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	10,715.4	-17,588.9	487,553.2	200,817.3	179,613.3	278,639.7	-119,522.0	-749,908.7	-544,600.1	205,308.5	0.0	-0.1	2.0	0.7	0.6	0.8	-0.3	-1.8	-1.2
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	69,421.7	40,484.3	33,760.4	115,198.9	106,838.4	137,810.1	160,632.9	151,000.0	280,000.0	129,000.0	0.3	0.2	0.1	0.4	0.3	0.4	0.4	0.4	0.6
<b>ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)</b>	-867,959.1	-1,156,909.8	-3,660,289.1	-1,742,456.9	-27,859.3	-756,190.0	-4,440,434.8	-3,691,837.1	-2,387,079.4	1,304,757.7	-4.0	-5.0	-15.3	-6.4	0.1	-2.0	-12.0	-8.8	-5.1
<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	867,959.1	1,156,909.8	3,660,289.1	1,742,456.9	27,859.3	756,190.0	4,440,434.8	3,691,837.1	2,387,079.4	-1,304,757.7	4.0	5.0	15.3	6.4	-0.1	2.0	12.0	8.8	5.1
<b>1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт</b>	144,034.6	-43,861.0	-112,351.4	-1,013,222.2	911,446.9	-1,103,376.9	1,868,413.0	123,038.6	-500,000.0	-623,036.8	0.7	-0.2	-0.5	-3.7	2.8	-3.0	5.1	0.3	-1.1
<b>2. ЗГ-ын үнэт цаас</b>	1,050,847.8	681,425.7	3,332,685.0	206,613.0	-2,434,728.6	-165,105.9	-249,393.2	2,258,612.6	1,371,318.6	-887,294.0	4.8	2.9	14.0	0.8	-7.6	-0.4	-0.7	5.4	2.9
2.1. Урт хугацаат	1,051,821.4	681,799.6	3,332,756.2	206,925.8	-2,434,728.6	-165,105.9	-249,393.2	2,258,612.6	1,371,318.6	-887,294.0	4.8	2.9	14.0	0.8	-7.6	-0.4	-0.7	5.4	2.9
2.1.1. Дотоод	1,051,821.4	366,870.5	2,311,511.2	-2,305,397.6	-1,767,698.0	-165,105.9	-263,004.6	2,636,380.0	1,772,084.0	-864,295.9	4.8	1.6	9.7	-8.5	-5.5	-0.4	-0.7	6.3	3.8
2.1.1.1. Шинээр гаргах	1,527,906.6	1,359,201.8	3,754,214.2	1,759,934.2	0.0	0.0	0.0	0.0	3,666,292.3	813,917.2	7.0	5.9	15.7	6.5	0.0	0.0	0.0	6.8	7.8
2.1.1.2. Үндсэн төлбөр	-476,085.2	-992,331.3	-1,300,415.2	-3,065,331.8	-1,767,698.0	-165,105.9	-263,004.6	-215,995.2	-1,894,208.3	-1,678,213.1	-2.2	-4.3	-5.4	-11.3	-5.5				



	/сая төгрөг/										/ДНБ-д эзлэх хувь/									
	2014		2015		2016		2017		2018		2019		2020		2021		2022			
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Төсөл	Зөрүү	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Тод	Төсөл	
	-1.	-2.	-3.	-4.	-5.	-6.	-7.	-8.	-9.	-8.	-8.	-1.	-2.	-3.	-4.	-5.	-6.	-7.	-8.	-9.
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	4,244,274.3	3,834,039.9	3,894,443.3	5,857,085.6	7,656,054.2	9,112,417.3	7,809,354.7	10,767,008.2	10,049,997.7	-717,010.5		19.3	16.5	16.3	21.6	23.8	24.7	21.1	25.6	21.5
<b>ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН</b>	39,913.8	2,333.7	0.0	325,680.2	206,986.6	94,596.6	66,242.9	612,800.0	643,389.3	30,589.3		0.2	0.0	0.0	1.2	0.6	0.3	0.2	1.5	1.4
<b>ИРЭЭДҮЙН ӨВ САН</b>	0.0	0.0	0.0	357,722.8	620,693.6	1,040,219.9	914,085.5	1,062,430.0	0.0	-1,062,430.0		0.0	0.0	0.0	1.3	1.9	2.8	2.5	2.5	0.0
<b>ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	4,204,360.5	3,831,706.2	3,894,443.3	5,173,682.6	6,828,374.0	7,977,600.9	6,829,625.3	9,091,778.2	8,406,608.4	314,830.2		19.2	16.5	16.3	19.0	21.2	21.6	18.5	21.6	20.1
<b>1. Татварын орлого</b>	3,119,620.7	2,943,409.5	2,854,078.6	3,987,205.3	5,430,635.3	6,493,488.8	5,690,102.6	7,612,407.3	7,612,407.3	358,186.9		14.2	12.7	11.9	14.7	16.9	17.6	15.4	17.2	16.3
1.1. Орлогын албан татвар	621,237.0	688,496.8	519,958.7	962,144.9	1,276,931.4	1,660,572.5	1,398,473.1	2,010,900.3	1,188,630.0	-822,270.3		2.8	3.0	2.2	3.5	4.0	4.5	3.8	4.8	2.5
1.1.1. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	621,237.0	688,496.8	519,958.7	962,144.9	1,276,931.4	1,660,572.5	1,398,473.1	2,010,900.3	1,188,630.0	-822,270.3		2.8	3.0	2.2	3.5	4.0	4.5	3.8	4.8	2.5
1.2. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,371,725.4	1,049,588.7	1,140,721.4	1,618,492.1	2,195,907.2	2,486,268.1	2,208,953.7	2,804,000.0	3,441,800.0	637,800.0		6.3	4.5	4.8	6.0	6.8	6.7	6.0	6.7	7.4
1.3. Онцгой албан татвар	454,390.3	592,323.6	630,124.8	519,721.5	754,440.2	863,406.5	776,886.3	879,200.0	1,132,200.0	253,000.0		2.1	2.6	2.6	1.9	2.3	2.3	2.1	2.1	2.4
1.4. Тусгай зориулалтын орлого	11,574.1	11,791.8	10,767.4	12,386.6	13,063.7	16,355.0	17,071.7	15,000.0	17,200.0	2,200.0		0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
1.5. Гаалийн албан татвар	355,328.9	320,594.9	328,490.6	512,351.2	682,218.2	790,178.4	740,742.4	935,030.0	1,081,912.0	146,882.0		1.6	1.4	1.4	1.9	2.1	2.1	2.0	2.2	2.3
1.6. Бусад татвар (төлбөр, хураамж)	305,365.0	280,613.7	224,015.6	362,109.0	508,074.6	676,708.3	547,975.4	610,090.0	750,665.3	140,575.3		1.4	1.2	0.9	1.3	1.6	1.8	1.5	1.4	1.6
<b>2. Татварын бус орлого</b>	1,084,739.8	888,296.7	1,040,364.8	1,186,477.3	1,397,738.7	1,484,111.9	1,138,923.7	1,837,557.9	1,794,201.2	-43,356.7		4.9	3.8	4.4	4.4	4.3	4.0	3.1	4.4	3.8
2.1. Нийтлэг татварын бус орлого	891,737.3	669,123.9	702,241.3	738,043.5	810,845.1	793,784.6	587,867.6	1,137,476.8	979,540.4	-157,936.4		4.1	2.9	2.9	2.7	2.5	2.2	1.6	2.7	2.1
2.2. Хөрөнгийн орлого	11,340.9	15,769.6	253.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		0.1	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
2.3. Тусламжийн орлого	181,661.5	203,403.2	337,869.7	448,433.8	586,893.5	690,327.4	551,056.1	150,300.2	298,519.4	148,219.2		0.8	0.9	1.4	1.7	1.8	1.9	1.5	0.4	0.6
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	549,780.9	516,141.4	-33,639.5		0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.3
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮҮЛСЭН)</b>	5,229,168.5	4,996,886.5	7,394,235.5	7,139,637.5	7,181,902.8	9,295,080.0	10,735,610.8	12,568,721.8	12,086,996.3	-481,725.5		23.8	21.6	31.0	26.3	22.3	25.2	29.0	29.8	25.8
<b>А. УРСГАЛ ЗАРЛАГА</b>	3,910,233.6	4,025,377.1	4,993,050.2	5,524,236.3	5,713,529.9	6,353,474.8	8,224,821.9	10,256,942.6	8,362,173.1	-1,894,769.6		17.8	17.4	20.9	20.3	17.8	17.2	22.3	24.3	17.9
<b>1. Бараа, үйлчилгээний зардал</b>	1,536,021.5	1,639,580.1	1,951,062.5	1,901,793.0	1,993,675.7	2,359,460.4	2,921,888.1	2,947,914.7	2,947,914.7	154,987.7		7.0	7.1	8.2	7.0	6.2	6.4	7.9	6.6	6.3
1.1. Цалин, хөлс	866,078.0	948,067.1	968,555.0	1,004,717.0	1,034,179.5	1,206,361.9	1,400,136.8	1,259,054.5	1,278,792.2	19,876.6		3.9	4.1	4.1	3.7	3.2	3.3	3.8	3.0	2.7
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	68,766.1	74,660.3	74,635.2	76,684.2	84,174.9	103,461.6	122,748.4	106,764.6	4,205.3	0.0		0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.2
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	601,177.4	616,852.7	907,872.3	820,391.8	875,321.4	1,049,637.0	1,399,002.9	1,427,145.6	1,558,140.4	130,994.8		2.7	2.7	3.8	3.0	2.7	2.8	3.8	3.4	3.3
<b>2. Эзэлийн үйлчилгээний төлбөр</b>	438,326.3	663,721.1	926,331.7	1,156,465.1	1,046,419.8	860,980.8	932,819.9	965,525.3	959,309.9	-6,213.6		2.0	2.9	3.9	4.3	3.3	2.3	2.5	2.3	2.0
<b>3. Татаас ба урсгал шилжүүлэг</b>	1,935,885.8	1,722,076.0	2,115,656.0	2,465,978.1	2,673,434.4	3,133,033.6	4,370,113.8	6,498,504.4	4,454,967.8	-2,043,543.7		8.8	7.4	8.9	9.1	8.3	8.5	11.8	15.4	9.5
3.1. Татаас	403,995.4	368,900.6	571,958.8	647,766.9	698,745.0	705,770.0	564,733.4	844,632.2	866,254.3	21,622.1		1.8	1.6	2.4	2.4	2.2	1.9	1.5	2.0	1.9
3.2. Урсгал шилжүүлэг	1,531,890.4	1,353,175.4	1,543,697.2	1,818,211.3	1,974,689.4	2,427,263.5	3,805,380.4	5,653,872.2	3,588,706.4	-2,065,165.7		7.0	5.8	6.5	6.7	6.1	6.6	10.3	13.4	7.7
<b>Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	1,238,797.7	950,712.4	1,893,336.7	1,322,440.6	1,206,425.1	2,548,153.6	2,487,461.9	2,670,551.8	3,754,923.4	1,084,371.6		5.6	4.1	7.9	4.9	3.8	6.9	6.7	6.3	8.0
1. Барилга байгууламж	923,523.6	387,221.8	1,319,987.8	929,940.3	820,222.0	2,059,785.6	1,847,721.5	1,816,701.0	3,163,161.7	1,346,460.7		4.2	1.7	5.5	3.4	2.5	5.6	5.0	4.3	6.8
